



Монгол Улс
Хэвлэл мэдээллийн эрх зүйн
үндсэн асуудал
Сургалтын гарын авлага

2014 оны 11 дүгээр сар

Агуулга

ТАНИЛЦУУЛГА

МОДУЛЬ 1: ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ

1. Олон улсын хууль
2. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө
3. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтууд

Ашигласан материал

МОДУЛЬ 2: ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

1. Агуулгын дүрэм журам
2. Мэдээллийн эрх чөлөө
3. Хэвлэл мэдээллийн зохицуулалт

Ашигласан материал

МОДУЛЬ 3: ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

1. Ерөнхий асуудал

Ашигласан материал

МОДУЛЬ 4: НЭР ТӨР ГУТААХ

1. Ухагдахууны тодорхойлолт ба хамрах хүрээ
2. Өмгөөлөх
3. Шийтгэл ногдуулах
4. Нэр төр гутаасан үйлдлийг өмгөөлөх

МОДУЛЬ 5: МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ

1. Мэдээллийн ашиг тусын талаар
2. Гол зарчмууд

Ашигласан материал

МОДУЛЬ 6: ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ, ИНТЕРНЕТИЙН ЗОХИЦУУЛАЛТ

1. Зохицуулах байгууллага
2. Тусгай зөвшөөрөл олгох процесс
3. Олон талт байдлыг хөхиүлэн дэмжих нь
4. Агуулгын хяналт
5. Интернэтийн зохицуулалт

Ашигласан материал

ТАЛАРХАЛ

Энэхүү гарын авлагыг Эрх зүй, ардчилал төвийн гүйцэтгэх захирал Тоби Мендел эмхтгэв. Тус гарын авлагыг Дойче Велле Академийн дэмжлэгтэйгээр боловсруулав.

ТАНИЛЦУУЛГА

Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг үндсэн суурь эрх чөлөө гэдгийг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрдөг. Энэ нь өөрөө маш чухал эрх төдийгүй, бусад бүх эрхийг хүндэтгэх үндэс суурийг тавьж өгдөг. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хүндэтгэхэд гадны халдлагад өртөх, бүхий л эрхүүд эрсдэлд орох нь бий. Бусад бүх эрхийн хамгаалалтыг баталгаажуулах үүргээ гүйцэтгэсний үр дүнд, чухамдаа ардчилал өөрөө үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бол хүний эрхийн суурь, язгуур мөн хэмээн өргөн хүрээнд хүлээн зөвшөөрдөг.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг олон улсын болон үндсэн хуулиар баталгаажуулахдаа цөөн хэдэн өгүүлбэрт багтаан гол мөн чанарыг нь товч тодорхойлдог. Гэхдээ энэ эрх нь өөрөө цогц бүрдэл шинжтэй. Үүний нэг тал нь, нийтийн болон хувийн ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд авч үзэн хамгаалахын тулд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тавьж болохыг улс орнуудад олон улсын хуулиар зөвшөөрсөн. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь улс орнуудын хувьд зөрчихөөс татгалзах ёстой гэсэн утгаараа эерэг эрх, төдийгүй нийгэм дэх мэдээлэл, үзэл санааны чөлөөт урсгалыг дэмжин баталгаажуулсны эерэг хэмжүүр үзүүлэлт болдог. Эцэст нь, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь ярьж буй хүнийг төдийгүй, мөн сонсогчийг хамгаалж, хэвлэл мэдээллийн олон төрөлт байдлыг хөхиүлэн дэмжих үндсэн хэмжүүр болж байдаг юм.

Хэвлэл мэдээллийн эрх зүйн асуудлаар явуулах энэхүү сургалтын гарын авлага нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон хэвлэл мэдээллийн эрх зүйн гол гол асуудлуудыг хөндсөн хичээлийн хүрээнд боловсруулагдсан. Энэ гарын авлагад Монгол улсын хувьд сонирхож буй асуудлуудад гол анхаарлаа хандуулж, олон улсын хуулиар хамгаалагдсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн үндсэн утга, ойлголтыг тоймлон харуулсан болно. Энэхүү гарын авлагыг анхлан сургалтад ашиглахаар бүтээсэн боловч, цаашид мөн лавлагаа мэдээлэл болгон ашиглах боломжтой.

Энэ гарын авлага нь зургаан модульд хуваагдах ба модуль бүр нь олон улсын стандартад анхаарлаа хандуулсан, сургалтын үеэр заах хичээлүүдэд нийцсэн байна. Эхний модуль - Олон улсын стандарт. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний олон улсын болон үндсэн хуулийн баталгааг дурдсан. Мөн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө яагаад хэрэгтэй юм, түүний үндсэн гол шинж чанарууд, хязгаарлалтын шалгуурын асуудлууд багтана. Хоёр дахь модульд хэвлэл мэдээллийн зохицуулалтын эрх зүйн хүрээний бүхий л гол мэдээллүүдийг багтаасан. Оролцогчдод эдгээр өөр өөр зохицуулалтын тогтолцооны хоорондын ялгааг мэдрүүлж ойлгуулахыг зорьсон.

Гурав дахь модуль –Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт хэсэгт өөрийн зохицуулалтын тогтолцоо хэрхэн ажилладаг, түүний үндсэн элементүүд, эрх зүйн зохицуулалтын тогтолцоотойгоо харилцан нөлөөлөх, үйлчлэх арга замуудын тухай мэдээлэл багтсан. Дөрөв дэх модуль – Нэр төр гутаах. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүндэтгэх үүднээс нэр хүндийн хамгаалалтыг хэрхэн тэнцвэржүүлэх вэ гэсэн нарийн төвөгтэй цогц асуудлыг авч хэлэлцэх юм. Тав дахь модуль - Мэдээлэл олж авах. Энэ хэсэгт төрийн байгууллагаас мэдээлэл олж авах эрхийг хүлээн зөвшөөрсөн дотоодын хууль ба олон улсын стандартыг ярилцана. Энэхүү эрхийн үр шим нь юу вэ, хуулийн бүтэц, зохицуулалт хэрхэн хийгдсэн гэдэгт анхаарна. Төгсгөлийн зургаа дахь модуль нь өргөн нэвтрүүлгийн болон интернэтийн зохицуулалт байна. Өргөн нэвтрүүлэг, интернетийн зохицуулалтын гол хандлагуудын талаар ерөнхийд нь тоймлосон. Зохицуулагчийн хараат бус байдлыг баталгаажуулах, эдгээр үндсэн салбаруудын олон талт байдлыг хэрхэн баталгаажуулах зэрэг асуудлуудыг энд багтаан оруулав.

Модуль 1: Олон улсын хэм хэмжээ

Хэлэлцүүлэг: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө гэдэг нэр томъёо танд юу бодогдуулж байна вэ? Энэхүү эрхийн өвөрмөц онцлог шинж нь юу вэ? Хүний эрхийн ямар ойлголт вэ? Үүнийг чухал эрх гэж та хэлэх үү? Яагаад тийм, эсвэл үгүй вэ?

1. Олон улсын хууль

- Эцсийн дүндээ ямар нэгэн зүйлийг хүний эрх гэж хэлэхэд олон улсын хууль (болон үндэсний хууль тогтоомжоор) баталгаажсан байна гэсэн агуулгатай.
- Улс орнууд олон улсын хуулийг бий болгодог. Энэ нь эерэг, сөрөг талын аль аль нь байж болно.
 - Эерэг тал нь төрд үүнийг няцаах эсвэл үүнийг заавал биелүүлэх үүрэггүй гэж хэлэхэд төвөгтэй болгох
 - Сөрөг тал нь хүний эрхийг (үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудал биш гэж бидний ойлгож байгаа шиг) хатуу баталгаажуулахыг хүлээн зөвшөөрөх нь улс орнуудыг бид байнга олж чадахгүй.
- “Зөөлөн хэм хэмжээ” гэж нэрлэдэг маш олон жишээнүүд мөн бий.
 - Тунхаглал, зөвлөмж, тогтоол шийдвэр, эрх бүхий этгээдийн мэдэгдэл
 - Эдгээр нь заавал биелэгдэх хүчин чадалтай биш хэдий ч олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн нэр нөлөө бүхий итгэл хүлээхүйц арга замаар нарийн судалж боловсруулагдсан байдаг.
 - Жишээ нь, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх Тусгай илтгэгчдийн хамтарсан тунхаглал, эсвэл Европын Зөвлөлийн Сайд нарын хорооны зөвлөмж гэх мэт.
- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үндсэн баталгаажуулалт
 - *Хүний эрхийн түгээмэл тунхаглал*
 - Статус: уламжлалт/ энгийн олон улсын хэм хэмжээ (НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол)
 - *Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ICCPR)*: Монгол улс 1974 онд нэгдэн орсон, хууль ёсоор дагаж мөрдөх үүрэг хүлээсэн
 - Бүс нутгийн гэрээ: Европ, Африк, Латин Америк, Ази орохгүй

2. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө

Хүний эрхийн мөн чанар

- Уламжлал ёсоор, олон улсын хуулийг улс орнуудын хооронд мөрдөх бөгөөд тухайн улсын хэмжээнд хувь хүний эрхэнд нөлөөлдөггүй.
 - Жишээлбэл, дайны тухай хуулиар улс орнуудад үүссэн дайны нөхцөл байдлыг зохицуулахаас бус дайны талбар дээр хувь хүнтэй хэрхэн харьцахыг авч үзэхгүй. Тэр байтугай, хувь хүний асуудлын талаарх тогтоол шийдвэр байсан ч, жишээлбэл, дайны дараа олзлогсдыг эх оронд нь буцаах зэрэг асуудал нь хувь хүний эрх гэхээсээ илүүтэйгээр тухайн улсын өөрийн орны иргэдийг эх оронд нь буцаах эрх юм.
- Женевийн Конвенцийн 1864 оны эх хувь, дайны талбарт байгаа шархтануудтай харьцах тухай, хувь хүний эрхийн талаарх хамгийн анхны гэрээ бөгөөд дараа дараачийн Женевийн Конвентүүд үүн дээр боловсруулагдсан. Эдгээр гэрээ нь хувь хүнтэй харьцахад чиглэгдсэн боловч бусад улс орны иргэдийг бас анхаарч үзсэн.
- Дэлхийн хоёрдугаар дайны дараа улс орнууд гагцхүү хүн болохынхоо хувьд бүгд салшгүй тодорхой шинж чанар эзэмших, өөрөөр хэлбэл эрхээ эдлэхэд үндэслэн өөрийн

орны иргэдтэй харьцах хэр хэмжээ байдаг талаар хүлээн зөвшөөрсөн. Өдгөө энэ нь ердийн зүйл боловч тухайн үедээ цоо шинэ үзэл санаа байв.

- Гэсэн хэдий ч хүний эрхийн зарим чухал хэр хэмжээ бий. Үүнд:
 - Гагцхүү олон улсын хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн бол хүний эрхийн тодорхой төрөлд тооцогдоно. Хэн нэгэн этгээд ямарваа нэгэн зүйлийг хүний эрх хэмээн зарлах боломжгүй. Тухайлбал, баян байх эрх, эсвэл эрүүл байх, эрх тэгш байх эрх гэж үгүй боловч зохистой хөдөлмөр эрхлэх, эрүүл мэндээ хамгаалуулах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, эрх чөлөө гэж бий.
 - Хүний эрх нь тухайн улсад үүрэг хүлээлгэдэг, өөрөөр хэлбэл хувь хүнд хувийн этгээдээс бус төрөөс эдлүүлдэг эрх юм. Өөрөөр хэлбэл, хүний эрхийг хангах үүрэг улсад ногддог. Олон улсын хууль нь эдгээр үүргийн нэг хэсэг бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө үүнд хамаарна.
 - Иймээс, эцэг хүн хүүдээ хооллох үеэр ярихыг хориглох нь хүний эрхийн асуудал биш юм. Учир нь тэр эцэг төрийг төлөөлөхгүй. Харин улсын сургуулийн багш хүн сурагчдаа ярихыг зөвшөөрөхгүй байгаа явдал нь хүний эрхийн асуудал болно (үүнийг заавал хүний эрхийн зөрчил гэж үзэж болохгүй, учир нь тэр багшийн үйлдлийг зөвтгөх магадлал бас бий)
- Төр нь түүний эрх мэдэл дор буюу түүгээр дамжуулан үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн, үндэсний, эрх зүйн, гүйцэтгэх, шүүхийн болон төрийн байгууллагын өмнөөс үйл ажиллагаа явуулж буй хувийн бүх байгууллага, нэгжийг хамарна.

Хэлэлцүүлэг: Хүний эрхийг хамгаалах, хүндэтгэн сахих үүргийг улсад/төрд ногдуулна гэдэг үзэл санаа Танд ердийн эсвэл бага зэрэг идеалист санагдаж байна уу? Төрийн хүлээх эдгээр үүргийн бусад хэсгийн талаар юу гэж бодож байна?

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрх зүйн тодорхойлолт

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ИБУТЭТОУП)-ын 19 дүгээр зүйл:

2. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл:

Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;

17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална

Хэлэлцүүлэг: Дээрх баталгаануудын хооронд ялгаа бий юу? Эдгээр ялгаа нь илэрхий байна уу? Бодит амьдрал дээр эдгээр баталгаа нь аливаа өөрчлөлт авчрах уу? Үндсэн хуулийн баталгаа нь таны хүсч байгаагаас үр нөлөө багатай байгаа талаар жишээ байна уу?

ИБУТЭТОУП-аар баталгаажуулсан үзэл бодлоо илэрхийлэх эрхийн 7 гол шинж чанар:

1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь эерэг болон сөрөг талтай:
 - Бид юуны өмнө үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг сөрөг эрх хэмээн тооцно, энэ нь төрийг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хөндлөнгөөс оролцохоос сэргийлнэ.
 - *Жишээ:* Төр нь таны бусад хүмүүсийг хэрхэн шүүмжилж болохыг хязгаарласан хууль баталдаг (жишээ нь, гүтгэлэгийн тухай хууль). Сонины үйл ажиллагаа эрхлэхэд төрөөс таныг бүртгэлд хамрагдахыг шаарддаг.
 - Гэсэн хэдий ч олон улсын хуулиар, энэ нь мөн эерэг элемент агуулна. Үүнд, төр нь нийгэмд мэдээлэл, үзэл санааны чөлөөт урсгалыг хангахын тулд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстой.
 - *Жишээ:* өргөн нэвтрүүлэгчдийн олон талт байдлыг хангасан хууль батлах, сэтгүүлчдийн эсрэг халдлагаас урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, мэдээлэл авах эрхийн тухай хууль батлах г.м.
2. Хүн бүр эрх эдэлнэ.
 - *Жишээ:* гадаад хүмүүс, хоригдогсод болон хүүхдүүд эрхийнхээ дагуу хамгаалагдана, зарим тохиолдолд бусад шалтгааны улмаас үзэл бодлоо илэрхийлэх эрхийг адил хэмжээнд эдлэх боломжгүй (жишээ нь, хоригдогсод зан байдлаасаа үүдэн зарим эрхээ, тухайлбал чөлөөтэй зорчих эрхээ эдэлж чадахгүй байгаа байдлыг хүлээн зөвшөөрдөг).
3. Энэ эрх үг хэлэх эрхээс давж, **хайх, хүлээн авах** (түүний дотор сонсох, эрэн сурвалжлах) эрхийг багтаана.
 - a. Олон улсын хууль нь мэдээлэл, үзэл санааг дамжуулах эрхийг хамгаалаад зогсохгүй, мөн түүнчлэн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хамгаалдаг.
 - b. Энэ эрх ардчиллын үндэс болдог учраас зарим талаар, эрхийн нэлээн чухал хэлбэрт тооцогдоно. Таны хувьд, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө унших, сонсох, мөн ярихаас илүүтэйгээр үзэж харах, ажиглах (түүний дотор, яг одоо хийж буй үйлдэл чинь) хэлбэрээр хавьгүй олон удаа эдэлдэг.
 - *Жишээ:* төрөөс сонины үйл ажиллагааг зогсоож буй үйлдэл нь сэтгүүлчийн үгээ хэлэх эрхэнд халдаад зогсохгүй, мөн түүнчлэн сонины уншигчдын мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг зөрчиж буй явдал юм. *Мавлонов, Сайди нар Узбекистаны эсрэг.*
 - Хүн бүр төрийн байгууллагаас мэдээлэл хүсэх, хүлээн авах эрхтэй, (мэдээллийн эрх бол уг эрхийн эерэг тал, мөн хайх, хүлээн авах эрхийн нэг хэлбэр).
4. Уг эрхэд хэр зэрэг чухал байхаас үл хамаарч, зөв буруу аль нь ч бай, тэр байтугай олонх хүмүүс доромжлол гэж тооцохыг үл харгалзан **бүхий л төрлийн мэдээлэл, үзэл санаа** хамаарна,
 - *Жишээ:* хошин шог зураг, зар сурталчилгаа, арилжааны мэдээлэл, мөн ташаа мэдээлэл хүртэл уг эрхэд хамаарна; олонд алдаршаагүй, эрүүл бус шинжтэй үзэл санаа хүртэл хамгаалагдана. Гэвч орон нутгийн засаг захиргаанаас иргэдийг байшингаа ногооноор будахыг хориглох нь байж болох асуудал. Учир нь танай байшингийн өнгө нь илэрхийлэх үйлдэл үзүүлэхгүй (энэ нь таны бусадтай харилцаж буй хэлбэр бус, та зөвхөн уг өнгийг таашааж буй явдал юм)

5. Хил хязгаарыг үл харгалзан уг эрхийг эдэлнэ. Үүнийг ИБУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлд тодорхой заасан. Энэ эрхийг эдлэхэд улсын хил хязгаар хорио саад болохгүй.
- *Жишээ:* та бусад улс орноос сонин хэвлэл импортлох эрхтэй, төрөөс интернэтийг хаах, түүнд шүүлтүүр хэрэглэж огтоос болохгүй.
6. Үүнд үзэл санааны илэрхийлэл бүхий ямар ч төрлийн агуулгыг уламжлалт, орчин үеийн аль ч аргаар түгээх эрх багтана. Энэ эрхийг нь “өөрийн сонгосон бусад аргаар ... түгээх” хэмээн ИБУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлд тодорхойлжээ..
- *Жишээ:* сонин, сэтгүүл, ном товхимол, радио, телевиз, интернэт, гар утас, олон нийтийн цуглаан, айл өрхөөр явж ухуулга хийх, уран зураг, уран баримал, шог зураг, тамхины утаагаар дохих, Морзын дохио, нүүр тулсан ярилцлага, зарим тохиолдолд хувцасны хэв маяг, загвар
7. Төрөөс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг шууд, шууд бусаар хязгаарлах аливаа үйлдэл нь өнгөц харахад хөндлөнгийн оролцоо гэж болохоор. Төрөөс үзэл бодлын эрх чөлөөг хязгаарлаж болох хууль батлах, хэрэгжүүлэх аргаас гадна шууд бус аргаар хязгаарлаж болдог.
- *Жишээ:* түгээмэл хэрэглэдэггүй үзэл бодлын илэрхийлэл бүхий агуулгад онцгой татвар ногдуулах, засгийн газар өөрийг нь шүүмжилсэн агуулга бүхий сурталчилгааг сонинд нийтлүүлэхээс татгалзах
 - Хүний эрхийн тухай Америк тивийн орнуудын конвенцийн 13.3 дугаар зүйлд зааснаар: “Үзэл бодлын эрхийг засгийн газар эрх мэдлээ урвуулан ашиглан, албан бус аргаар сонин хэвлэл, радио, өргөн нэвтрүүлгийн давтамж, мэдээлэл түгээх тоног төхөөрөмж зэргийг хянах, харилцаа холбоо, үзэл санаа, үзэл бодол түгээн дэлгэрүүлэхэд саад болохуйц аливаа бусад шууд бус арга, хэлбэрээр хязгаарлаж болохгүй.”

Дасгал 1: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хамрах хүрээ

3. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтууд

- Үзэл бодлоо илэрхийлэх үйлдэл бүгд хууль ёсных бус хэмээн нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг. Бусдыг гэмт хэрэгт турхирах, бусдын хувийн амьдралыг илчлэх, төрийн нууцыг худалдах, худал, гүжирдлэгийн шинж чанартай мэдээлэл өгөх зэрэг үйлдэлд төрөөс хориг саад тавих нь хууль ёсны гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрнө.
- Гэвч энэ нь төр хүссэнээрээ үзэл бодлын эрх чөлөөг хязгаарлана гэсэн үг биш. Ингэх нь уг эрхийн олон улсын хамгаалалтыг ач холбогдолгүй болгох магадлалтай. Учир нь засгийн газар бүр үзэл бодлын эрх чөлөөг ямар нэг байдлаар хязгаарлаж болох ба уг эрх нь ямар ч ач холбогдолгүй болно.
- Олон улсын хуулийн дагуу үзэл бодлын эрх чөлөөний, өнгөц харахад хэт өргөн хүрээний баталгаажилт, хүмүүс хоорондын харилцаа холбоо, үзэл санааны аливаа хэлбэр, түүн дотроо дээр дурдагдсан жишээ, өөрөөр хэлбэл аливаа санааг илэрхийлэхүйц ямар ч төрлийн үйл ажиллагаа, ямар хэлбэрээр явагдах нь хамаагүй, хамгаалагдсан байна.
- Гэсэн хэдий ч, улс орнуудад зарим төрлийн илэрхийллийн үйл ажиллагааг зохицуулах хууль ёсны шаардлага тулгарахыг хүлээн зөвшөөрдөг, мөн чанар (гүтгэлэг, доромжлол, үзэн ядалтаас үүдсэн үг хэллэг), өрнөж буй аргын аль алинаас шалтгаалах (олон нийтийн долгионыг ашиглан өргөн нэвтрүүлэх). Ингэснээр төр зарим тохиолдолд үзэл бодлын эрх чөлөөг хязгаарлах, зохицуулах боломж олгоно.
- Олон улсын хууль нь нэг чухал зүйлээс бусдаар, улс орноос үзэл бодлын эрх чөлөөг зохицуулах, хязгаарлахыг шаарддаггүй, зөвхөн ингэхийг зөвшөөрдөг гэдгийг анхаарна уу. Энэ зүйл нь ИБУТЭТОУП-ын 20(2) дугаар зүйлийн дагуу хязгаарлах шаардлагатай үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэг (бид эргээд энэ талаар ярилцана)
- Уг эрхийн цөмийг хүндэтгэн сахих явдлыг хангах, мөн төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахаас сэргийлэхийн тулд, олон улсын хуулиар үзэл бодлын эрх чөлөөний аливаа хязгаарлалт нийцэж байх хатуу хэмжүүр тогтоосон.

Хэлэлцүүлэг: Ямар төрлийн үг хэлэхийг хязгаарлах шаардлагатай гэж та бодож байна? Эдгээр хязгаарлалт нь үзэл бодлын эрх чөлөөний цөмийг сааруулахгүй байхад бид хэрхэн эргэлзэхгүй байж чадах вэ? Өөрөөр хэлбэл, төрийн эрх мэдэлд үзэл бодлын хязгаарлалт хийх ямар нөхцөл тавьж болох вэ?

- ИБУТЭТОУП-ын 19(3) дугаар зүйлээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтад хууль ёсны хэмжүүр тогтоосон:

Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой:

- (а) бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;
- (b) үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах

- Энэ нь хязгаарлалтад 3 талт хатуу шалгуур тогтоосон нь. Үүнд:
 - a. Хуулиар тогтоогдсон байх
 - b. (a) болон (b) заалтанд тусгагдсан эрх ашгийн аль нэгийг хамгаалах зорилгоор
 - c. Эрх ашиг хамгаалах шаардлагаас үүдэн гарах

Хуулиар тогтоогдсон байх

Хэлэлцүүлэг: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ямар төрлийн хязгаарлалт “хуулиар тогтоосон” гэх шаардлага хангахгүй байж болох вэ? Хязгаарлалт хийхэд ямар шинж чанарыг хамгийн багадаа агуулсан байх вэ? Үүнд ямар гол үндэслэл байна гэж та бодож байна?

- Энэ тогтоолд хэд хэдэн үндэслэл бий. Үүнд:
 - a. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ач холбогдол: парламентаар дамжуулан үйл ажиллагаа явуулж буй зөвхөн сонгогдсон төлөөлөгчид хязгаарлалт тавих эрх мэдэлтэй байх учиртай. Энэ нь дан ганц сайд, цагдаа, шүүгчдийг тооцохгүйгээр, үүнд хариуцан тайлагнах байдал, иргэдийн хяналт орно.
 - b. Шударга ёс: иргэд хэлж болох үг, болохгүй үгнийхээ талаар урьдчилан мэдсэн байх ёстой, шударга сануулгагүйгээр хэнийг ч шийтгэх ёсгүй.
 - c. Сөрөг нөлөө: хэрэв та урьдчилан өөрт зөвшөөрөгдсөн зүйлийн талаар мэдэхгүй бол, хууль дүрэм зөрчихгүйн тулд та нэн болгоомжтой байх болно.
 - d. Урвуулан ашиглах: хязгаарлалтуудыг бусад этгээд тогтоосон бол, эдгээр хязгаарлалтыг улс төр, бизнесийн хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах өндөр эрсдэлтэй
- Тогтоол шийдвэр нь хэр хэмжээнээсээ хэтэрч хуулийн үүрэг гүйцэтгэх нь:
 - a. Хууль нь тодорхой байх ёстой, бүрхэг хууль албан тушаалтнуудыг өөрсдийн үзэмжээр шийдвэр гаргахад нөлөөлж, ингэснээр зөвхөн парламентаас хязгаарлалт хийнэ гэдэг үзэл санааны хүчийг сулруулж, мөн хүмүүс урьдчилан хязгаарлалт хийх гэж буйд зохистой сануулга авах үзэл санааг үгүй болгоно.
 - b. Европын хүний эрхийн шүүх нь хувь хүмүүс өөрсдөд хориотой зүйлсийн талаар урьдчилан мэдсэн тодорхой нөхцөл хангалттай буй тохиолдолд тогтоол шийдвэрийг “хууль”-д тооцно хэмээн мэдэгдсэн.
 - c. Хууль мөн хүртээмжтэй байвал зохино. Хэрэв хуулийг ил тодорхой бус, далд байлгах юм бол, дээрх (b) ба (c) үндэслэлүүд нь хүчингүй болно.
 - d. Хууль нь албан тушаалтнуудад хэт өөрийн үзэмжээр шийдэх боломж олгохгүй, учир нь хязгаарлалтыг парламентаас боловсруулах эрх мэдлийг тууштай булааж, түүнийг албан тушаалтнуудад олгодог.

- *Жишээ:* “нийгмийн үнэт зүйл, ёс суртахууныг зөрчсөн” гэдэг үндэслэлээр үгээ чөлөөтэй хэлэхийг хуулиар хориглох нь хангалттай тодорхой бус, түргэн батлагдаж, албан ёсны хэвлэлд нийтлэгдээгүй хууль нь хүртээмжтэй гэж тооцогдохгүй, цагдаа нарт олон нийтийн жагсаал цуглааныг олон нийтийн эрх ашигт харшилсан гэж хэдийд ч тооцогдсон үед зогсоох эрх олгосон хууль нь цагдаагийн бие бүрэлдэхүүнд хэт эрх мэдэл олгоно
- Үүний зэрэгцээ, хязгаарлалтуудыг маш нарийвчилсан байдлаар тодорхойлох боломж тэр бүр байдаггүйг хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл, олон оронд үгээ чөлөөтэй хэлэхийг хязгаарлах үндэс болох хараал, бүдүүлэг үг хэллэгийн тухай ойлголт нь мөн чанараараа бүрхэг бөгөөд тодорхойлоход төвөгтэй. Тиймээс, улс орнуудад аль болох тодорхой байх, ингэхийн тулд хүчин чармайлт гаргах шаардлага тавина.
- Энд зөвхөн хуулийн хэмжээнд боловсруулагдсан гол хуулиуд бус:
 - Хуулиар сайд нар, бусад талуудад гол хуулийн хэм хэмжээний үндсэн дээр журам батлах эрх олгох нь түгээмэл. Эдгээр журам нь гол хуулиар тодорхой зөвшөөрөгдсөн нөхцөлд, шаардагдаж буй тодорхой байх гэсэн хэм хэмжээнд нийцэж, хуулийн адил мөрдөгдөнө.
 - Зарим тохиолдолд хуулиар зохицуулагч байгууллагуудад үгээ чөлөөтэй хэлэхийг хязгаарласан, тухайлбал өргөн нэвтрүүлгийн зохицуулагчдад ёс зүйн код батлах зэрэг журам батлах эрх олгодог. Дахин хэлэхэд, эрх олгох нь шууд бөгөөд журам нь өөрөө хангалттай тодорхой нөхцөлд л шаардлага хангана.
 - Европын хүний эрхийн шүүх эрх зүйн ерөнхий тогтолцоонд гол төлөв шүүхээс тогтоосон түгээмэл хуулиудын хэм хэмжээг хууль тогтоох байгууллагатай бага зэргийн эсвэл огт холбоогүйг үл харгалзан хуулийн шаардлагад мөн нийцүүлэхийг тогтоосон.

Хууль ёсны зорилго

- 19(3) дүгээр зүйлд заасан хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилготой хязгаарлалтууд л гагцхүү хууль ёсных байна. Энэ жагсаалтад хэмжээ хязгаар бий, дор дурдсанаас бусад ашиг сонирхлыг хамгаалсан хязгаарлалт хийж болохгүй:
 - a. бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх
 - b. үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам
 - c. хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун

Хэлэлцүүлэг: Дээрх ашиг сонирхлын талаар та юу гэж бодож байна? Үгээ чөлөөтэй хэлэхийг хязгаарлахыг зөвтгөсөн, хамгаалалт шаардсан өөр ашиг сонирхол бий юу? Хүрээлэн буй орчинг хамгаалах, эдийн засгийн талаар юу гэж бодож байна? Дээрх ашиг сонирхол ямар санаа зорилготой вэ? Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хэт хязгаарлалтаас сэргийлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?

- Эдгээр ашиг сонирхлыг тогтоох нь дараах үндсэн шалтгаантай. Үүнд:
 - a. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бол суурь эрх ба гагцхүү маш чухал эрх ашгийн үүднээс түүнийг үл хэрэгсэнэ.
 - b. Хэрэв үүнд хязгаарлах шаардлага бүхий ашиг сонирхлыг тогтоогоогүй бол, засгийн газрууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах хэрэгцээ шаардлагын дор бүхий л төрлийн оролдлого хийх болно.
 - *Жишээ:* засгийн газрууд олон нийтийн дунд айдас бий болгохгүйн тулд агаарын бохирдлын индексийг нийтэд мэдээлэх боломжгүй талаар мэдэгдэв, олон нийтэд ийм төрлийн захирангуй хандлага үзүүлэхийг 19(3) дүгээр зүйлд заагдсан аль ч эрх ашигт нийцнэ хэмээн зөвтгөх боломжгүй. Засгийн газрууд улс орны удирдлагын талаарх шүүмжлэлт мэдээ, нийтлэл нь аялал

жуулчлалд саад тотгор болсноор эдийн засгийг доройтуулна хэмээн мэдэгдэв. Эдийн засаг нь хамгаалагдсан ашиг сонирхол биш юм. Нэгэн идэвхтнийг олон нийтэд сонгуулийг эсэргүүцэхийг уриалахыг хориглосон хууль зөрчсөн гэдэг үндэслэлээр бусдыг сонгуулиар саналаа өгөхгүй байхыг уриалсны төлөө торгууль ногдуулжээ. Энэ хязгаарлалт нь хууль ёсны дээр дурдсан ашиг сонирхлын алинд ч нийцэхгүй.

- Үүний зэрэгцээ, дээрх ашиг сонирхлын тодорхой элемент, тухайлбал бусдын эрх, хүн амын ёс суртахуун зэрэг нь хэт өргөн хүрээтэй. Үнэн хэрэгтээ, хуулиар ийм эрх олгож, дараа нь уг эрхийг хамгаалахын тулд үгээ чөлөөтэй хэлэхийг хязгаарласан нөхцөлд бараг бүхий л зүйлийг бусдын эрхийн хүрээнд оруулах боломжтой,
- Бодит байдал дээр, шүүхээр шийдвэрлэгдсэн цөөн хэргийг уг хэм хэмжээнд тулгуурлан шийдвэрлэсэн байдаг. (өөрөөр хэлбэл, бараг бүх хязгаарлалтууд нь аль нэгэн хууль ёсны зорилгод үйлчилдэг)
- Засгийн газруудын зүгээс хязгаарлалт хууль ёсны эрх ашгийг хамгаалж буй хэмээн мэдэгдэх нь хангалтгүй. Тэд уг хязгаарлалт болон тухайн эрх ашиг хоорондын холбоог тодорхой харуулах ёстой.
 - *Жишээ:* Өмнөд Солонгост, өмнөд хэсэгт гадны хөрөнгөтнүүд ноёрхож, хойт хэсэгт энх тунх байгааг илэрхийлсэн уран зургийг “дайсны талд таатай байдал бий болгосон илэрхийлэл” гэсэн үндсэн дээр хориглосон. Үүнд дээрх төрлийн илэрхийлэл болон өмнөд хэсгийн үндэсний аюулгүй байдлыг хамгаалах явдлын хооронд тодорхой холбоо байгаагүй. Беларусийн жишээн дээр, засгийн газар үндэсний аюулгүй байдлыг хамгаалах нэрийдлээр зурагт хуудсыг хориглох шаардлагатай байсан хэмээн мэдэгдэхдээ, тухайн зурагт хуудас нь хуулийн шаардлагад нийцээгүй хэмээн тайлбарласан. Үндэсний аюулгүй байдалтай холбогдох ямар нэгэн тодорхой уялдаа байгаагүйгээс дээрх хязгаарлалт нотлогдож чадаагүй.

Хэрэгцээ шаардлага

- Хэм хэмжээний гурав дахь хэсэг нь хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай.
- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө шиг суурь эрхийг хязгаарлах шаардлагагүй бол, үүнийг хэрхэн зөвтгөх вэ гэдэг нь илэрхий. Гэсэн хэдий ч бодит байдал дээр энэ хэм хэмжээний хэсэг нь хамгийн төвөгтэй бөгөөд олон улсын хэргүүдийн дийлэнх хэсэг нь уг бичвэрийн энэ хэсгийн үндсэн дээр шийдэгдсэн.
- “Шаардлагатай” хэмээх тодорхойлолтод дараах шаардлага багтана. Үүнд:
 - a. **Чухал хэрэгцээ шаардлага:** хамгаалагдсан эрх ашигт тулгарах өчүүхэн аюул заналхийлэл нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах хэмжүүрийг давахгүй. Үүнд эрх ашгийг хамгаалах тулгамдсан хэрэгцээ байх шаардлагатай.
 - *Жишээ:* зарим оронд олон нийтийн хэтэвчнээс гарсан албан тушаалтнуудын хоолны төлбөр олон нийтэд ил байж болох ч, захиалсан хоолных нь төрөл нээлттэй бус байх ёстой хэмээн тэд мэдэгдэж байна. Учир нь ингэснээр тэдний сонголтыг илчлэх бөгөөд хувь хүний нууцтай холбоотой асуудал. Гэвч энэ нь мэдээлэл авах эрхээс давсан чухал бус үндэслэл
 - b. **Хамгийн багаар хор хохирол учруулсан:** ихэнх тохиолдолд, хууль ёсны зорилгыг хамгаалах төрөл бүрийн арга зам байдаг. Шалгуурыг давахын тулд засгийн газар нь зорилгодоо хүрэхдээ, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хамгийн ээлтэй арга хэмжээг сонгох шаардлагатай. Өөрөөр хэлбэл, илүү хязгаарлалт бүхий арга хэмжээ нь хууль ёсны зорилгыг хамгаалсаар байх аваас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд илүүтэйгээр нөлөөлсөн арга хэмжээ нь “шаардлагатай” байж чадахгүй.

- *Жишээ:* сонин хэвлэлд олгох тусгай зөвшөөрлийг өмчлөлийн хэт төвлөрлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглаж болно, гэвч уг зорилгыг бүртгэлийн систем, өмчлөлийн тухай журам зэрэг аргаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд бага харшлах замаар биелүүлэх боломжтой.
- с. **Хэт өргөн хүрээг хамраагүй:** зөвхөн хор уршиг бүхий илэрхийллийг хязгаарлахаас бус, хууль ёсны илэрхийллийг хязгаарлахгүй.
 - *Жишээ:* Албан тушаалтныг шүүмжлэхийг хориглосон хууль нь тэдний нэр төрийг хамгаалах боловч хууль ёсны шүүмжлэлийг ихээр дагуулах магадлалтай. Албан тушаалтны талаар худал хуурмаг зүйл мэдээлэхийг хориглосон хуулийг хүлээн зөвшөөрч болно, учир нь энэ нь хэзээ ч хууль ёсных байх боломжгүй.
- д. **Тэнцвэртэй:** Сайнаас илүүтэйгээр саар зүйл учруулахгүйн үүднээс хязгаарлалтуудыг тэнцвэртэй тогтоох шаардлагатай. Заримдаа тодорхой сэдвийн талаарх хэлэлцүүлэг нь эрсдэл дагуулдаг ч уг хэлэлцүүлэг нь ямар ч тохиолдолд өрнөхөөс аргагүй чухал байж болно. Ийм тохиолдолд, үүнийг тэнцвэртэй бус байж болох шийтгэл ногдуулахад мөрдөнө. Өөрөөр хэлбэл, шийтгэл хууль ёсных байсан ч, ямар ч шийтгэл (тухайлбал, шоронд хорих) хүлээлгэх нь зохистой гэсэн үг биш.
 - *Жишээ:* Хэв журам сахиулах үйл ажиллагааны доголдлын талаарх сонины нийтлэл нь гэмт хэрэгтнүүдэд шүүхийн тогтолцоон дахь цоорхойг зааж өгснөөр, богино хугацаанд нийгмийн дэг журмыг алдагдуулах магадлалтай хэдий ч үүнийг хориглох нь тэнцвэртэй бус байх болно, учир нь эдгээр шүүмжлэл зөвшөөрөгдөөгүй байсан бол цагдаагийнхан хариуцлага алдах байсан. Нэгдсэн Вант Улсын жишээн дээр, гүтгэсэн мэдэгдлийн төлөө 1.5 сая фунт стерлингийн торгууль ногдуулсныг зохисгүй хэмээн тооцсон бөгөөд улс орон дахь хууль ёсны мэдээ, сурвалжилгад сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Дасгал 2: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтууд

Ашигласан материал

1. *Inter-American Declaration of Principles on Freedom of Expression*, adopted by the Inter-American Commission on Human Rights at its 108th Regular Session, 19 October 2000, available at: <http://www.iachr.org/declaration.htm>
2. *Declaration of Principles on Freedom of Expression in Africa*, adopted by the African Commission on Human and Peoples' Rights at its 32nd Session, 17-23 October 2002, available at: http://www.achpr.org/english/declarations/declaration_freedom_exp_en.html
3. Declaration on the Freedom of Expression and Information, adopted by the Committee of Ministers on 29 April 1982. Available at: [http://www.coe.int/t/dghl/standardsetting/media/Doc/CM/Dec\(1982\)FreedomExpr_en.asp#TopOfPage](http://www.coe.int/t/dghl/standardsetting/media/Doc/CM/Dec(1982)FreedomExpr_en.asp#TopOfPage)
4. Joint Declarations by the special international mandates on freedom of expression, available at: <http://www.osce.org/fom/66176>
5. ARTICLE 19, *Central Asian Pocketbook on Freedom of Expression*. Available at: <http://www.article19.org/data/files/pdfs/tools/central-asian-pocketbook.pdf>

Модуль 2: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ерөнхий төлөв байдал

Хэлэлцүүлэг: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрх зүйн хүрээний тухайд энэхүү сургалтаас ямар тогтоол шийдвэр, зохицуулалтын хэлбэрийг мэдэхийг та хүсч байна вэ?

- Сургалтын энэ хэсэг нь оролцогчдод үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрх зүйн хүрээг ардчилсан улс орнуудын ерөнхий дүр зургаар танилцуулах зорилготой. Энэ хэсэг нь дараа дараагийн хичээлүүдээр илүү нарийвчилсан хүрээ бүрийн удирдамж гэхээсээ илүү, эрх зүйн орчны дүр зургийг нэгтгэж харуулах, түүнчлэн мөн чанарыг өргөн далайцтай судлахад шаардлагатай юм.

Агуулга

Мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж

Эрүүгийн
• <i>Үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэг</i> Үндсэрхэг үзлээр, арьс үндсээр, шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн ялгаварлан гадуурхалт, дайсагнал, хүчирхийллийг өдөөн турхирахыг хуулиар хориглох • <i>Үндэсний аюулгүй байдал/нийгмийн дэг журам</i> Зайлуулах боломжгүй хүчирхийлэл өдөөх зорилготой • <i>Зүй зохисгүй үг хэллэг/садар самууныг сурталчлах</i> Бүдүүлэг үг хэллэг хэрэглэсэн материал төдийгүй хүүхдийг садар самуунд уруу татсан зэрэг хор хохиролтой агуулга бүхий • <i>Шүүн таслах ажиллагаа</i> Хувь шүүгчийг хамгаалах бус, шүүн таслах ажиллагааны шударга байдлыг хамгаалах • <i>Шашин шүтлэгийг үл ойшоох/Худал мэдээлэл</i> Ардчилсан нийгэмд аль нь ч шаардлагатай биш

Хэвлэл мэдээллийн зохицуулалт

Хараат бус зохицуулах байгууллага Арилжааны асуудлууд

Сэтгүүлчид	Сонин хэвлэл
• <i>Тусгай зөвшөөрөл/бүртгэл байхгүй</i> Сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхлэх нь хүн бүрт чөлөөтэй • <i>Эх сурвалжийг хамгаалах</i> Мэдээллийн нууц эх сурвалжийг хамгаалах эрх • <i>Аккредитаци/давуу эрх олгох</i> Хязгаарлалт бүхий байууллагад нэвтрэн орох давуу эрхийг баталгаажуулсан ба мэргэжлийн үйл ажиллагаанд хяналт тогтоохгүй	• <i>Тусгай зөвшөөрөл байхгүй</i> • <i>Техникийн бүртгэл</i> Шаардлагатай мэдээллээр хангахаас шууд татгалзахдаа үзэмжээрээ шийддэггүй байх • <i>Залруулга хийх, хариу өгөх эрх</i> Гэм хорыг арилгахын тулд залруулга хийх эрхтэй; хууль ёсны эрхийг зөрчсөн бол хариу өгөх эрхийг хангах • <i>Гомдол барагдуулах</i> Өөрийн зохицуулалтыг илүүд үзэх; урьдчилан тогтоосон ёс зүйн кодтой ба зөөлөн санкцтай байх

Иргэний/захиргааны	Хувийн өргөн нэвтрүүлэг	Олон нийтийн өргөн нэвтрүүлэг
• <i>Нэр төр гутаах</i> Зүй ёсны өмгөөлөл (үнэн, үзэл бодол, үндэслэл бүхий нийтлэл)-өөр зөвхөн хууль ёсны нэр төрийг хамгаалах, хариуцлага санхүү нь хязгаартай байх • <i>Хувийн нууц</i> Хувийн нууцыг үндэслэл бүхий шаардлага байх, олон нийтийн ашиг сонирхлыг илүүд үзэх	• <i>Тусгай зөвшөөрөл</i> - Давтамжийн төлөвлөгөөнд үндэслэх - Олгох процесс ажиллагаа нь шударга, ил тод байх - Үндсэн зорилго нь олон талт байдлыг хөхиүлэн дэмжих; хүйн өргөн нэвтрүүлэг • <i>Баримтлах ёс зүйн код</i> Шийтгэл ногдуулах биш, стандарт тогтоох зорилгоор бүхий л оролцогч талуудын зөвлөгөөнөөр ёс зүйн кодоо боловсруулж батлах	• <i>Хараат бус байдал</i> Хараат бус удирдах зөвлөлөөр удирдуулдаг, олон нийтийн санхүүжилтыг хараат бус эх үүсвэрээс авдаг • <i>Эрх/Мандат</i> Энэхүү эрх мандат нь хуулиар тогтоогдсон байна. Чанартай мэдээгээр олон нийтийг хангах, нийгмийн бүхий л бүлэгт үйлчлэх үүрэг хүлээнэ.

1. Агуулгын дүрэм журам

- Бидний судалж мэдсэнээр, олон улсын хуульд бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зайлшгүй шаардлагын үүднээс хууль ёсны ашиг сонирхлыг хангахын тулд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж болохыг хүлээн зөвшөөрдөг ч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой. Ардчилсан улс орнууд хязгаарлалтын боломжтой хэлбэр бүрийг албан ёсны болгохгүйгээр, харин цөөн хэдэн хязгаарлалтыг л тогтоож өгдөг.

Эрүүгийн хуулийн дүрэм журам

Үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэг

- Дийлэнх улс орнууд үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэгийг дэлгэрүүлэхийг эрүүгийн хуулиараа хориглодог ба олон улсын хуулиар ч үүнийг шаарддаг. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 20(2)-р зүйлд:
“Алагчилан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэх үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгааг хуулиар хориглоно” гэж заасан.
- Үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэгийг хязгаарлахад дараах үндсэн элементүүдийг харгалзан үздэг байна. Үүнд:
 - “дэмжсэн” үг хэллэгээр нотлогдох үзэн ядалтыг сурталчлах санаа зорилготой байхыг шаардана.
 - Үзэн ядалтыг дэмжсэн бодитой, шууд эрсдэлийг бий болгохуйц тухайн илэрхийлэл нь өдөөн хатгасан, дэвэргэсэн байхыг шаардлана.
 - үзэн ядалт нь маш хүчтэй, сөрөг сэтгэл хөдлөл байна гэсэн үзэл санаа мөн байна.
 - Ялгаварлан гадуурхалт, дайсагнал, хүчирхийллийн аль нэг үр дүнд саад тотгор урчуулахаар өдөөн турхирсан илэрхийлэл байхыг шаардлана.

Үндэсний аюулгүй байдал/Нийгмийн дэг журам

- Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хамгаалахын тулд чөлөөтэй үг хэлэхийг хязгаарлах шаардлага гардаг. Үүний зэрэгцээ, эдгээр шалтгаан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хууль бус хязгаарлалт тогтоохыг хүлцэн өнгөрүүлэхэд түүхэн цаг үед буруугаар ашиглагдаж байсан төдийгүй, тодорхой бус ойлголтууд одоо бараг л хэвээрээ байна. 1995 онд “19-р зүйл” байгууллагаас батлан гаргасан “Үндэсний аюулгүй байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн хүртээмж”-ийн Йоханнесбургийн зарчмуудаар сайтар шалгах хэмжүүр тогтоосон. Йоханнесбургийн зарчмын 6 дахь зарчимд дараах байдлаар заасан.

15, 16-р Зарчимд нийцүүлэн үзэл бодлоо илэрхийлэхийг зөвхөн засгийн газар дор дурдсан байдлыг нотолж чадсан тохиолдолд үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй хэмээн шийтгэж болно:

- а) зайлуулах боломжгүй хүчирхийлэл өдөөх зорилготой;
- б) тийм хүчирхийлэл өдөөх магадлалтай;
- в) үзэл бодлоо илэрхийлсэн, тийм хүчирхийлэл гарч болох магадлалын хооронд шууд холбоо байгаа.

Зүй зохисгүй үг хэллэг/Садар самууныг сурталчлах

- Зүй зохисгүй үг хэллэгт тооцогдох материал тараахад зарим төрлийн хязгаарлалтыг улс орнууд тогтоодог. Хүүхэд, залуучуудыг хамгаалах нь үүний нэг чухал хэсэг болдог ба насанд хүрэгчдэд зориулсан материалд боломжит хязгаарлалт тавьснаараа насанд хүрээгүйчүүд түүнийг олж авахаас урьдчилан сэргийлдэг.
- Ихэнх улс орнуудад, зүй зохисгүй үг хэллэгтэй материалын тодорхой төрлүүдийг бүрмөсөн хориглогдог. Тухайлбал, хүүхдийн порнограф ямагт хууль бус байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь мэдээлэл, үзэл санааг түгээн дэлгэрүүлдэг. Цочролд оруулах, гомдоох үзэл санаа ч өргөн хүрээнд хүлээн зөвшөөрдөгдөг. Энэ зарчмаар авч үзвэл зарим нь доромжилсон агуулгатай байж болох ч тухайн нөхцөлд бодитойгоор хор уршиг учруулаагүй (хүүхдийг садар самуунд уруу татсан тохиолдол зэрэг) тохиолдолд бэлгийн амьдралын талаарх илэн далангүй бичсэн материал ч хамгаалагдана. Гэхдээ, энэ нь олон улсын хуулийг хүлээн зөвшөөрсөн улс орнууд дагаж мөрдөх дүрэм журмын хүрээ хязгаараа өөрсдөө тогтоодог. Нэлээд улс оронд, ямар байх нь тохиромжтой талаар хүй олны өргөн тархсан үнэлэмжид тулгуурлан тухайн стандартаа тогтоосон байдаг.

Шүүн таслах ажиллагааг хамгаалах

- Шүүхийн захиргааны хууль ёсны дагуу, үйл ажиллагаа хэвийн, саадгүй явуулах баталгааг хангах, шүүх эрх мэдлийг хамгаалах нь хоёулаа шүүн таслах ажиллагааны шударга байдлыг хамгаалахад чухал үүрэгтэй. Хэн ч бай гэрч, шүүгчийг нөлөөндөө оруулах, эсвэл айлган сүрдүүлэх, шүүхэд худлаа ярих (худал мэдүүлэг өгөх), шүүн таслах ажиллагааг тасалдуулахыг хориглосон дүрэм журам байх шаардлагатай гэсэн ерөнхий ойлголт байдаг.
- Шүүх засаглалыг шүүмжлэхийг хориглосноор шүүх эрх мэдлийн хамгаалалтыг илүү их эргэлзээтэй болдог. Шүүгчийг хүндэтгэх ёстой гэдэг утгаар олон улс оронд хүлээн зөвшөөрөөд буй уг дүрэм журмын зорилгын талаар байнгын төөрөгдөл будлиан, маргаан гардаг. Гэсэн хэдий ч, ямар нэг хэмжээгээр шүүх эрх мэдлийг хүндэтгэснээр иргэдийн хувьд нийгэм дэх маргаантай асуудлаар эцсийн шийдвэр гаргадаг шүүхийн гүйцэтгэх үүргийг хүлээн зөвшөөрөхөд зайлшгүй шаардлагатай гэдэг нь тэдгээр дүрэм журмын бодит үндэслэл болдог. Өөр өөр үр дүнд хүрэхийг шаардсан эрс тэс ялгаатай зорилгууд байна. Тухайлбал, шударга бус гэж шүүмжилсэн ч, хууль ёсны дагуу илүү хүчирхэг гэдгийг нь хүмүүс ойлгосон тул цаашид шүүхийг ашигласан хэвээр байна. Үнэн хэрэгтээ, шүүхийн нээлттэй шүүмжлэл нь хариуцлагатай байдлыг дэмжихэд тусалж, олон нийтийн итгэлийг илүү хүлээхэд тэргүүлэх үүрэгтэй оролцсоноороо байгууллагын хувьд хөгждөг.

Шашин шүтлэгийг үл ойшоох болон худал мэдээний хууль тогтоомж

- Шашин шүтлэгийг үл ойшоохтой холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн асуудал дэлхий даяар маш их маргаантай байна. Шашин шүтлэгийг үл ойшоохтой холбоотой харилцааг зохицуулсан хуулиа хүчингүй болгож, үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэгийн эсрэг хуулиар шашин шүтэгчдийн эрхийг хамгаалахаар болсон ардчилсан улс орнуудын тоо нэмэгдэж байна. Бусад оронд, Шашин шүтлэгийг үл ойшоохтой холбоотой харилцааг зохицуулсан хууль нь шашныг зохистойгоор хүндэтгэх эрхийг хангахад үндсэндээ оршдог.
- Эдгээр хууль тогтоомж нь чөлөөтэй үг хэлэх талаасаа харахад бэрхшээл ихтэй. Шашин, итгэл үнэмшлийн эрх чөлөө хариуцсан НҮБ-ын тусгай илтгэгч шашин шүтлэгийг үл ойшоохтой холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомжоо хүчингүй болгохыг улс орнуудад уриалсан.
- Нэг гол асуудал нь итгэгчдийг (үзэн ядалтын эсрэг хуулиар хамгаалах боломжтой) хамгаалах хууль ёсны зорилгоос гадна итгэл үнэмшлийг дангаараа хамгаална. Асуудал юу вэ гэхээр бол итгэл үнэмшил бол зөрчилдөөнтэй байж болно. Тэгэхээр нэг итгэл үнэмшлийг хамгаална гэдэг нь нөгөө итгэл үнэмшлийг хамгаалж чадахгүй, нөгөө нэгийгээ үнэндээ үгүйсгэж байдаг. Бодит байдал дээр, шашин шүтлэгийг үл ойшоохын эсрэг хуулиуд нь ялгаварлан гадуурхалтыг бий болгож, зөвхөн нэг үндсэн гол гэж үзсэн шашинаа хамгаалдаг. Ийм төрлийн хуулийн ихэнх нь шашин шүтэгч, шүтлэггүй хүмүүсийг ялгаварлан гадуурхалтад өртүүлдэг. Энэ хууль нь шашны цөөнх болсон хүмүүсийг хэлмэгдүүлж, итгэгчдийг хооронд нь сөргөлдүүлэхэд байнга ашиглагддаг. Цаашилбал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зарчим нь эрх мэдэл бүхий хүмүүсийг эрх мэдлээ урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэхийн тулд нээлттэй шүүмжлэлийг дэмждэг. Гэсэн хэдий ч ийм хууль нь шашны толгойлогчдыг л байнга хамгаалдаг.
- Зарим улс орон хуурамч мэдээллийн тухай хуультай. Энэ нь нэр төр гутаасан эсэхээс үл хамааран хуурамч мэдээлэл тараасан л бол гэмт хэрэгт тооцдог. Мэдээжийн хэрэг, сайтар нягтлан шалгасан сурвалжилга мэдээ нь сэтгүүлчдийн мэргэжлийн түвшинд ажиллах хүсэл эрмэлзэл байдаг. Үүнтэй зэрэгцэн, худал мэдээллийн зүйл заалтаар маш олон асуудал үүсч, нэлээд оронд шүүхэд очих хэрэгт давамгайлсаар байна. Энэ нь олон нийтийн ашиг сонирхлын асуудал хөндсөн асуудлаар цаг үеийн мэдээллээр хангах мэргэжлийн үүргээ гүйцэтгэж буй сэтгүүлчдэд айдас түгшүүртэй нөлөө үзүүлж байна. Энэ нь “факт”-д илүү ач холбогдол өгөх хандлагыг нэмэгдүүлэх, олон нийтэд ил болоогүй үзэл бодлыг илэрхийлэхэд хязгаарлалт тогтооход буруугаар ашиглагдах боломжтой.

Хэлэлцүүлэг: Худал мэдээллийн дүрэм журмын ойлголтыг та юу гэж бодож байна вэ? Тэдгээр нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд халдахаас зайлсхийхэд шаардлагатай юу? Энэ салбарт олон улсын ямар хэм хэмжээ байдаг вэ?

Иргэний хууль тогтоомж

Нэр төр гутаах

- Улс орон бүр гүтгэлгийн эсрэг хууль тогтоомж гэж нэрлэгддэг нэр төрийг хууль бус халдлагаас хамгаалах тогтоол шийдвэр байдаг. Олон улсын хууль тогтоомжоор ийм хууль нь иргэний хууль байх ёстой гэдэг ба эрүүгийн хуулийн гүтгэлэг нь нийгмийн дэг журмыг хангах үүднээс гэж түүхэнд зөвтгөгддөг байсан ч, одоо энэ үндэслэл дэмжигдэхээ больсон.
- Нэр төр гутаахтай холбоотой иргэний хуулийн зохицуулалт нь наад захын нэлээд хэдэн стандартыг хүндэтгэх ёстой:
 - Энэ нь бодитойгоор нэр хүндийг л хамгаалахад чиглэгдэнэ. Объектыг (туг далбаа, шашны бэлэгдэл), төрийн байгууллагыг хамгаалахад хэрэглэхгүй
 - Үнэн хамгаалалт болно. Үзэл бодол, эсвэл мөн эцэстээ үнэн зөв биш нь тогтоогдсон ч гэсэн үндэслэл бүхий бичигдсэн нийтлэл хамгаалагдах ёстой.
 - Хууль тогтоох байгууллага, шүүхээс өмнө нь хийгдсэн мэдээ нийтлэл, тэдний хийсэн мэдэгдлийн талаарх шударга сурвалжилга нь хамгаалагдах ёстой.
 - Нэр төр гутаасны нөхөн төлбөрийн хэмжээ нь бодит учруулсан хохиролтой дүйж байх ёстой бөгөөд ял цээрлүүлэх зорилгоор ашиглагдах ёсгүй. Залруулга хийх, хариу өгөх эрх олгох зэрэг мөнгөн бус хэлбэрээр гэм хорын хохирлыг барагдуулахыг илүүд үзэж, тэргүүн ээлжинд хэрэглэнэ.

Хувийн нууц

- Дийлэнх улс орнууд хувийн нууцыг иргэний хуулиараа мөн хамгаалдаг.
- Хувийн нууцтай байх ашиг сонирхлыг хамгаалбал зохих дөрвөн төрлийг тодорхойлсон. Үүнд: бусдын орон байранд үндэслэлгүй нэвтрэх, хэн нэгний нэр, хөрөг зургийг ашиглах, хуурамч мэдээлэл хэвлэн нийтлэх, хэн нэгний хувийн амьдралын тухай байж болшгүй нийтэл гаргах
- Нууцын хууль тогтоомж нь чөлөөтэй үг хэлэх наад захын хэм хэмжээтэй зөрчилдвөл олон улсын стандартыг баримтлана.
 - Бүх нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр тухайн хувь хүнд нууц мэдээллээ үндэслэлтэйгээр шаардах нөхцлүүдийг хязгаарлах ёстой.
 - Мэдээ нийтлэл нь авлигын, эсвэл амь нас, аюулгүй байдалд халдсан баримтыг илчилсэн зэрэг олон нийтийн нийтлэг ашиг сонирхолд нийцсэн бол чөлөөтэй үг хэлэх боломж олгох ёстой.

Дасгал 3: Хувийн нууцын хувилбар

2. Мэдээлэл авах эрх

- Төрийн байгууллагуудад хадгалагдаж буй мэдээллийг хүн бүр олж авах эрхтэй. Үүнд олон улсын хуулиар хүлээн зөвшөөрсөн үл хамаарлын хязгаарлалт байж болох ба үндэсний хууль тогтоомжоор энэ дамжин хэрэгжинэ.
 - Мэдээлэл олж авахыг дэмжсэн өргөн боломж нөхцлийг бүрдүүлэх
 - Төрийн байгууллагууд мэдээллээ ил болгох идэвхтэй ажиллагааг шаардах

- Мэдээлэл авах хүсэлтийг шийдвэрлэх нарийн тодорхой процедурыг бий болгох
- Мэдээлэл олж авах эрхийн үл хамаарлыг явцуу, маш тодорхой тогтоох
- Бие даасан давж заалдах механизмыг бүрдүүлэх

3. Хэвлэл мэдээллийн зохицуулалт

- Гурван гол зарчим нь ардчилсан хэвлэл мэдээллийн зохицуулалтын үндсэн тулгуур болдог.
 - a. *Эрх чөлөө*: Тогтоол шийдвэр нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулахад ч, эсвэл агуулгын зохицуулалтын хувьд ч хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хязгаарлалтыг хэтрүүлж болохгүй.
 - b. *Хараат бус байдал*: Тогтоол шийдвэрээр хэвлэл мэдээлэлд улс төрийн болон арилжааны хөндлөнгийн оролцоо нөлөөллийн аль алинаас нь урьдчилан сэргийлэх ёстой.
 - c. *Олон ургальч байдал*: Тогтоол шийдвэр нь хэвлэл мэдээллийн олон ургальч, олон талт байдлыг дэмжих ёстой

Хараат бус зохицуулах байгууллага

- Хэвлэл мэдээллийн зохицуулагч байгууллага нь улс төр, арилжааны хөндлөнгийн оролцоо нөлөөллөөс хамгаалагдахын тулд хараат бус байх ёстой. Хараат бус байх шалтгаан нь маш тодорхой харагдаж байна. Ийм хамгаалалт байхгүй бол зохицуулах байгууллагын шийдвэр нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, олон нийтийн ашиг сонирхлоос илүүтэй улс төрийн, эсвэл арилжааны талаасаа нөлөөлөлд орох болно. Энэ нь олон улс орны хувьд ноцтой асуудал болоод байна.
- Бодит байдал дээр хараат бус байдлыг баталгаажуулах нь маш хэцүү. Энэхүү хараат бус байдлыг баталгаажуулах арга зам нь улс орны улс төр болон институт/зохион байгуулалтын нөхцөл байдалд нийцсэн байх ёстой. Тус зохицуулах байгууллагын удирдах гишүүдийг томилох үйл явцад хууль тогтоох байгууллага, иргэний нийгэм зэрэг оролцогч талуудыг илүү өргөн хүрээнд татан оролцуулах нь түүний хараат бус байдлыг бэхжүүлэхэд тусалдаг. Мөн бүрэн эрхийн хугацаанаас өмнө гишүүнийг чөлөөлөхөөс хамгаалсан байх нь маш чухал.

Арилжааны асуудлууд

- Хэвлэл мэдээллийн өмчлөлийн хэт/зүй бус төвлөрөл бий болсноор өмчлөгч бүлгийн дэмжсэн нэгэн хэвийн агуулга хандлагатай, тус бүлэгт харьяалагдах өөр өөр мэдээллийн хэрэгслүүд ижил хөтөлбөр нэвтрүүлдэг учраас олон талт байдал алдагдаж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг сулруулдаг. Улс орнууд хэвлэл мэдээллийн өмчлөл төвлөрөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай байна. Хэвлэл мэдээллийн төвлөрлийн эсрэг арга хэмжээ нь чөлөөт зах зээлд өрсөлдөөнийг бий болгохоос гадна, олон нийтийг олон талт мэдээлэл, үзэл санааг хүлээн авах боломжоор хангахыг эрэлхийлдэг.
- Ихэнх улс оронд олон нийтийн зар сурталчилгаа нь хэвлэл мэдээллийн орлогын чухал эх үүсвэр байдаг хэдий ч, хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг

хамгаалахын тулд улс төрийн хөндлөнгийн оролцоо нөлөөнөөс ангид байх шаардлагатай. Олон нийтийн зар сурталчилгааг байршуулахын тулд зах зээлийн нөхцөл байдлаа тооцсон, шударга, бодит шалгуур дээр үндэслэсэн цогц тогтолцоо бий болгохыг шаарддаг.

Сэтгүүлчид

- Бусад мэргэжлээс эрс ялгаатай нь, хүний үндсэн суурь эрх болох үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө эдэлснээр сэтгүүл зүйн практик бий болдог учир сэтгүүлчдэд тусгай зөвшөөрөл олгох нь хууль ёсны биш юм. Олон улсын хуулиар хүлээн зөвшөөрсөн аливаа эрх ашгийг хамгаалах шаардлагатай гэдгээр ч зөвтгөж болдоггүй учраас сэтгүүлчдийг бүртгэх тогтолцоо нь ч хууль ёсны биш юм.
- Олон улсын хуулиар сэтгүүлчдийн хувьд хоёр эерэг хамгаалалтыг хүлээн зөвшөөрдөг:
 - Сэтгүүлчид мэдээллийн нууц эх сурвалжаа илчлэхээс татгалзах эрхтэй. Эс тэгвээс тэдгээр эх сурвалж нь эхний ээлжинд олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн мэдээллийг гаргаж тавихаа болино.
 - УИХ, мөн шүүх зэрэг хязгаарлалт бүхий газруудад нэвтрэх давуу эрхтэй байх ёстой. Тэдгээр газарт юу болж буй талаар олон нийтэд өргөнөөр мэдээлж байхын тулд үүнийг баталгаажуулж өгдөг.

Сонин хэвлэл

- Ихэнх ардчилсан улс оронд хэвлэл мэдээллийн тусгай хууль байхгүй байна. Улс орнуудын сонин хэвлэлийг зохицуулах тусгай дүрэм журам, тогтоол шийдвэрт дараах зарчмыг баримтлах шаардлагатай:
 - Сонин хэвлэлд тусгай зөвшөөрөл шаардах нь хууль ёсны биш (өөрөөр хэлбэл, хэвлэл байгуулахад албан ёсны зөвшөөрөл шаардах гэх мэт).
 - Тэр ч байтугай, хэвлэл мэдээлэлд техникийн бүртгэлийн систем ч урвуулан ашиглагдаж болзошгүй тул шаардлагагүй гэж үздэг. Хэрэв ийм тогтолцоо байгаа бол энэ нь хэт төвөгтэй, дарамттай байх ёсгүй.
 - Иргэний хуулиар заасан хувийн нууцад халдах, нэр төр гутаахын эсрэг гомдол барагдуулах сайн тогтолцоо нь алдаагаа засах, хариу эрх олгох байдаг. Гэхдээ энэ нь чөлөөтэй үг хэлэх эрхийг хязгаарлахад буруугаар ашиглагдахааргүй зүй ёсны, маш нарийн тодорхой байх шаардлагатай.
 - Мэргэжлийн ур чадварыг дэмжих, хэвлэл мэдээллийн талаар гаргасан гомдолд хариу өгөх өөрийн зохицуулалтын тогтолцоо нь буруу байдлаар урвуулан ашиглагдахаагүй байхыг илүүд үзэх ёстой. Хэвлэлийн зөвлөл нь хуулиар байгуулагдсан бол хараат бус байж, түүнд хэвлэл мэдээллийн гишүүдийн хүчтэй бүрэлдэхүүнийг оролцуулах нь тохиромжтой.

Хувийн өргөн нэвтрүүлэг эрхлэгч

- Сонин хэвлэлээс ялгаатай нь, олон нийтийн хязгаарлагдмал нөөц болох агаарын долгионы эмх цэгцтэй хэрэглээг бий болгох зорилгоор л өргөн нэвтрүүлэгт тусгай зөвшөөрөл шаардлагатай байна.
- Олон улс оронд, өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл олгох, агуулгад хяналт тогтоох аль алинд зохицуулалт хийж байна.
- Давтамжийн нэгдсэн төлөвлөгөөн дээр тулгуурлан олон нийтийн, арилжааны болон хүйн өргөн нэвтрүүлгүүдэд адил тэгш давтамж авах боломжтойгоор хуваарилалтыг хийж, тусгай зөвшөөрөл олгоно. Олон талт байдлыг дэмжсэн, өмчлөлийн хэт их төвлөрөл бий болохоос хамгаалах зэрэг зорилгод нийцүүлэн урьдчилан тогтоож, нийтэд зарласан шалгуур үзүүлэлтээр давтамж хүссэн өргөдлийг үнэлж дүгнэнэ.
- Өргөн нэвтрүүлгүүдэд хөтөлбөрийн хамгийн наад захын стандарт, баримтлах ёс зүйн кодыг тогтоож өгөх нь түгээмэл байдаг. Өргөн нэвтрүүлгийн баримтлах ёс зүйн код нь бүхий л оролцогч талуудтай зөвшилцөн боловсруулагдсан, кодоо зөрчвөл хүлээлгэх хариуцлага санкц хэмжээндээ, тохирсон байх хэрэгтэй.

Олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгч

- Бүхий л хэвлэл мэдээллийн нэгэн адил олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгч нь засгийн газрын оролцоо, ялангуяа, удирдах зөвлөлийг томилоход оролцох арга замаар нөлөөлөхөөс хамгаалагдах ёстой.
- Олон нийтийн өргөн нэвтрүүлэг нь арилжааны өргөн нэвтрүүлгийнхээс илүү баялаг, өргөн хүрээний агуулгатай хөтөлбөр нэвтрүүлэгтэй байх зорилт тавьдаг. Үүний тулд улс орны эрх ашиг, онцгой хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдээ сурвалжилга хийх эрхийг нь хуулиар тодорхой тогтоож өгдөг. Улс төрийн дарамт шахалтаас хамгаалагдсан байхаар хуульд заасан боловч, тэдэнд олон нийтийн санхүүжилт мөн хэрэгтэй.

Хэлэлцүүлэг: Монгол улсын олон нийтийн өргөн нэвтрүүлэг хэр зэрэг хараат бус байна вэ? Түүний хараат бус байдлыг сайжруулахад практик ямар арга хэмжээ хэрэгжүүлж болох вэ?

Ашигласан материал

1. Toby Mendel, *Study on International Standards Relating to Incitement to Genocide or Racial Hatred*, 2006:
http://www.concernedhistorians.org/content_files/file/TO/239.pdf
2. ARTICLE 19, *Freedom of Expression and Contempt of Court* (2000):
<http://www.article19.org/pdfs/publications/foe-and-contempt-of-court.pdf>
3. ARTICLE 19, *The Camden Principles on Freedom of Expression and Equality*, 2009:
<http://www.article19.org/data/files/pdfs/standards/the-camden-principles-on-freedom-of-expression-and-equality.pdf>
4. Recommendation No. R(2000)23 of the Committee of Ministers to member states on the independence and functions of regulatory authorities for the broadcasting sector, adopted 20 December 2000:
[https://wcd.coe.int/wcd/ViewDoc.jsp?Ref=Rec\(2000\)23&Language=lanEnglish&Ver=original&Site=CM&BackColorInternet=9999CC&BackColorIntranet=FFBB55&BackColorLogged=FFAC75](https://wcd.coe.int/wcd/ViewDoc.jsp?Ref=Rec(2000)23&Language=lanEnglish&Ver=original&Site=CM&BackColorInternet=9999CC&BackColorIntranet=FFBB55&BackColorLogged=FFAC75)
5. Special international mandates on freedom of expression, Joint Declaration on the OSCE Representative on Freedom of the Media and the OAS Diversity in Broadcasting, 12 December 2007. Available at:
<http://www.article19.org/pdfs/standards/four-mandates-dec-2007.pdf>
6. Centre for Law and Democracy and SEAPA, *Myanmar: Guidance for Journalists on Promoting an Empowering Press Law*. Available at: <http://www.law-democracy.org/live/myanmar-guidance-on-an-empowering-press-law/>
7. Toby Mendel and Eve Salomon, *The Regulatory Environment for Broadcasting: An International Best Practice Survey for Brazilian Stakeholders*, UNESCO, 2011:
<http://unesdoc.unesco.org/images/0019/001916/191622e.pdf>
8. ARTICLE 19, *Access to the Airwaves: Principles on Freedom of Expression and Broadcast Regulation* (2002):
<http://www.article19.org/pdfs/standards/accessairwaves.pdf>
9. Toby Mendel, *Public Service Broadcasting: A Comparative Legal Survey*, UNESCO, 2011:
http://portal.unesco.org/ci/en/files/31375/13052976943public_service_broadcasting_en.pdf/public_service_broadcasting_en.pdf

Модуль 3: Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт

- Хэвлэл мэдээлэл мэргэжлийн бус ажилласан тохиолдолд хувь хүнд нэр төрөө сэргээлгэх нэг төрлийн боломж олгодог энэхүү сайн туршлагыг өргөнөөр хүлээн зөвшөөрч байна. Үндсэн асуудал нь аль тогтолцоо нь хамгийн сайн бэ гэдэгт л оршино.

1. Өөрийн болон холимог зохицуулалт: Давуу ба сул тал

Зохицуулалтын тогтолцооны ялгаа

- Хэвлэл мэдээллийн зохицуулалтын гурван гол тогтолцоо байна. Үүнд: өөрийн зохицуулалт, холимог зохицуулалт, хуулиар зохицуулах /зохицуулалт/:
 - Эхний хувилбарын хувьд хэвлэл мэдээлэл (холбогдох хэвлэл мэдээллийн салбарынхан, тухайлбал сонин хэвлэл, өргөн нэвтрүүлэг) зохицуулалтын тогтолцоогоо өөрсдөө зохион байгуулж, бүрдүүлдэг. Ихэнх тохиолдолд, эдгээр тогтолцоо нь баримтлах ёс зүйн дүрэм, эсвэл түүнтэй адил бичиг баримтаа боловсруулж, хэвлэл мэдээллийн мэргэжлийн бус ажиллагаанд юу хамаарахыг тогтоож, энэхүү асуудлаар гомдол хүлээн авч, шийдвэрлэх эрх бүхий этгээдийг байгуулдаг.
 - Холимог зохицуулалтын тогтолцоо нь хэвлэл мэдээлэл, эсхүл хэвлэл мэдээллийн салбарынхны тусламжтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг тул өөрийн-зохицуулалтын зохион байгуулалттай нэлээд төстэй. Гэхдээ энэ нь хууль тогтоомжид тулгуурладаг тогтолцоо гэдгээрээ ялгаатай.
 - Цэвэр зохицуулалтын тогтолцооны хувьд хуулиар хяналт тавих байгууллага байгуулдаг. Энэ байгууллагын үйл ажиллагааг нь бүхэлдээ хэвлэл мэдээллийнхэн явуулахгүй, боловч хэвлэл мэдээллийн төлөөлөгчид түүнд оролцох боломжтой. Холимог болон өөрийн зохицуулалтын тогтолцоо хоёулаа энгийн гомдол хянан шийдвэрлэх чиг үүргээ байнга хэрэгжүүлэхээс гадна зохицуулалтын үйл ажиллагааны бусад хэлбэрийг ашигладаг.

Аль тогтолцоо нь илүү тохиромжтой вэ?

- Өөрийн зохицуулалтын тогтолцоо нь засгийн газрын нөлөө оролцоонд хамгийн багаар өртөхөд анхаарах нь хамгийн чухал учраас сонин хэвлэлийн салбарт илүү ойр дөхөм гэж хүлээн зөвшөөрөгддөг. Гэсэн хэдий ч, холимог зохицуулалтын тогтолцоог мөн харгалзан үзэх хоёр шалтгаан байна:
 - Нэгдүгээрт, олон улс оронд хэвлэл мэдээлэл, эсвэл холбогдох хэвлэл мэдээллийн салбар нь өөрийн зохицуулалтын тогтолцооны хэлбэрийн шаардлагад нийцэхүйц уялдаа холбоо, төлөвшил дутмаг байдаг. Мэдээж, хэвлэл мэдээллийн орчны хөгжил төлөвшлийг харьцуулсан ч жинхэнэ өөрийн зохицуулалтын тогтолцоог хөгжүүлэхэд хүндрэлтэй байж болно. Тухайлбал, нэг зах зээлийг хувааж, мэдээний агуулгаараа бие биетэйгээ өрсөлддөг учраас өөр өөр хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь хамтран ажиллахад нэлээд бэрхшээл учирч болно. Холимог зохицуулалтын хандлага

нь энэ асуудлыг шийдэж чаддаг. Энэхүү тогтолцооны үндсэн үзүүлэлтүүдийг хуулиар тогтоож өгснөөрөө өөр өөр хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хоорондоо зөвшилцөлд хүрсэн эсэхээс огт хамаарахгүй болдог. Хэвлэл мэдээллийн дэмжлэг, итгэл үнэмшил энэхүү тогтолцоонд чухал ач холбогдолгүй гэсэн үг бас биш. Энэ тогтолцоонд хэвлэл мэдээлэлтэй үр дүнтэй, зүй ёсны зөвшилцөл, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон ажилтнуудын өргөн хүрээний дэмжлэг нь түүний амжилтын үндэс болдог. Гэхдээ хууль тогтоомж түлхэц болж байгаа нь төслийг урагштай болгоход шийдвэрлэх үүрэгтэй. Цаашилбал, бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл энэ тогтолцооны оролцогч тал болохыг холимог зохицуулалт нь шаарддаг. Ингэхдээ асуудал тулгарахаас зайлсхийхийн тулд ажлаа үргэлжлүүлэхээс өмнө бүх оролцогч талууд хоорондоо бүрэн тохиролцоонд хүрсэн байдаг.

- Өөрийн зохицуулалтын тогтолцооны шийдвэр нь хуульд нийцсэн байсан ч хүч султай байдаг нь хоёр дахь шалтгаантай нягт холбоотой. Үр дүнд нь, мэдээллийг системээс татаж авах, эсвэл дутагдал алдаагаа хэвлэн нийтлэх зэргээр түүнд нийгмийн хариуцлага хүлээлгэж болох хэдий ч хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өөрсдийн эсрэг гаргасан шийдвэрийг эцсийн дүндээ үл тоомсорлож болно. Холимог зохицуулалтын тогтолцоо нь нөгөө талаас эрх зүйд тулгуурладаг тул шийдвэрээ заавал дагаж биелүүлэхийг шаарддаг. Энэ нь зөвхөн хүчин төгөлдөр болох асуудал биш бөгөөд олон нийтийн өмнө энэхүү тогтолцооны итгэл үнэмшлийг бэхжүүлэхэд тусалдаг. Олон нийтийн итгэл үнэмшил нь маш чухал. Учир нь олон нийт энэ тогтолцоог ашиглахгүй бол /тухайлбал, гомдол гаргахгүй бол/ энэ нь зорилгодоо хүрч чадахаа болино.
- Сонин хэвлэлийн хувьд цэвэр зохицуулалтын тогтолцоотой ардчилсан улс оронд бараг л байдаггүй. Учир нь өөрийн болон холимог зохицуулалтын хандлагын үндсэн үзүүлэлт болдог сонин хэвлэл нь энэ зохицуулалтын тогтолцоонд хүчтэй үүрэг гүйцэтгэдэггүй. Цэвэр зохицуулалтын тогтолцоог хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хүнд хэлбэрийн зөрчлүүд гардаг газруудад хэрэглэгддэг.
- Цэвэр зохицуулах тогтолцоо нь долгион ашигладаг гэдгээрээ зохицуулалтад ордог өргөн нэвтрүүлгийн хэвлэл мэдээллийг илүү зохицуулдаг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх олон улсын тусгай илтгэгчдийн 2003 онд баталсан Хамтарсан тунхаглалд:

“Зохицуулалтын тогтолцоо нь хэвлэмэл болон өргөн нэвтрүүлгийн салбар, төдийгүй интернэтийн хоорондох үндсэн ялгааг харгалзан үзэх ёстой” гэж заасан.

Хэлэлцүүлэг. Монгол дахь сонин хэвлэлийн хувьд хамгийн тохирох хандлагыг юу гэж бодож байна вэ? Өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн хувьд ямар байх вэ? Цэвэр зохицуулалтын тогтолцоо ажиллаж чадаж байна гэж үзэж байна уу?

2. Хэвлэлийн зөвлөл: Бүтэц, хараат бус байдал

Хараат бус байдлыг баталгаажуулах

- Хэвлэлийн зөвлөл мэтийн хяналтын байгууллагыг байгуулах нь хэвлэл мэдээллийн зохицуулалтын аль ч тогтолцооны хувьд амин чухал зүйл байдаг. Тулгамдаж буй асуудлууд нь тухайн байгууллагын хараат бус байдал, мэдээж засгийн газраас, мөн зохицуулахыг оролдож буй хэвлэл мэдээллийн оролцогч талуудыг хамруулан арилжааны ашиг сонирхлоос ангид байлгах асуудлыг хэрхэн баталгаажуулахад оршдог. Ардчилал илүү хөгжсөн улс орнуудад зохицуулахыг оролдож буй тэдгээр зохицуулагчдын “үзүүлж буй” аюул занал нь засгийн газрын хяналтаас ч илүү эрсдлийг дагуулж байна.
- (Зөв) өөрийн зохицуулалтын тогтолцоонд засгийн газрын хяналтын эрсдэл маш бага байдаг бөгөөд хэвлэл мэдээлэлд хангалттай итгэл хүлээхүйц хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах баталгааг бий болгоход л сорилт бэрхшээл нь байдаг. Холимог тогтолцооны хувьд засгийн газраас хараат бус байх үндсэн баталгаа нь, бусад сонирхол бүхий оролцогч талуудтай хамтран хэвлэл мэдээллээс олон төлөөлөл оролцуулахад оршино. Үүний хамгийн чухал зүйл нь тухайн байгууллагын гишүүнчлэл, томилогдсон гишүүд байдаг.

Гишүүдийн төлөөлөл

- Хэвлэлийн зөвлөлд аль салбарыг төлөөлөхийг шийдвэрлэх нь үндсэн асуудал болно. Энд шидэт арга зам байхгүй бөгөөд янз бүрийн улс орнуудад өөр өөр арга зам сонгосон байна. Энэ нь улс орны олон талын хүчин зүйлээс хамаарч, аль нь зөв арга зам сонгохыг тодорхойлдог. Практик ойлголтоор бол, тус байгууллага нь нийгэм, улс төрийн байдлаасаа хараат бус ажиллахыг хангалттай баталгаажуулах шаардлагатай. Хэвлэл мэдээллийн хүй олноос тодорхой тооны гишүүдийг шаардлагатай тоогоор нь гаргаж ирэх хэрэгтэй. Зарим улс оронд хуулиар бусад гишүүдийн ерөнхий тодорхойлолтыг өгдөг бол, зарим улс оронд тодорхой салбаруудаас гишүүдтэй байхыг илүү нарийвчлан заадаг.
 - *Жишээ:* Индонезид Хэвлэлийн зөвлөл нь 9 гишүүнтэй байна. Сэтгүүлчдийн төлөөлөл 3, хэвлэл мэдээллийн эздийн төлөөлөл 3, жирийн иргэдийн ашиг сонирхлыг төлөөлөх 3 төлөөлөгч (“олон нийтийн төлөөлөл”) байхаар тогтоосон. Сүүлийн ангилалд хамаарч буй хувь хүнд академик хүмүүс, иргэний нийгмийн төлөөлөл болон бусад хүй олонд хүлээн зөвшөөрөгдсөн этгээдүүд багтдаг.
 - *Жишээ:* Энэтхэгт, Хэвлэлийн зөвлөлийн 29 гишүүний 13 нь ажиллаж буй сэтгүүлч байна. Түүний 6 нь эрхлэгч, 7 нь эрхлэгч бус этгээд байх бөгөөд түүнээсээ хамгийн багадаа 3-4 төлөөлөл нь үндэснийхээ хэл дээр гардаг сониных байх ёстой. 6 өмчлөг/сонины менежер, 1 нь мэдээний агентлаг, 3 нь хууль, боловсрол, шинжлэх ухаан, утга зохиол, соёлын асуудлаар нэр хүнд бүхий этгээд байна. 5 нь парламентын гишүүн байх ба нэмэлт нэг суудал байж болохоор зохицуулсан байна.

- Нөгөө нэг асуудал нь засгийн газрын төлөөлөл консулд байх эсэх асуудал юм. Индонез, Энэтхэгийн загварын аль алинд ийм төлөөлөл байхгүй ба сайн жишгийг тогтооход засгийн газрын төлөөлөл байх шаардлагагүй гэж практикт үздэг.

Гишүүдийн томилгоо

- Энд мөн л хэвлэлийн зөвлөлийн гишүүдийг хэн томилж байгаад шилдэг, шидэт арга зам гэж байхгүй. Харин хараат бус, үр нөлөө бүхий байдлаа хэрхэн хамгийн сайн баталгаажуулах гэдэг асуудалтай үндсэндээ холбогддог.
 - *Жишээ:* Индонезид хэвлэл мэдээллийн хүй олон нь хэвлэлийн зөвлөлийн бүх гишүүдээ нэр дэвшүүлнэ. Сэтгүүлчид нь өөрийн төлөөллөө, эзэд нь төлөөллөө, хоёулаа нийлээд олон нийтийн төлөөлөлдөө нэр дэвшүүлдэг. Жинхэнэ томилгоог ерөнхийлөгч хийдэг. Гэхдээ энэ нь хууль ёсны болгож ёсчилж байгаагаас бус, гишүүдийг сонгоход ямар нэг үүрэг гүйцэтгэдэггүй. Дарга, орлогч даргаа гишүүд дотроосоо томилдог.
 - *Жишээ:* Энэтхэгт, өөр өөр салбарууд нь өөрийн салбарынхаа төлөөллөө нэр дэвшүүлнэ. Харин даргын суудал нь чухал байр суурь эзлэх ба бусад гишүүдээс сонгогдсон төлөөлөгч болон парламентыг татан оролцуулсан онцгой процедураар нэр дэвшүүлдэг. Индонезид хуулийн дагуу засгийн газар нь гишүүдийг албан ёсоор томилдог ч, хэн зөвлөлд суудал авахыг шийдвэрлэхэд ямар нэг үүрэг гүйцэтгэхгүй.
- Эдгээр хоёр улс нь гишүүдээ нэр дэвшүүлэх үндсэн механизмуудыг тодорхой харуулж байна. Нэг нь хэвлэл мэдээллийн хүй олон нь өөрийн болон олон нийтийн төлөөллийг нэр дэвшүүлэх аргыг, нөгөө нь өөр бусад салбарууд өөр өөрийн төлөөллийг нэр дэвшүүлэх арга замыг харуулна. Хоёулаа хараат бус байдлын ирээдүйг харж, тухайн нөхцөлд сонголтод засгийн газрын нөлөөг оруулдаггүй.

Хэрхэн сонгох вэ?

- Нэг удаагийн шийдвэр нь нэр дэвшүүлэх ажлыг хэн хариуцаж байгаа, хувь хүмүүсийг хэрхэн гаргаж ирэх онцгой сонгуулийн тогтолцоо байгаагаас шалтгаалдаг. Хэвлэл мэдээллийн хувьд, ялангуяа, өөр өөр бүлгийн төлөөлөл хэрхэн нэрээ дэвшүүлэх асуудлыг хамтран шийдвэрлэдэг. Тэгэхээр дахиад, Индонези, Энэтхэг улсуудад хуульд зааснаар явуулах хоёр загвар байна.
 - *Жишээ:* Индонезид, хууль нь хэрхэн томилгоог хийх тухайд зохицуулаагүй, хэвлэл мэдээллийн хүй олон өөрсдөө түүнийг удирдан зохион байгуулахаар үлдээсэн. Бодит байдал дээр, сэтгүүлчид болон эзэд аль аль нь тус тусын төлөөллөө маш нарийн процедураар гаргаж ирээд, харин олон нийтийн төлөөллөө хоёр бүлэг хамтран сонгодог.
 - *Жишээ:* Энэтхэгт, эрс ялгаатайгаар зохицуулсан. Хуулиар хэвлэл мэдээллийн төлөөллийг ямар процессоор гаргаж ирэх, тусгай нэр дэвшүүлэх байгууллагуудын хувьд бусад гишүүдэд болзол тавихаас эхлээд маш нарийн тодорхой зохицуулалтыг хуулиар тогтоож өгсөн. Үндсэндээ, зөвлөл нь өөрөө холбогдох хэвлэл мэдээллийн эвсэл

холбоодыг хүлээн зөвшөөрөх ба дарга нь тэтгэвэрт гарахдаа эдгээр эвсэл холбоодоос гишүүдээ нэр дэвшүүлэхийг урьдаг.

- Энд засгийн газрын оролцоо нөлөө орох эрсдлийг хамгийн бага байлгадаг Индонезийн хандлагыг илүү санал болгож байна. Энэтхэгийн систем нь шүүмжлэгддэг. Нөгөө талаас, энэ хандлагыг ажиллуулахын тулд хэвлэл мэдээллийн хүй олны талд зохицуулалт, төлөвшлийн тодорхой түвшинд хүрсэн байхыг шаардана. Хэдийгээр цэвэр өөрийн зохицуулалтын тогтолцооны хувьд шаардлага нь баг тавигддаг.

Санхүүжилт ба хариуцлага

- Хэвлэлийн зөвлөлийн санхүүжилт нь хараат бус байдлын ирээдүйн нэг чухал зүйл учраас “Мөнгөтэй нь ая дуугаа захиална” гэсэн хэллэг гарсан. Төгс шийдэл нь хэвлэл мэдээлэл өөрөө зөвлөлийн зардлаа санхүүжүүлэх юм. Хэвлэл мэдээллийн татвар хандивыг олон улс оронд урьдчилан тооцоолж төлөвлөдөг ч, бодит амьдралд холимог болон хууль ёсны тогтолцоонд маш ховор тохиолддог.
- Үүний оронд, ихэнх тохиолдолд, хууль ёсны дагуу зөвлөл нь олон нийтийн хуримтлалын сангаас санхүүжилт авдаг. Сайн туршлагын хувьд байгууллага нь жилийн төсвөө илгээж, парламентаараа батлуулдаг. Энэ нь хөндлөнгийн оролцооны эсрэг хүчтэй хамгаалалтыг бий болгодог. Учир нь парламент олон намын төлөөлөлтэй ба хөндлөнгөөс оролцох боломж нь хязгаарлагддаг. Засгийн газрын хяналтанд шууд удирдлагаар хангагддаг учраас яамаар төсвийг батлуулах нь хамгаалалтын системийг сулруулдаг.

3. Хэвлэлийн зөвлөл: Гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагаа

Гомдол хянан шийдвэрлэх

- Хэвлэлийн зөвлөлийн хамгийн анхан шатны үүрэг үйл ажиллагаа нь хэвлэл мэдээллийн мэргэжлийн үйл ажиллагааны талаарх олон нийтээс гомдол хүлээн авах байдаг. Үүнийг зохих ёсоор хийхийн тулд зөвлөл нь мэргэжлийн үйл ажиллагаа гэж юу болохыг тогтоосон стандарт, ерөнхийдөө баримтлах ёс зүйн кодыг тогтоох хэрэгтэй болдог. Мөн тэд гомдлыг хянан шийдвэрлэх нарийн тодорхой процедуртай байх шаардлагатай.
- Хэн, эсвэл юуг ёс зүйн кодоор тогтоох вэ гэдэг нь эхний ээлжийн асуудал юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өөрсдөө тогтоодог сайн туршлага бий. Жишээ нь, сонинууд, сэтгүүлүүд тогтоох нь хувь сэтгүүлчээс хамаагүй илүү болно. Үүнд хоёр үндсэн шалтгаан байна. Үүнд:
 - Нэгдүгээрт, хувь хүн нийтлэл бичсэн хэдий ч, хариуцлагатай редактор хэвлэл мэдээллийн хэрэгсэлдээ нийтлэх шийдвэр гаргадаг тул хувь сэтгүүлчээс илүү байна. Цаашилбал, ихэнх тохиолдолд, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдэж, үүний үр дүнд өргөн хүрээнд уншигчдад түгээгдсэнээс хохирол учирсан тул гомдол гардаг.
 - Хоёрдугаарт, дийлэнх хэвлэл мэдээллийн гомдлын систем нь маш чухал, үр нөлөөтэй залруулгыг санал болгодог. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл зөвхөн

дагаж мөрдөх ёстой ёс зүйн кодыг зөрчсөн гэдгээ хүлээн зөвшөөрснөө нотолсон нийтлэлийг гаргаснаараа үр дүнтэй байдаг.

- Гомдлын систем нь хандах гэж буй асуудлаар давхардсан зүйл байсан хэдий ч иргэний болон эрүүгийн хуулийг орлохгүй. Гомдлын зорилго нь хэвлэл мэдээлэл мэргэжлийн наад захын хэм хэмжээг хангахгүй байна гэсэн мэдрэмж авсан хувь хүмүүст хүртээмжтэй, хөнгөн тайвшрал авчирдаг. Дээр тодорхойлсноор, шүүхээр хамгаалуулах хязгаартай эрх зөвхөн гомдлын системээр дамжина. Санхүүгийн нөхөн олговор хүссэн хувь хүмүүс иргэний хуулийг ашиглах ёстой. Хэрэв сэтгүүлчид гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргасан бол эрүүгийн шүүхийн системийн дагуу шийдвэрлэгдэх ёстой.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих нь

- Олон хэвлэлийн зөвлөлд гомдол хэлэлцэх үйл ажиллагаанаас гадна хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах нийтлэг эрх хэмжээ олгогдсон байдаг. Дэмжлэг үзүүлэх талаасаа, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний мөн чанар, ач холбогдлын тухай хэвлэл мэдээллийн ажилтнуудын ойлголт мэдлэгийг дээшлүүлэх ажлыг явуулдаг. Энэ хүрээнд нийгмийн төрөл бүрийн салбарынханд чиглэсэн, эсвэл янз бүрийн сэдэв асуудлаар сургалт, семинар явуулах, мэдлэг дээшлүүлэх кампанит ажил, гадны туршлага хуваалцах зэрэг олон янзын үйл ажиллагаанд татан оролцуулдаг.
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хамгаалалт гэдэгт энэхүү эрхийг зөрчсөн халдлагад хариу үзүүлэх шаардлагаас хамаарч, мөн өргөн хүрээний үйл ажиллагаанд татан оролцуулна. Зарим тохиолдолд, хэвлэлийн зөвлөл нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй хууль батлагдахаас нь өмнө төсөлд нь санал өгөх үйл ажиллагаа явуулдаг. Мөн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний халдлагын эсрэг эсэргүүцэл илэрхийлж болно. Зарим тохиолдолд тэд шууд хамгаалах үйл ажиллагаанд ч оролцож болно. Тухайлбал, хуулийн асуудалд холбогдсон хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх, аюулгүй байдлын сургалт, эсвэл аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмжөөр хангах зэргээр сэтгүүлчдийн аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх боломжтой.
- Дийлэнх тохиолдолд, зөвлөл нь эдгээр төрлийн ажилдаа зориулан илүү хөрөнгө босгох хэрэгтэй болдог.

Бүртгэл

- Олон улс оронд сонины бүртгэлийн систем байдаг бөгөөд энэ нь хууль ёсны төдийгүй, ижил шаардлагатай гэж ихэнхдээ авч үздэг. Ойрын судалгаагаар, тухайлбал, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дарамт учруулах байдлаар урвуулан ашиглагдаж болдог дутагдалтай талыг туршлагаар харуулсан бүртгэлийг хязгаарлахыг зөвлөсөн. Хэрэв сониныг бүртгүүлэхийг шаарддаг бол хэвлэлийн зөвлөлөөр хянуулснаар урвуулан ашиглагдах эрсдэл нь буурна. Энэ бол Индонезид байдаг жишээ юм.

Нийгмийн хэлэлцүүлгээр шийдвэр гаргах

- Нийгэм илүү ардчилсан болохын хирээр уламжлалт ойлголт, харилцаа алга болж болно. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй илүү холбоо хамааралтай байдаг. Сэтгүүлчид заримдаа юу ч хамаагүй хүссэнээ бичих, хэвлэн нийтлэхийг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө гэж ойлгодог. Бусад нийгмийн гишүүдэд ч хэвлэл мэдээллийн эрх чөлөөний шинэ хил хязгаарыг ойлгох, хүндэтгэхэд эргэлзээ байнга төрдөг. Жишээ нь, хувь хүмүүс нийгмийн тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг явуулах дургүй байгаа бол улс төрчид маш хүчтэй шүүмжлэлд өртөхгүй байх боломжтой.
- Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд зарим улс оронд хэвлэлийн зөвлөл хувь хүнд чиглэсэн гомдлоос гадна, өргөн хүрээнд хэлэлцүүлж маргааныг шийдвэрлэх үүрэг хүлээдэг.
 - *Жишээ:* Индонезид Хэвлэлийн зөвлөл нь хэвлэл мэдээллийн ажиллагаанд тавих зүй ёсны, тохирох хязгаарлалтын тухай маргалдаантай, үл ойлголцолтой байсан хэвлэл мэдээлэл, Мусулманы Холбооны хооронд хэлэлцүүлэг өрнүүлсэн. Хэвлэл мэдээлэл, засгийн газрын хоорондын зөрчилдөөнийг шийдвэрлэхэд мөн ингэж ажилласан.

Мэргэжлийн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих

- Олон улс оронд хэвлэлийн зөвлөл маш сайн мэргэжлийн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжихийг тэргүүн ээлжинд тавьж, гомдол гарахаас урьдчилан сэргийлэхэд тусалдаг. Энэ бол үндсэн зорилт нь болдог. Засгийн газар, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хамруулан бусад оролцогчид нь үүний төлөө гол хариуцлага хүлээдэг. Гэхдээ, зөвлөл нь мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, бусад санаачлагуудыг зайлшгүй боловсронгуй болгоход энэ туршлага нь тусална.

4. Баримтлах ёс зүйн код боловсруулах, дагаж мөрдөх

Баримтлах ёс зүйн код боловсруулах

- Хэвлэл мэдээллийн гомдол барагдуулах аль ч тогтолцооны хувьд ёс зүйн код амин чухал бүрэлдэхүүн хэсэг нь болно. Олон нийтийн хувьд, ёс зүйн код нь хэвлэл мэдээллийн төлөвшил байдлын хувьд ямар стандарттай байхыг хүсэн хүлээж байгаагаар тодорхойлдог. Энд чухал зүйл нь ардчилалд шилжиж буй улс орнуудад энэ талаар ойлголтгүй байх нь түгээмэл. Хэрэв олон нийт тодорхой хэвлэл мэдээллийн стандартуудыг санал болгосон кодыг хэрэглэж эхэлбэл, энэ нь мэдлэг ойлголтыг дээшлүүлэх арга хэрэгсэл болж, хэвлэл мэдээлэл, нийгмийн хоорондох санал зөрөлдөөнийг багасгахад тусална.
- Хэвлэл мэдээллийн хувьд, ёс зүйн код нь чанд мөрдөхөөр хүлээн зөвшөөрсөн төлөвшил байдлын хамгийн доод түвшний стандартыг тогтоодог. Энэ нь мэдлэг ойлголтыг дээшлүүлэх элементтэй. Тодорхой сэтгүүлчид ёс зүйн кодыг бэлтгэхэд илүү сайн оролцуулж байхад, зарим нь энэ тухай ойлголтгүй байдаг. Маш нарийн сайн тодорхойлогдоогүй стандартыг баримтлан, сэтгүүлчид хууль ёсоор хүндэтгэн биелүүлэх нь хэцүү тул энэ тогтолцооны шударга гэдгийг баталгаажуулах нь гол

асуудал юм. Эцэст нь хэлэхэд, маш нарийн тодорхой томъёологдсон ёс зүйн код нь удаан хугацаанд тогтвортой хэрэглэхүйц тогтоол шийдвэр гэсэн утгаар урьдчилан харж баталгаажуулахад тусалдаг, шударга ёсны нэг хэсэг болж өгдөг.

- Хэвлэлийн зөвлөлийн гол үүрэг хариуцлага бол ёс зүйн кодыг батлах байдаг. Үүний сацуу, хамгийн чухал зүйл нь ёс зүйн кодыг боловсруулахад бүхий л оролцогч талуудад хувь нэмрээ оруулах боломжийг олгох явдал юм. Энэхүү үйл явцад сэтгүүлчдийг илүү татан оролцуулах нь мөн онцгой чухал байна. Ёс зүйн кодоод мэргэжлийн хэвлэл мэдээллийн баримтлавал зохих шинж байдлын бодит стандартыг тусгасан байх ёстой бөгөөд хэвлэл мэдээлэлд тулгараад буй сорилт бэрхшээлийг ойлгомжтой байлгахад үндэслэн тулгуурласан байна. Эргээд энэ нь сэтгүүлчид боловсруулах ажиллагаанд оролцсон тохиолдолд л үр дүнд хүрнэ.

Ёс зүйн кодын агуулга

- Баримтлах ёс зүйн кодууд нь нэг улсаас нөгөөд ямар нэг байдлаар ялгаатай байдаг бөгөөд мөн өргөдөл хүлээн авах хүрээ (хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсвэл зөвхөн сэтгүүлчдийн гэх мэт)-нээс хамаарна. Мөн тухайн үедээ, эдгээр нь хамгийн их тохиолддог үндсэн стандартууд байдаг. Агуулгын асуудал (яг юу хэвлэн нийтэлсэн) болон сэтгүүлчдийн бие авч явах байдал (сэтгүүлчид өгүүлэл түүхээ бичихийн тулд юу хийж чадсанал алиныг ихэнхдээ хамруулдаг.
- Зарим нэг түгээмэл, чухамдаа бараг олон улсын болсон ёс зүйн кодын өвөрмөц онцлог нь нягт нямбай байхыг шаардах, хувийн мэдээллийг хамгаалах дүрэм журам, мэдээнд орж буй хүүхэдтэй харьцах журам, мэдээллийн нууц эх сурвалжийг хамгаалах үүрэг, өгүүлэлд төлбөр төлөх журам зэрэг шаардлагууд багтдаг.
- Эрүү, иргэний хууль болон гомдол барагдуулах энэхүү тогтолцооны үндсэн ялгаа нь дүрэм журам зөрчсөний төлөөх санкц буюу арга хэмжээ нь харьцангуй зөөлөн шинж чанартай байдаг. Эрүүгийн болон иргэний хуулиас илүү зарим бүс нутагт илүү төвөгтэй стандарт тогтоосон ёс зүйн код түгээмэл болж байна. Жишээ нь, Олон улсын хуулиар үзэн ядалтыг өдөөн хатгахыг хориглосон нь улс орнуудын эрүүгийн эрх мэдлийг хязгаарладаг. Маш олон хэвлэл мэдээллийн ёс зүйн код нь хэрээс хэтрүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслийг стереотип буюу хэвшмэл ойлголтыг дэвэргэхээс зайлсхийхийг уриалдаг.

Гомдол хянан шийдвэрлэх

- Дийлэнх хэргүүдийг гомдол хэлэлцэх процессын дагуу нарийвчлан ёс зүйн код өөрөө зохицуулдаг. Ихэнх тохиолдолд, хэвлэлийн зөвлөл нь гомдол хянан шийдвэрлэх үйл явцаа илүү нарийвчлан тодорхойлж, түүнчлэн цаг үедээ тохируулан шинэчлэх, өөрчлөх боломжтой болохыг ёс зүйн кодоод өөрт нь заадаг. Зөвлөлийн гомдол хянан хэлэлцэх барагдуулах процессыг маш тодорхой, шударга дүрэм журмаар батлан мөрдөх нь сайн туршлага болно.

Шийдвэр биелэх хүчинтэй байх

- Дээр дурдсанчлан, ихэнх хэрэг дээр энэ тогтолцоо нь зөөлөн санкц оноох, залруулгын хэлбэрүүдийг ашигладаг. Ёс зүйн кодыг зөрчвөл хамгийн түгээмэл хэрэглэгддэг санкц нь зөрчил гаргасан тухайгаа хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл гаргахыг сониноос шаарддаг. Мөн олон хэрэг дээр зөвлөл энэхүү мэдэгдлийг бэлтгэдэг бөгөөд зарим хэрэг дээр сонинд шийдвэрийг бүхэлд, эсвэл түүний гол хэсгийг хэвлэн нийтлэхийг шаардаж болдог.
- Алдаагаа засах буюу хариу өгөх эрх олгох нь сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн кодоо зөрчсөний төлөө хамгийн түгээмэл хэрэглэгддэг хариуцлагын хэлбэр болдог. Алдаагаа засах гэж өмнө нь алдаа мадагтай, нягтлан шалгаагүй гаргасан мэдээллийнхээ алдааг залруулсан мэдээлэл нийтлэхийг сониноос шаардахыг ойлгоно. Хариу өгөх гэж ташаа мэдээллээр буруутгагдсан этгээд тухайн хэвлэгдсэн нийтлэлд өөрийн үгээрээ хариулт өгөх эрх олгохыг ойлгоно. Алдааг засах нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний цаашдын хандлагад хамгийн улиг болж залхаасан шинжтэй ч, алдаатай өгүүлэл нийтэлж, зөрчил гаргасан л бол цаашид ч хэрэглэхээс өөр арга байхгүй.
- Баримтлах ёс зүйн кодыг зөрчсөний төлөө залруулахаар хариу өгөх эрхийг хүлээн зөвшөөрсөн ч гэсэн, тухайн үедээ энэ нь урвуулан ашиглагдаж болдог. Тухайлбал, эрх мэдэл бүхий улс төрчид шүүмжлэгдэх бүртээ хэвлэл мэдээллийг өөрийн талд олж авахыг оролддог. Үр дүн нь, тухайн этгээдийн эрхээ эдлэж буй тухайн нөхцөл байдалд хязгаарлалт тогтоох нь чухал ач холбогдолтой. Жишээ нь, хувь хүний нууцад халдсан, эсвэл нэр төр гутаасан нийтлэл байгаа учраас нэхэмжлэгчийн хууль ёсны эрхийг гажуудуулсан, ёс зүйн кодоо шууд зөрчсөн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд энэ арга нь боломжтой байна. Хариу өгөх нь уртын хэмжээ, хүрээгээрээ хязгаарлагдах ёстой (тухайлбал, ёс зүйн код зөрчсөнөө залруулж, нэр төр сэргээх г.м).
- Хэвлэлийн зөвлөл нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд торгууль ногдуулах эрх хэмжээтэй болж практик өөрчлөгдөж байна. Эдгээр нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нэлээд онцгой үр нөлөө үзүүлж байгаа ба энэ нь өөрөө болон холимог зохицуулалтын тогтолцоонд хэрэглэх тохиромжгүй гэдгийг нэлээд улс орон тогтоосон. Нөгөө талаар, энэ нь зөрчлийг нэн ноцтой гэдэгт дохио өгөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хэвлэлийн зөвлөлд торгууль ногдуулах эрх хэмжээтэй бол тэрхүү торгуулийн дүнгийн дээд хэмжээг тогтоож өгөх нь сайн туршлага болно.
- Өөрөө болон холимог зохицуулалтын тогтолцооны хамгийн гол ялгаатай талын нэг бол зөвлөлийн шийдвэр цаашид хууль ёсоор заавал биелэгдэх болдог. Түүний үр хүрэх үр дүнг нарийн тогтоох хэмжигдэхүүн нь эрх зүйн системийн мөн чанараас хамаарна.

Жишээ: Индонезид, хэвлэл мэдээлэлтэй холбоотой хэргийг шүүхээс авч хэлэлцэхийн тулд нэхэмжлэл гаргагч нь шүүх руу явахын өмнө хамгийн эхлээд Хэвлэлийн зөвлөлд гомдол гаргаж шийдвэрлүүлсэн байхыг шаарддаг. Хэвлэлийн зөвлөлийн шийдвэр нь тэдний эсрэг гарсан, эсвэл буруутай үйлдлийн төлөөх нөхөн төлбөрт сэтгэл хангалуун биш байгаа зэрэг аль ч байдлаар Хэвлэлийн зөвлөлийн гаргасан шийдвэрт сэтгэл ханамжгүй, эс зөвшөөрч байвал нь шүүхэд нэхэмжлэл гарган зарга үүсгэх боломжтой байна.

Модуль 4: Нэр төр гутаах

1. Ухагдахууны тодорхойлолт ба хамрах хүрээ

Ерөнхий хэлэлцүүлэг

- “Нэр төр гутаахтай холбоотой” хууль хэмээх өргөн хэрэглэгддэг хэллэгийг хувь хүний нэр төр, мэдрэмжийг хамгаалдаг бүхий л төрлийн хуулийг хэрэглэхдээ дурддаг. Энэхүү хэллэгийн хамрах хүрээ нь гүтгэх, хов жив тараах, доромжлох, үл тоомсорлох гэх мэт ухагдахууныг тодорхойлно.
- Нэр төр гутаахтай холбоотой **сайн** хууль гэдэг нь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба хувь хүний нэр төрийг хамгаалах ойлголтын хооронд алтан дундажийг баримталсан үндэслэлтэй байх ба дараах байдлаар тодорхойлж болох юм. Энэ нь хүмүүсийн нэр төрд сэв суулгахаар бодит үнэнийг гуйвуулсан худал хуурмаг мэдээ, мэдээллийн эсрэг тэднийг хамгаалах зорилготой хууль юм. Хуулийн тодорхойлолт нь дөрвөн хэсгээс бүрдэнэ. Нэр төрийг гутаасан мэдээ мэдээлэл нь дараах шинжийг агуулсан байх ёстой. Үүнд:
 - Худал хуурмаг байх (Үнэнийг хамгаалах тухай дор дурдсан хэсгээс тодруулна уу)
 - Үнэнийг гуйвуулсан байх (Санал бодлыг хамгаалах тухай хэсгээс тодруулна уу)
 - Олны өмнө хэлсэн байх (Дор хаяж хөндлөнгийн нэг этгээдийн хажууд хэлсэн байх, өөрөөр хэлбэл ярьж буй этгээдээс гадна хөндлөнгийн хүн ярианд оролцсон байх)
 - Тухайн хүний нэр төрд сэв суулгах буюу гутаах; энэхүү зорилгын үүднээс авч үзвэл нэр төр гэдгийг нийгмийн бусад гишүүдээс тухайн хүнд үзүүлж буй хүндэтгэл гэж тодорхойлж болно; тухайн хүний нийгэмд эзлэх байр суурь буурахгүй ч гомдож гутрах байдлаар илрэх хүмүүсийн мэдрэмжийг үүнд хамааруулахгүй, мэдрэмж нь хийсвэр ойлголт бол нэр төр гэдэг нь бодит шалгуураар хэмжигддэг ба гомдол гаргагчаас гадна өөр бусад хүмүүс мэдээллийг сонссон байдаг.
- Үзэн ядалтаас үүдэлтэй үг хэллэгийн тухай хууль (бүлэг хүмүүсийн эсрэг өдөөн хатгалтаас сэрэмжлэх зорилготой), харааж зүхсэн үг хэллэгийн тухай хууль (шашны гол номлолыг үгүйсгэсэн агуулгатай), хувийн нууцын тухай хууль (бусдын хувийн амьдралд оролцохоос сэргийлсэн), нийгмийн хэв журмын тухай хууль (олныг хамарсан үймээн самуун, гэмт хэргээс сэргийлэх зорилготой) үүнд хамаарахгүй болно.
- Нэр төр гутаахтай холбоотой хууль нь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах замаар өөр нэг зайлшгүй чухал ашиг сонирхол болох хүний нэр төрийг хамгаалдаг. Энд бэлэн хэвшсэн ангилал байхгүй ба нарийвчлан тодорхойлсон

дүрэм журамтай уялдуулсан тэнцвэрт байдал зайлшгүй байх ёстой. Үүнд мөн гэмтэн этгээд өмгөөлөгчид хандах боломжтой, буруутгагч тал зайлшгүй нотлож чадахаар элементүүдийг нарийн тодорхойлсон хуулийн систем оролцоно.

- Энэхүү тэнцвэрт байдлыг удирдлага болгохдоо мэдээ мэдээлэл тараасан хүний ашиг сонирхол буюу зөвхөн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрөхөөс гадна нийгэмд мэдээ мэдээлэл, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй олон нийтийн түгээмэл ашиг сонирхлыг бас бодолцож, үүн дотроо олон нийтийн мэдээлэл авах эрх, улмаар мэдээлэлтэй иргэд шийдвэр гаргах боломжийг бас чухалчлах хэрэгтэй. Иймд зөвхөн хариуцлага хүлээлгэхийг урьдал болголгүй энэ нь бас бусдын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй ханддаг хүмүүст ч гэсэн үр нөлөө үзүүлдэггүйг зайлшгүй бодолцох ёстой.
- Олон улсын хуулийн дагуу нэр төр гутаахтай холбоотой хууль нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарладаг бүх хуулийн адилаар энэхүү хичээлийн нэгдүгээр хэсэгт дурдсан гурван талт шалгуурын дагуу авч үзэх хэрэгтэй.

Хэлэлцүүлэг: Дээр санал болгосны дагуу нэр төр гутаах хуулийг хязгаарлах нь тохиромжтой эсэх талаар таны бодол? Худал мэдээлэл бүхий санал бус ор үндэсгүй шударга бус зүйл байвал яах вэ? Хувь хүний нэр хүндийг шууд гутаахгүй ч гэсэн хүнийг эвгүй байдалд оруулах мэдээллийн талаар та юу гэж бодож байна?

Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиуд

- Хэдийгээр ихэнх оронд нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиуд хүчин төгөлдөр үйлчилж байгаа ч олон улсын хэм хэмжээгээр үүнийг хууль ёсны гэж тооцдоггүй. НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос 2011 онд гаргасан Ерөнхий тайлбарын 19 дүгээр зүйлд:

Засгийн газрынхаа улс төрийн систем, эс бөгөөс засгийн газрын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандсан хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэгчид, сэтгүүлчдэд торгууль ногдуулсныг үзэл бодлын эрх чөлөөнд тавих зайлшгүй хязгаарлалт гэж авч үзэж болохгүй.

Улс орнууд нэр төр гутаахтай холбоотой хэрэгтэй тэмцэхдээ зөвхөн онц ноцтой тохиолдлыг эрүүгийн хуулиар авч үзэж болох ч ямар ч тохиолдолд хорих ял ногдуулах нь зохисгүй юм.

- 2002 онд гаргасан Хамтарсан тунхаглалын олон улсын тусгай илтгэлд энэ тухай бүр нарийвчлан тусгасан. Үүнд:

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой нэр төр гутаасан явдалд эрүүгийн хэрэг үүсгэн хуулийн хязгаарлалт тавих ёсгүй ба нэр төр гутаасан

талаархи эрүүгийн бүх хуулийг халж өөрчлөн шаардлагатай тохиолдолд иргэний хуулиар асуудлыг шийдвэрлэх нь зохимжтой.

- Нэр төр гутаасан хэргийг эрүүгийн хуулиар шийдвэрлэхэд хамгийн санаа зовоох асуудал нь энэ нь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд сөрөг нөлөө үзүүлдэгт оршино. Нэр төр гутаасан хэргийг эрүүгийн хуулиар шийдвэрлэх нь хүнд шийтгэл ногдуулах тухайлбал, шоронд хорих, төлж дийлэхээргүй торгууль ноогдуулах, сэтгүүлчдийн хувьд мэргэжлийн ажлаа гүйцэтгэх эрхийг боомилох зэрэгт хүргэдэг. Шийтгэлийг тооцохгүй байлаа гэхэд нэр төр гутаасан хэргийг эрүүгийн хуулиар шийдвэрлэхэд хувь хүн цагдаагийн газарт баривчлагдах, улмаар урьдчилан хорих газарт хоригдох, эрүүгийн хэргийн шүүхэд дуудагдах гэхчлэн удаан хугацаанд үргэлжлэх сөрөг үр дагавартай. Хэдийгээр шүүх багахан хэмжээний торгууль ногдуулсан ч тухайн хүн эрүүгийн хэрэгт холбогдсон нэр зүүж олны өмнө нүүрээ улалзуулах болдог. Шоронд хорих ялыг түдгэлзүүлэхэд мөн дээрх асуудал тулгардаг ба тухайн хүн хэдий чөлөөтэй үлдсэн ч дахин шоронд хоригдохоос эмээх айдас үүсэн ахиж хэзээ ч дуугарахгүй амаа хамхихад хүргэнэ.
- Баримтаас харахад, олон оронд нийгэмд нөлөөтэй эрх мэдэл бүхий хүмүүс буюу ихэнх тохиолдолд зарга зайлхай хийдэг хүмүүс тухайлбал, албан тушаалтнууд нэр бүхий бизнесменүүд нэр төр гутаасан хэргийг эрүүгийн хуулиар шийдүүлдэг нь байдлыг улам хурцатгадаг сөрөг талтай. Үнэн бодит байдлыг нуун дарагдуулах, шүүмжлэлээс өөрсдийгөө хамгаалахын тулд эдгээр хүмүүс хуулийн заалтыг буруугаар хэрэглэхийг оролддог.
- Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийг эсэргүүцэх гол түлхүүр нь хувь хүний нэр хүндийг хамгаалах зорилготой иргэний хуулийг үр дүнтэй хэрэглэх явдал юм. Энэ нь нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийг хүчингүй болгосон ба цаашид хэрэглэхээ больсон орнуудын туршлагаас үүдэлтэй.
- Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийг бас өөр өнцгөөс шүүмжлэх нь бий. Нэр төр гутаах асуудал нь маргаангүй хүний хувийн харилцаанаас үүсдэг байхад төр үүнд оролцох хэрэггүй хэмээн шүүмжилдэг. Түүнээс гадна, эрүүгийн хуулийн хариуцлагын дагуу нэр төр нь гутаагдсан хүн ямар нэгэн нөхөн төлбөр авдаггүй харин ихэнхдээ тогтсон хуулийн системийн хүрээнд торгууль төрийн халаасанд шууд ордог.
- Төрийн байгууллагууд (тухайлбал, төрийн яамд, засгийн газрын агентлагууд ба засаг захиргааны байгууллагууд) ямар ч тохиолдолд нэр төр гутаасан хэргээр шүүхээр заалдах ёсгүй ба учир нь эдгээр байгууллагын үйл ажиллагааны талаар нээлттэй хэлэлцэх нь чухал, тэдгээрт хамгаалах нэр төрийн асуудал байх боломжгүй юм. Энэ нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэхчлэн төрийн бүх шатны тухайлбал, үндэсний, бүс нутгийн, орон нутгийн байгууллагуудад хамаарна.
- Төрийн “нэр хүнд”-ийг хамгаалах, тухайлбал, төртэй холбоотой бодит зүйлүүд шашны бэлэг тэмдэг, туг далбаа, төрийн сүлдийг нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиар хамгаалах нь мөн маргаан дагуулсан асуудал юм. Эдгээр хийсвэр

зүйлд хамгаалж болох ямарваа нэгэн санхүүгийн болон сэтгэл санааны ашиг сонирхол байхгүй, мөн үнэнийг гуйвуулсан худал мэдээллээр гутааж болох аливаа нэгэн “нэр хүнд” байгаа эсэх нь өөрөө эргэлзээтэй асуудал билээ. Цөөхөн тохиолдолд нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийн зорилго нь дээрх хийсвэр ашиг сонирхлыг олны санаанд нийцэхгүй улс төржсөн үг ярианаас сэргийлэхэд чиглэдэг.

- 2000 онд баталсан Хамтарсан тунхаглалын олон улсын тусгай илтгэлд энэ салбарын олон улсад мөрдөгдөх хэм хэмжээг тодорхойлон тусгасан. Үүнд:

Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулинд хамгийн багаар бодоход, дараах хэм хэмжээг дагаж мөрдөх ёстой.

- Төр, түүнтэй холбоотой объектууд, тухайлбал, туг далбаа, сүлд, төрийн байгууллагууд ба албан тушаалтнуудыг бүхий л төрлийн гутаан доромжилсон үйлдлээс сэргийлсэн агуулгатай байна.

Хэлэлцүүлэг: Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиар төрийн байгууллагууд болон бэлэг тэмдгийг хамгаалах ёсгүй гэдэгтэй та санал нийлж байна уу? Хэрвээ үүнийг тооцохгүй бол төрийн байгууллагууд өөрсдийгөө хэрхэн худал хуурмаг, хорон үр дагавартай мэдээллээс хамгаалах вэ? Үндэсний омогшил бэлэг тэмдгийг хэрхэх вэ?

2. Өмгөөлөх

- Нэр төр гутаахтай холбоотой нэхэмжлэлийн эсрэг өмгөөлөх систем нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бө нэр төрөө хамгаалах эрхийн тэнцвэрийг олох түлхүүр ойлголтын нэг юм. Нэр төр гутаахтай холбоотой нэхэмжлэлийн эсрэг янз бүрийн өмгөөлөл байх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрдөг. 2011 онд баталсан НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны Ерөнхий тайлбарт эдгээр өмгөөлөх аргын заримаас дурдахдаа:

Нэр төр гутаахтай холбоотой хуулиудыг хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах зорилгоор практикт хэрэглэхгүй гэсэн 3 дугаар заалттай уялдсан эсэхийг нягтлан боловсруулах ёстой. Энэ төрлийн хуулиуд, ялангуяа нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулинд үнэнийг хамгаалах гэсэн өмгөөлөх хэсгийг оруулах хэрэгтэй ба мэдээллийн уг сурвалж, сэдвийг нягтлах, илэрхийлсэн хэлбэрийг дурдан хэрэглэх ёсгүй. Төрийн албан тушаалтнуудын тухай мэдээлэлтэй холбоотой тохиолдолд дор хаяж, торгууль ноогдуулахаас зайлсхийх, эсвэл өөр аргаар өш хонзон саналгүй хууль бус, худал хуурмаг мэдээлэл алдаатай хэвлэгдсэнийг залруулж болох юм. Ямар ч тохиолдолд олон нийтийн ашиг сонирхлын үүднээс шүүмжлэл нь өмгөөлөх арга гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

- 2000 оны Хамтарсан Тунхаглалын олон улсын тусгай илтгэлд өмгөөлөлийн талаар илүү нарийвчилсан, тодорхой мэдээлэл тусгагдсан байна. Үүнд :

Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулинд наад зах нь, дараах хэм хэмжээг дагаж мөрдөх ёстой.

- Төрийн байгууллагатай холбоотой асуудлыг нээлттэй хэлэлцүүлэх нь чухал болохыг нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулинд тусгаж, мөн албан тушаалтнууд жирийн иргэдийг бодвол шүүмжлэлд илүү өртдөг зарчимтайг дурдаж, ялангуяа албан тушаалтнуудад тусгай хамгаалалт эдлүүлдэг хуулиуд тухайлбал, үл тоомсорлосон, хүндэтгээгүй тухай хуулийг хүчингүй болгох хэрэгтэй.
- Төрийн байгууллагын тухай мэдээлсэн баримтын худал хуурмаг болохыг нотлоход гарах зардлыг зарга мэдүүлэгч тал гаргана.
- Санал бодлоо илэрхийлсэн хэн ч болов нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулиар хариуцлага хүлээх ёсгүй.
- Төрийн байгууллагын талаархи мэдээлэлтэй холбоотойгоор уг мэдээлэл бүх талаараа үндэслэлтэй болохыг үзүүлэх нь өмгөөлөл болно.

Үнэн

- Үнэнийг хамгаалах нь нэр төр гутаахтай холбоотой хууль ба үзэл бодлын эрх чөлөөний тэнцвэрийн төв гэж хэлж болно. Олон оронд бодит баримтыг гуйвуулаагүй тохиолдолд нэр төр гутаасан асуудлаар хувь хүн хариуцлага хүлээдэггүй. Өөрөөр хэлбэл, үнэн гэдэг нь нэр төр гутаасан мэдэгдлээс бүрэн хамгаална гэсэн үг.
- Үнэнийг өмгөөлөх үндэслэлд нэр төр гутаахтай холбоотой хууль нь хүмүүс сайн нэрээ хадгалж чадсан эсэхээс илүү хувь хүн, тэдний нэр хүндийг үндэслэлгүй худал дайралтаас хамгаалахад үйлчлэх ёстой гэдэг нь багтдаг. Асуудлыг өөрөөр тавибал, чи өөрөө сайн нэрээ хадгалж чадаагүй бол түүнийгээ хамгаалж чадахгүй гэсэн үг. Хувь хүн буруутай хэрнээ өөрийнх нь тухай илэн далангүй бичиж нийтлүүлсэнийг эсэргүүцдэг гэсэн хэдий ч нэрэнд нь толбо суулгасан нийтлэлийн эсрэг заргалдаж чадахгүй. Энэ нөхцөлд харин хувь хүн өөрийнхөө хувийн амьдралын нууцыг дэлгэсэн нийтлэлийн эсрэг хувийн нууцад халдсан гэдгээр зарга мэдүүлэх эрх нь нээлттэй байдаг.
- Худал хуурмаг мэдээ мэдээллийн хуурамч болохыг нотлоход гарах зардлыг хэн хариуцах вэ гэдэг нь чухал асуудал юм. Нэр төр гутаасан асуудалд мэдээлэл хуурамч болохыг тодорхойлох нь чухал тул зарга мэдүүлэгч гомдол гаргасны хувьд зайлшгүй батлах ёстой болдог. Улмаар зарга мэдүүлэгч гомдол гаргасан хүний хувиар ихэнхдээ худал хуурмагийг нотлох баримтыг илүү амархан олдог. Төгсгөлд нь хэлэхэд, шүүгдэгчээс гаргасан гомдлын дагуу үнэнийг нотлохыг шаардах нь

өөрийн цагдан хяналтыг бий болгодог. Хувь хүн худал хуурмаг болох эсвэл худал гэж итгэж байгаа маргаантай асуудлаар бичихээс татгалзах нь шүүх хурал дээр үнэнийг нотолж чадахгүй байх гэсэн айдас, эсвэл нэр төр гутаахтай холбоотой хэргийн өмгөөллийн хөлс өндөр байдагтай холбоотой байдаг.

- *Жишээ:* АНУ-ын Дээд шүүхээс 1964 онд шийдвэрлэсэн Нью-Йорк Таймс Ко.в.Силиваны хэрэг дээр зарга мэдүүлэгч нь цагдаагийн комиссар байсан ба Нью-Йорк Таймс сонины зар мэдээлэлд цагдаа нар хэтэрхий хүч хэрэглэж байна хэмээн бичсэн нь нэр төрд сэв суулгасан гэж үзсэн. Хэдийгээр сонины зар мэдээнд зөрүүтэй баримт тусгагдсан байсан ч шүүгч Бриан шүүгдэгчийн гаргасан гомдол нь үзэл бодлоо илэрхийлэхийг баталгаажуулсан хуулийн Нэгдүгээр нэмэлтийг зөрчсөн гэж үзээд шүүх хурал дээр үнэнэ нотлохыг шаардсан.

Ийм төрлийн хуулийг удирдлага болговоос, шүүх хурал дээр үнэнийг нотолж чадахгүй гэсэн айдас, эсвэл нотлохын тулд гарах зардлаас эмээсэндээ үнэн гэж итгэж болохоор, эсвэл үнэн хэрэгтээ болсон баримтыг албаны хүмүүс ил гаргаж шүүмжлэхийг боогдуулах тал бий.

- Олон улсад мөрдөгдөж буй хэм хэмжээний дагуу төрийн ашиг сонирхлын талаар буюу тухайлбал, төрийн албан хаагчид, улс төрчдийн үйл ажиллагааны талаарх гомдлыг хэлэлцэх үед үнэнийг нотлох зардлыг ихэнхдээ зарга мэдүүлэгч гаргах болдог. Энэ нь төрийн ашиг сонирхолтой холбоотой асуудал нээлттэй байхын чухлыг хуулиар баталгаажуулж байгаа хэрэг юм.
- Энэ нь олон улсын хуулийн дагуу мэдээллийн үнэнийг нотлох асуудал хэний ч өмнө нээлттэй байхаар сайтар зохицуулагдсан гэж хэлж болно.
 - Жишээлбэл: 1992 онд болсон Испанийн Кэстлийн хэрэг дээр дотоодын шүүх байгууллага нь салан тусгаарлах үзэлтнүүдийн хөдөлгөөнд харьяалагддаг байсан хүмүүсийн амь үрэгдсэн хэргийг Засгийн газар санаатайгаар мөрдөн шалгах аас зайлсхийж байгаа талаарх зарга мэдүүлэгчийн шүүх хурал дээр үнэнийг нотлох оролдлогод зөвшөөрөл өгөхөөс татгалзсан. Европын Хүний эрхийн шүүхээс дурдахдаа:

Зарга мэдүүлэгчийн хайж олсон баримтуудыг хэргийн нотлох баримт гэж үзэхийг Дээд шүүх нь зөвшөөрсний дагуу мөрдөн шалгах ажиллагааны үр дүн ямар байсан талаар бичгээр тайлбар хийх боломжгүй ч харин Манай шүүх энэхүү төрлийн нотлох баримтыг өмгөөлөл хийхэд ашиглах боломжгүй гэж мэдэгдсэн явдалд чухал ач холбогдол өгч байна.

Үзэл бодол

- Олон улсын хуулийн дагуу үзэл бодлоо илэрхийлэх нь хуулийн хатуу хамгаалалтанд байхаар зохицуулсан ба зарим оронд үзэл бодлоо илэрхийлсний

төлөө хэн ч нэр төр гутаасан хэргээр хуулийн хариуцлага хүлээдэггүй. Энэ нь олон улсын хууль үзэл бодлын илэрхийллийг хуулийн хатуу хамгаалалтанд авсантай холбоотой. Үүнээс гадна үзэл бодлын илэрхийлэл нь бодит мэдээллийг агуулах албагүй учраас түүний үнэн худлыг нотлох шаардлагагүй байдаг.

- Хувь хүний хийсэн мэдэгдлийг үзэл бодлын илэрхийлэл гэж тодорхойлох эсэх нь заримдаа хэцүү асуултыг дагуулдаг. Хэн нэгэн хүнийг “сайн” эсвэл “муу” гэж саналаа чөлөөтэй илэрхийлсэн байлаа гэхэд өөр нэг хүнийг “гэмт хэрэгтэн” хэмээн мэдэгдсэн тохиолдлыг яаж авч үзэх вэ? Зарим үед үзэл бодлын илэрхийлэл гэж санаатайгаар ойлгогдохуйц тодорхой шинжийг агуулсан мэдэгдэл хийсэн нь байдаг. Энэ нь ихэнхдээ дэвэргэсэн аястай үг хэллэг тухайлбал, егөөдөл, хошигнол, байдлыг хэтрүүлсэн үг ярианд тохиолддог. Ерөнхийдөө, шүүх эргэлзээ төрүүлсэн мэдэгдлийн уг чанар, үзэл бодлын илэрхийлэл гэж болохоор тодорхойгүй мэдэгдлийн уршиг дагаврыг тооцоолж шүүгдэгчийн саналтай уялдуулан хэргийг шийдэх хандлага баримталдаг.

- Жишээ: 2009 онд Сербид болсон Водрозик ба Вүжинний хэрэгт Европын Хүний Эрхийн Шүүх нийтлэгдсэн зүйлийн асуулга нь хошин аястай байгааг харгалзан үзэж шийдвэрлэсэн. Үүнд дурдахдаа:

2-р зарга мэдүүлэгчийн дурдсан, сонины “Зугаа цэнгэл” буланд нийтлэгдсэн текстийн агуулга хэлбэр нь хошин аястай, С.К-гийн нэр хүндэд хонзогнон халдах зорилготой дайрсан мэдэгдэл гэж үзэхээс илүүтэй хошигнол гэж ойлгогдож буй тул Шүүхийн зүгээс буруутгах боломжгүй гэж үзсэн.

- Олон улсын хуулийн дагуу үзэл бодлоо илэрхийлсний төлөө хэн ч шүүх дээр үнэнийг нотлох шаардлагагүй байхаар хэм хэмжээг зохицуулсан байдаг.
 - Жишээ: 1999 онд Румынд болсон хэд хэдэн удаагийн залилангийн хэргийн талаарх нийтлэлтэй холбогдуулан Европын хүний эрхийн шүүхээс мэдэгдэхдээ:

Сэтгүүлч үнэнийг нотлож чадахгүйн улмаас асуудалд шүүмжлэлтэй хандаж, улмаар бичиж нийтлэх эрхээ хасуулах нь хүлээн зөвшөөрч болохгүй зүйл юм.

Үндэслэлтэй нийтлэл

- Одоогийн байдлаар тодорхой нөхцөлтэй уялдуулан худал хуурмаг мөн бодит баримтын талаарх нэр төр гутаасан мэдэгдэл нь хариуцлага хүлээхээс хамгаалагдсан байхыг хүлээн зөвшөөрөөд байгаа билээ. Хүмүүсийн мэдэх эрхийг хангахын төлөө ажилладаг хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд заримдаа мэдээ, мэдээлэл бүрийн бодит эсэхийг тодруултал хүлээн байж нийтлэх, нэвтрүүлэх боломжгүй байдаг атал тэдэнд худал хуурмаг мэдээллийн төлөө хариуцлага хүлээлгэх дүрэмтэй байдаг нь шударга бус юм. Шилдэг сэтгүүлч нар ч бодлогогүй алдаа гаргах явдал тохиолддог тул мэдээ мэдээллийг цаг тухайд нь хүлээн авах

эрхтэй олон нийтийн ашиг сонирхлыг бодолцон худал мэдээлэл түгээсэн алдааг нээлттэй орхидог.

- Европын хүний эрхийн шүүхээс 1991 онд Их Британийн (№2) “Ням гаригийн мэдээ” сонины хэргийн тухайд:

Цаг үеийн мэдээ нь шинэ сэргэг байхыг шаарддаг учраас мэдээллийг нийтлэхээс түр татгалзах, хугацаа нь хэчнээн богино байлаа ч энэ нь эргээд мэдээний үнэ цэнэ, сонирхол татах байдлыг үгүй болгож байна.

- Олон нийтийн эрх ашигтай холбоотой мэдээллийг үндэслэлтэйгээр нийтлэхийн төлөө ажилласан хүмүүсийг хамгаалах мөртөө үүнд хамаарахгүй хүмүүсийн эсрэг зарга мэдүүлэхийг зөвшөөрөх нь зохистой тэнцвэрийг хадгалсан, үндэслэлтэй нийтлэлийг хамгаалах арга гэж тодорхойлж болох юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд, хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн хэм хэмжээтэй нь уялдуулан мэдээллийн үндэслэлтэй байдлыг тооцохгүй байж болох юм.

- Европын Шүүхээс 1999 онд Норвегид болсон Владет Тромсо ба Стенсеесийн хэрэгт “сэтгүүлчийн ёс зүйгээ баримтлан олон нийтийг тодорхой, найдвартай мэдээллээр хангахыг дээдлэн ажиллах” учраас олон нийтийн сонирхлыг татаж буй сэдвээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийтэлж нэвтрүүлж болохыг зөвшөөрнө гэж үзсэн.
- Энэтхэгт 1994 онд гарсан Р.Ражагүпал ба Тамил Наду муж хэрэг дээр Энэтхэгийн Дээд шүүх шоронгийн хоригдлын бичсэн намтрыг төрийн албан хаагч нар нийтлүүлэхгүй байж болох мөртөө долоо хоног тутмын сэтгүүлд нийтлүүлсэн хойноо өөрсдийнх нь нэр төрийг гутаасан гэж зарга мэдүүлсэнд хэргийн гол учир байна гэж үзсэн. Дээд шүүхээс мэдэгдэхдээ:

Төрийн албан хаагчдын хэргийн тухайд... тэдний хийсэн үйлдлийг авч үзвэл албан үүргээс нь чөлөөлөх арга хэмжээ авбал зохистой болохоос нэр хүндэд нь сэв суулгасан үйлдэл гэж үзэх аргагүй байна. Шүүгдэгч нь нийтлэлдээ үнэнийг зориудаар гуйвуулсан гэдгийг дээрх албан хаагч нар нотолсон гэж байгаа ч уг нийтлэл нь худал хуурмаг мэдээлэл дээр үндэслэн бичигдсан байлаа ч нэр төр гутаасан гэж дүгнэх аргагүй юм гэж үзсэн.

- Өмнөд Африк: 1998 оны Үндэсний хэвлэл мэдээлэл ХХК Богочи хэрэг дээр Өмнөд Африкийн давж заалдах шатны Дээд Шүүх мөн тэнцвэрийг баримталсан хэлбэрийг баталсан. Шүүх нэр төр гутаахтай холбоотой хэргээр хатуу хариуцлага тооцохыг эсэргүүцэж, мэдэгдэхдээ “өчүүхэн алдааны төлөө гэм хохирлын хариуцлага хүлээх нөхцлийг бүрдүүлэхээс илүү хор уршигтай зүйл байхгүй” гэжээ. Улмаар “Хэрвээ хэргийн нөхцөл байдлыг авч үзэхэд, цаг хугацааг зориуд тааруулан, бодит баримтыг илтээр гуйвуулан, үндэслэлтэйгээр хэвлэн нийтэлснээс бусад тохиолдолд үнэнийг гуйвуулсан, нэр төр гутаахтай холбоотой хуурамч мэдээлэл хэвлэлд гаргасныг хууль бус гэж үзэхгүй” гэсэн.

Хэлэлцүүлэг: Үндэслэлтэй нийтлэлийг өмгөөлөх талаар та юу гэж бодож байна? Монголд энэ хэрэгжих боломжтой юу? Үүнд тогтсон тодорхой хэм хэмжээ тухайлбал, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд, дурдсаны дагуу харгалзаж үзэх мэргэжлийн онцлог юу байж болох вэ?

Өмгөөллийн бусад хэлбэр

Бусдын хэлсэн үг

- Доорх гурван нөхцөл бүрдсэн үед хувь хүн бусдын нэр төрийг гутаахтай холбоотой мэдээлэл тараасан, дамжуулан тараасан бол хариуцлага хүлээхгүй гэж үзэх ба: үүнд нэгдүгээрт, олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн хэлэлцүүлгээс хэсэгчлэн авсан мэдээлэл, хоёрдугаарт, хувь хүн мэдээллийг баталгаажуулахаас татгалзсан, гуравдугаарт, бусдын хийсэн мэдээллийг дамжуулсан нь тодорхой байгаа нөхцөлд хариуцлага хүлээхгүй.
- Энэхүү өмгөөлөл нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл цаг үеийн мэдээ дамжуулах үүрэгтэйн улмаас мэдээн дотроо бусдын нэр хүндэд халдсан мэдээ мэдээлэл оруулж болзошгүйг хүлээн зөвшөөрдөг. Улмаар, сэтгүүлчид өөрсдийгөө эвгүй байдалд оруулах мэдээ дамжуулахаас зайлсхийх ёсгүй, эсвэл мэдээ бүрийн үнэн зөвийг шалгах ёсгүйг хүлээн зөвшөөрнө.
 - *Жишээ:* 2001 онд Люксембургт гарсан Томагийн хэрэгт радиогийн сэтгүүлч Люксембургийн наян ойн байцаагчдаас зөвхөн нэг хүн авлига аваагүй тухай мэдээлсэн сонины нийтлэлийг иш татан дурдсан. Шүүхээс сэтгүүлчийг шийтгэсэн нь тухайн хүний үзэл бодлын илэрхийллийг боогдуулж байна гэж үзэн мэдэгдэхдээ:

Өөр хүний хийсэн мэдээллийг дамжуулахад тусалсны төлөө сэтгүүлчид шийтгэл ноогдуулжээ. ...Үндэслэлтэй шалтгааны улмаас энэ хэргийг хийгээгүй нь тодорхой бол энэ нь олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн хэлэлцүүлэгт хэвлэл мэдээлэл хувь нэмрээ оруулах боломжийг ноцтойгоор боогдуулсан хэрэг болно.. гэж үзсэн.

Давуу эрхтэй нөхцлүүд

- Чөлөөтэй ярих нь зайлшгүй шаардлагатай тодорхой хэд хэдэн нөхцөлд хийсэн мэдэгдлийнхээ төлөө нэр төр гутаасан хэргээр хэзээ ч хариуцлага хүлээдэггүй. Иймэрхүү “давуу эрхтэй” нөхцөлд жишээлбэл, шүүхийн өмнө хийсэн мэдэгдэл, сонгогдсон гишүүдийн өмнө хэлсэн үг, энэ төрлийн мэдээллийн тухай тайлан тооцогдоно. Өөр бусад, хэд хэдэн төрлийн мэдэгдэл “давуу эрх” эдлэх ба үүнд, хүнд өвчтэй, гомдсон үедээ хэлсэн үг болох нь батлагдвал хариуцлага хүлээхгүй өнгөрдөг. Энэ төрөлд мөн үг хэлсэн этгээд хуулийн, ёс суртахууны, нийгмийн хариуцлагаа ухамсарлан хийсэн мэдэгдэл багтдаг. Жишээ нь, хэн нэгнийг гэмт хэрэгт сэжиглэн цагдаагийн газарт мэдэгдсэн байж болно.

- *Жишээ:* Европын хүний эрхийн шүүх хууль тогтоох байгууллага, парламент дээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь чухал болохыг хүлээн зөвшөөрч, энэхүү дархан эрхийн зорилгыг доорхи байдлаар дурдсан.

Эдгээр гишүүдэд шүүх, түүнтэй дүйцэх эрх мэдэл бүхий байгууллагын өмнө буруутан болох аюулаас зайлсхийхийн тулд өөрсдийн хэлэх үгийг найруулан засах, дүгнэлтээ хянаж цэнэлгүйгээр олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудалд шүүмжлэлтэй хандах, учир утгыг тунгаасан хэлэлцүүлэгт оролцох боломжийг олгох хэмээн тодорхойлсон. (2002, Нэгдсэн Вант Улс)

- 2008 онд Финляндад болсон Жубалагийн хэрэгт зарга мэдүүлэгч нь эмчийг хүүхдийн хүчирхийлэлд сэжиглэж байгаагаа мэдээлсний улмаас нэр төр гутаасан хэрэгт холбогдсон. Шүүхээс хувь хүний үг хэлэх эрхийг өмгөөлөх үүднээс буулт хийж, уг мэдээллийг сайн сэтгэлийн үүднээс хийсэн гэж үзсэн.

Торгуулийн өр төлбөрт орох, эсвэл, нэр төрд сэв суулгасны төлөө нөхөн төлбөр төлөх, эрүүгийн хэрэгт холбогдох зэргээс эмээлгүй аливаа нэгэн хувь хүн иймэрхүү төрлийн мэдээлэл өгөх боломжийг нээлттэй байлгах үүднээс хүүхдийн хүчирхийлэлд буруутгасан дээрх мэдээллийг сайхан сэтгэлийн үүднээс хийсэн гэж үзсэн байна.

3. Шийтгэл ногдуулах

- Мэдэгдлийг нэгэнтээ нэр төр гутаасан гэж үзээд шийтгэл ногдуулахаар заах нь эргээд үзэл бодлын илэрхийлэлд заналхийлж эхэлдэг. Хэт хатуу шийтгэл нь зөвхөн хориотой материал нийтэлсэн тохиолдолд нөлөөлөөд зогсохгүй сэтгүүлчид ба бусад хүмүүсийн хэлэх эрхийг хязгаарлаж үүгээрээ хууль зөрчихөд хүргэж болох юм. Олон улсын хуулийн дагуу хэт хатуу шийтгэл ногдуулах нь өөрөө үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчиж байгаа хэрэг гэж үздэг. 2011 оны НҮБ-ын Хүний эрхийн хорооны Ерөнхий тайлбарт дурдахдаа:

Улс орнууд хэт хатуу шийтгэл ногдуулах, мөн их хэмжээний торгууль төлүүлэхээс зайлсхийх талаар санаа тавих хэрэгтэй. Үүний дагуу, улс орнууд шүүгдэгчээс ялсан талд төлөх торгуулийн хэмжээнд үндэслэлтэй хязгаарлалт тавих ёстой.

- Энэ нь нэр төр гутаасан хэргийн нөхөн төлбөрийг тодруулж өгсөн хэрэг юм. 2000 оны Хамтарсан тунхаглалын олон улсын тусгай илтгэлд дурдахдаа: “Иргэний хуулийн нэр төр гутаасан хэргийн шийтгэл нь үзэл бодлын илэрхийлэлд сөрөг нөлөө үзүүлэхээр дааж давшгүй их байх ёсгүй, гутаагдсан нэр хүндийг сэргээх боломжийг бүрдүүлсэн, зөвхөн зарга мэдүүлэгчид нөхөн төлбөр олгохын тулд

хийгдээгүй, торгуулийн хэмжээг учруулсан хохирлын хэмжээтэй уялдуулан нарийн тооцоолсон байх ёстой” гэжээ.

- *Жишээ:* 1995 онд Нэгдсэн Вант улсад гарсан Толстой Миловскийн хэрэг дээр Европын хүний эрхийн шүүх нэр төр гутаасан хэрэгт хэт их торгууль ногдуулсан нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг зөрчсөн байна гэж үзсэн. Түүхч Николай Толстой Миловскийг нэр төр гутаасан хэргээр буруутгаж, Английн шүүхээс түүнд өмнө нь тавигдаж байсан торгуулийн хэмжээнээс гурав дахин их буюу 1,5 сая еврог зарга мэдүүлэгч талд төлөх торгууль ногдуулсан. Европын Шүүх гүтгэлгийн ноцтой байдлыг хүлээн зөвшөөрсөн хэдий ч 1,5 сая еврогийн торгуулийг хэт хатуу шийтгэл гэж үзсэн.
- Торгуулийн хэмжээг бага тогтоох, түүнтэй дүйцэхүйц бусад төрлийн шийтгэл ногдуулах, ялангуяа торгууль ногдуулахаас зайлсхийж хэвшвэл зохилтой. 2000 оны Хамтарсан Тунхаглалд “төрөл бүрийн торгууль ногдуулах шийтгэлээс зайлсхийсан хуулийг хэвшүүлж мөрдөх тухай” дурдсан байдаг.
- Нийтлэл бичсэн хүнээр залруулга, хариу няцаалт хийх эрхийг нээлттэй үлдээх нь торгуультай дүйцэхүйц бусад төрлийн шийтгэлийн боломжтой нэг сайн жишээ байж болох юм. Буруу ташаа мэдээллийн зөв хувилбарыг нийтлэх эсвэл алдаатай зүйлийг үнэн мэдээллээр солих нь нэр төрд нь сэв суулгахаар тухайн хүнд шууд хандсан хов жив, гүтгэлгийг “өөр өнгө аястай” нийтлэлээр залруулж байгаа хэрэг юм.
- Дээр дурдсанчлан, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөрийн зохицуулалтыг хэрэглэн нэр төр гутаасан үйлдлийг залруулах нь бас нэгэн чухал хувилбар билээ.

Хэлэлцүүлэг: Монголд нэр төр гутаасан хэргийн нөхөн төлбөр ба торгуулийн хэмжээ хэт их байдаг уу? Энэ нь үзэл бодлын илэрхийлэлд сөрөг нөлөө үзүүлдэг үү? Нөхөн төлбөрийг яаж буулгаж болох вэ?

4. Нэр төр гутаасан үйлдлийг өмгөөлөх

- Шаардлага тулгарсан үед, нэр төр гутаасан хэргийн буруутныг хэрхэн өмгөөлөх нь нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай, эдгээр хэргүүд нь олон талтай учраас хэргийг тогтсон томъёололоор шийдэх боломжгүй. Гэхдээ уг асуудлыг шийдэхэд дагаж мөрдөх хэд хэдэн зөвлөмж бас байдаг.
- Нэгдүеэр асуудал нь зарга мэдүүлэгчийн гаргасан гомдол үндэслэлтэй эсэхийг тодруулах өөрөөр хэлбэл, зарга мэдүүлэгчийн хэлж байгаачлан, үнэхээр нэр төр гутаасан агуулгатай мэдээлэл мөн эсэхийг нягтлах хэрэгтэй. Шүүгдэгч мэдээлэл яагаад тааламжгүй байгаагийн учрыг зарга мэдүүлэгчээс тодруулах, улмаар энэ нь нэр төр гутаахаас өөр ангид утга агуулсан гэдгийг хэлж болно. Үүнтэй холбоотой хэд хэдэн асуудал байдаг.

- Үүнд: шүүгдэгчийн тараасан мэдээлэл нь зарга мэдүүлэгчийн хэлж байгаа санааг агуулаагүй, жишээ нь, шүүгдэгчийн тараасан мэдээллийг учир ойлгох бусад хүмүүс егөөдөл, хошигнол гэж ойлгосон хэмээн эсэргүүцэх, эсвэл зарга мэдүүлэгчийн ойлгосноос өөр утгатай, үг өөрөө салаа утгатай байдаг учраас ихэнх тохиолдолд буруу ойлголцох явдал гардаг гэх мэт.
- Шүүгдэгч нь мөн зарга мэдүүлэгч талд алдах нэр хүнд байгаагүй хэмээн эсэргүүцэх, тухайлбал хаа яваа газраа худал ярьж явдаг хүнийг худалч гэж хэлсний төлөө тухайн хүний нэр төрд сөв суулгасан гэж үзэх аргагүй
- Шүүгдэгч мөн тараасан мэдээлэлд нэр төр гутаасан асуулга байгаагүй хэмээн эсэргүүцэж болно

Жишээ: Тайландад гарсан хэргийн тухайд, эхэндээ Ерөнхий сайдын өмчид байсан бизнесийг дараа нь эхнэр болон бусад хамаатнууд нь эзэмшиж улмаар Ерөнхий сайдын ивээл дор улам их ашиг олсон тухай мэдээлэл тараасан хүнийг шүүхэд өгсөн. Гэхдээ Ерөнхий сайд биш харин нэр дурдагдсан компани нь заргалдсан. Шүүгдэгч компанийн нэр хүнд гэдэг нь бизнесийн нэр хүнд учраас (мөнгө олох чадвартай холбоотой) Ерөнхий сайдын гар хөл болсон тухай мэдээлэл харин ч компанид ашигтай байсан хэмээн эсэргүүцсэн. Нэр төр гутаасан асуудал Ерөнхий сайдтай холбоотой учраас тэрээр өөрөө зарга үүсгэсэн бол байдал өөрөөр эргэх байлаа.

- Өмгөөлөгч мөн хэргийг өөр тийш нь залж болох бүх үндэслэлийг харгалзах хэрэгтэй. Төрийн байгууллага зарга мэдүүлсэн бол яахав? Шүүгдэгч үнэхээр тэр мэдээллийг хийснийг баталсан юм уу? Олны өмнө хэлсэн эсэх?
- Дараагийн асуудал бол шүүгдэгч өмгөөлөх аргад найдах явдал юм. Хамгийн боломжтой нийтлэг өмгөөлөх арга бол үнэнийг хамгаалах байдаг. Дахин хэлэхэд, үүнд ялгаатай асуудал бий. Тухайлбал:
 - Шүүгдэгч хэлсэн бүх зүйл нь үнэн гэдгийг батлах албагүй, зөвхөн нэр төр гутаасан асуудлыг л авч үзэх хэрэгтэй. Шүүгдэгчийн бичсэн түүх ор үндэсгүй байлаа ч зарга мэдүүлэгчийн нэр хүндэд халдсан мэдээлэл гутаасан агуулгагүй байж болох талтай.
 - Улсын ашиг сонирхол хөндөгдсөн мэдээлэл бүхий хэргийн тухайд, ялангуяа зарга мэдүүлэгч нь нотлох баримт бүрдүүлэх боломжтой нөхцөлд байгаа бол мэдээлэл хуурмаг болохыг батлахыг шаардах
 - Хэрвээ мэдээлэл бодитой үнэн бол батлахад амар. Жишээ нь, шүүгдэгч 10000 ам.долларын бизнесийн гүйлгээ хийнэ гэсэн зарга мэдүүлэгчийг худалч хэмээн мэдэгдсэн бол нэр төр гутаасан хэргийн гол учиг нь зарга мэдүүлэгчийн худалч болохыг батлахад оршино. Зарга мэдүүлэгч нь хэрэг дээрээ худал хэлсэн байж болно. 8000 ам.долларын гүйлгээ хийсэн гэж ярьсан хүн (үнэн хэрэгтээ зөвхөн 5000 ам.доллар шилжүүлсэн) байвал үндсэн мэдэгдэл нь өөрөө эргээд зарга мэдүүлэгчийн хэлсэн үгийн бодитой эсэхэд эргэлзэхэд хүргэдэг.

- Өмгөөллийн өөр нэг арга нь мэдээлэл бодит байдлыг хөндөөгүй зөвхөн үзэл бодлын илэрхийлэл байсныг батлах юм. Нөхцөл байдал бүрхэг үед шүүхээс мэдээллийг үзэл бодлын илэрхийлэл гэж үзэх хандлага давамгайлдаг. Өмгөөлөгч бүх нөхцөл байдлыг харгалзан үзэж, үүн дотроо тараасан мэдээлэл нь хошигносон, ёжилсон утгатай эсвэл утга зохиолын өөр хэлбэр ашигласан, утга шилжсэн үг, зүйрлэл ч байж болох талтайг нотлон харуулж болох юм.
 - *Жишээ:* 2001 онд Словакийн Фелдект гарсан хэрэг. Европын хүний эрхийн хороо зарга мэдүүлэгчийн гаргасан гомдолд “фашистын үлдэгдэл” гэсэн үг нь тухайн хүнийг фашист үзлийг сурталчилсан үйл ажиллагаанд оролцдог хэмээн доромжилсон гэж үзсэнтэй санал нийлээгүй. Үүнийг тухайн хэллэг нь түгээмэл хэрэглэгддэг, өөр утга агуулж байж болох талтайг тайлбарласан.
- Үндэслэлтэй нийтлэлийг өмгөөлөх нь тухайн нөхцөл байдлаас хамааралтай өмгөөллийн нэг хэлбэр юм.
 - *Жишээ:* Рейнолдын Таймс сонин ба бусад (1999 он)
Английн Лордуудын танхим нийтлэл үндэслэлтэй эсэхийг шийдэх жагсаалт гаргаж арван хүчин зүйлийг тодорхойлон заасан. Үүнд:
 - i. Мэдээлэл ноцтой эсэх. Хуурамч мэдээ мэдээллийн улмаас хувь хүн хохирсон эсэх, олон нийт буруу мэдээлэл авсан эсэх, хор хохиролтой эсэх
 - ii. Мэдээллийн агуулгыг тодорхойлох, сэдэв нь ямар асуудлыг хөндсөн олон нийтэд холбоотой асуудал байгаа эсэх,
 - iii. Мэдээллийн эх сурвалж. Зарим шүгэлдэгч болсон явдлын талаар шууд бус эх сурвалжаас мэдээлдэг. Зарим нь өөрийн өнцгөөс асуудалд хандсан, зарим нь мэдээллийнхээ төлөө мөнгө авсан байдаг.
 - iv. Эх сурвалжаа нягтлах талаар ямар алхам хийснийг мэдэх
 - v. Мэдээллийн статус. Мэдэгдэл нь заримдаа эрэн сурвалжлах ажиллагааны сэдэв болж, нөхцөл байдлыг нь сайтар тодруулсан байдаг.
 - vi. Мэдээлэл яаралтай эсэх. Цаг үеийн мэдээ нь дороо ач холбогдолоо алддаг.
 - vii. Зарга мэдүүлэгчийн талаас тайлбар хүссэн эсэх. Тухайн хүнд өөр мэдээлэл байсан эсвэл түүнийгээ задруулахыг хүсээгүй байж болох. Зарга мэдүүлэгчид заавал хандах албагүй байж болно.
 - viii. Зарга мэдүүлэгчийн өнцгөөс асуудалд хандсан агуулга байгаа эсэх
 - ix. Мэдээллийн өнгө аяс. Сонины газар асуулга явуулсан эсвэл эрэн сурвалжлага хийн утасдсан байж болно. Энэ нь мэдээллийг баримтын талаарх мэдэгдэл гэж хүлээж авах эсэхийг тодруулдаг.
 - x. Нийтлэлийн нөхцөл байдал үүнд цаг хугацаа орно.

Хэлэлцүүлэг: Энэ жагсаалтын талаарх таны санал? Танд жагсаалтанд нэмэх санал байна уу?


Ашигласан материал

1. Нэр төр гутаахтай холбоотой ухагдахууныг тодорхойлох нь: Нэр хүнд хамгаалах ба үзэл бодлын эрх чөлөө (Лондон: 19 зүйл, 2000 он) Цахим хаяг:
<http://www.article19.org/pdfs/standards/definingdefamation.pdf>
2. Нэр төр гутаах ABC: Нэр төр гутаахтай холбоотой хуулийн гол үзэл баримтлалтай танилцуулах нь (Лондон: 19 зүйл, 2006 он) Цахим хаяг:
<http://www.article19.org/pdfs/tools/defamation-abc.pdf>
3. НҮБ-ын Үзэл бодлын илэрхийллийн эрх чөлөөний асуудлаарх Тусгай Илтгэгч ба Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Хэвлэлийн эрх чөлөөний Төлөөлөгч ба Америкийн Муж улсуудын байгууллагын үзэл бодлын эрх чөлөөний асуудлаарх Тусгай Илтгэгчийн 2000 оны 11 сарын 30-нд гаргасан Хамтарсан Тунхаглал. Цахим хаяг:
4. <http://www.unhchr.ch/hurricane/hurricane.nsf/view01/EFE58839B169CC09C12569AB002D02C0?open document>

Модуль 5: Мэдээлэл авах

- Иргэд төрийн байгууллагаас гаргасан аливаа мэдээллийг авах мөн төрийн байгууллагад иргэн хүнийг мэдээллээр хангах үүргийн ноогдуулдаг энэхүү мэдээлэл авах эрхийг (RTI) мөн мэдээллийн эрх чөлөө эсвэл мэдээлэл авах зэргээр нэрлэдэг.
- Энэ эрхийг хамгаалах хоёр үндсэн арга байдаг. Үүнд:
 - *Мэдээллийг нээлттэй байлгах*: Хувь хүн асууж сураглах шаардлагагүй төрийн байгууллагууд санаачлагаараа гол хэрэгтэй мэдээллийг нээлттэй байлгах
 - *Мэдээллээр хангах*: Хувь хүн мэдээлэл хүсэх эрхтэй ба хүссэн мэдээллээ авах ёстой.
- Мэдээлэл авах эрхийг Үндсэн Хуулиар баталгаажуулж өгөх нь амьдралд нийцтэй туршлага байдаг ч Үндсэн хуулинд нарийвчлан заагаагүй бусад зүйлийг тодруулахын тулд энэхүү эрхийг хүчин төгөлдөр болгох тухай хууль тогтоомж зайлшгүй шаардлагатай. (үүнд хүсэлт тавих процесс, хаалттай мэдээллийн хэлбэрүүд гэх мэт) (онцгойлох тохиолдол)
 - Өнөөгийн байдлаар дэлхийд 100 орон мэдээлэл авах эрхийн хуультай ба үүнд Зүүн Азийн дөрвөн орон (Хятад, Япон, Монгол, Өмнөд Солонгос, Тайван) мөн Зүүн Өмнөд Азийн хоёр орон (Индонези, Тайланд) багтдаг.

Figure 1. Chronological Development of RTI Laws



Source: [RTI Rating](#) by the [Centre for Law and Democracy](#) and [Access Info Europe](#).

- Эрх зүй ба Ардчилал төв, мөн Европын мэдээлэл авах байгууллага гэсэн хоёр ТББ хамтран мэдээлэл авах эрхийн хууль эрх зүйн орчны чанарыг үнэлэх боломжтой мэдээлэл авах эрхийн зэрэглэл (www.RTI-rating.org) хэмээх боловсронгуй аргачлалыг зохиосон юм. Мэдээлэл авах эрхийн зэрэглэлийг энэхүү эрхийн олон улсын хэм хэмжээ, мөн үндэсний туршлагад тулгуурлан хийсэн билээ. Доорх хүснэгтэд үзүүлснээр мэдээлэл авах эрхийн зэрэглэл нь энэхүү эрхийн талаарх хуулиудын чанарыг мэдээлэл авах эрх, хамрах хүрээ, хүсэлт тавих процесс, онцгойлох ба татгалзах тохиолдол, давтан хүсэх, зөвшөөрөл ба хамгаалах сурталчилгааны арга хэмжээ гэсэн голлох долоон үзүүлэлтээр дүгнэсэн болно.

Үзүүлэлт	Дүгнэх оноо
1. Мэдээлэл авах эрх	6
2. Хамрах хүрээ	30
3. Хүсэлт тавих процесс	30
4. Онцгойлох ба татгалзах тохиолдол	30
5. Давтан хүсэх	30
6. Зөвшөөрөл ба хамгаалах	8
7. Сурталчилгааны арга хэмжээ	16
Бүх оноо	150

- Онооны шалгуур хатуу байгаагүйг бодолцож үзвэл, үзүүлэлтүүд үндэслэлтэй гэж хэлж болох ба дээрх зэрэглэлийн дагуу маш өндөр оноо авах боломжтой байсан. Жагсаалтын хамгийн өндөр оноог 150-аас 135 оноо авсан Серби улс эзэлсэн бол удаах байрт 130 оноо авсан Энэтхэг, Словени улсууд орсон билээ. Мөн маш бага оноо авах нөхцөл бүрдсэн байсан тул Австри, Лихтенштейн улсууд хамгийн муу буюу дөнгөж 37 ба 39 оноо авсан байна.
- Өнөөгийн байдлаар ихэнх орнууд үүнийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пактын 19 дүгээр заалтаар баталгаажсан мэдээлэл ба шинэ санааг эрж хайх, хүлээн авах эрхийн нэг хэсэг зайлшгүй хамгаалах ёстой эрх болохыг хүлээн зөвшөөрөөд байгаа билээ. Олон улсын хуулийн дагуу энэ нь зөвхөн ярьсан төдийгүй сонссон хүний үзэл бодлын илэрхийллийн эрх хамгаалагддаг. Энэ нь мэдээлэл авах эрхийг хүлээн зөвшөөрөхийн үндэс болдог.
- НҮБ-ын Хүний эрхийн хорооноос 2011 онд гаргасан Ерөнхий тайлбарын 19 дүгээр зүйлд:

“19 дүгээр зүйлийн 2 дугаар заалт нь төрийн байгууллагаас гаргасан мэдээллийг иргэн хүн авах эрхийг дэмжиж байна” гэжээ

1. Мэдээллийн ашиг тусын талаар

Хэлэлцүүлэг: Мэдээлэл авах эрх яагаад чухал гэж та бодож байна? Монголын нөхцөлд эдгээрээс аль нь илүү чухал вэ? Мэдээлэл авах эрхийн тухай Монголын хууль зарим талаараа эсвэл бүх талаараа ашиг тустай болно гэдэгт та итгэж байна уу?

- Төрийн байгууллага мэдээллийг өөрсдөдөө зориулах бус харин олон нийтийн сайн сайхны гаргадаг гэсэн гол санаа мэдээлэл авах эрхийн цаана агуулагдаж байдаг. Төрийн байгууллага мэдээллийг хав даран өмчлөх ёсгүй, харин олон нийтэд түгээх хэрэгтэй. Иргэд мэдээлэл авах эрхээ эдэлсний давуу тал буюу ашиг тусыг доор дурдвал:
 - а. *Ардчилсан оролцоо:* Ардчиллын бүх шатанд мэдээлэл авах эрх нь зайлшгүй чухал. Иргэд өөрсдийн амьдралд нөлөөлөх асуудлаар шийдвэр гаргахад идэвхтэй оролцох боломж нь ардчиллын үндэс суурийг бүрэлдүүлж байдаг. Ардчилсан орнууд иргэдийн оролцооны төрөл бүрийн механизмтай байдаг ба үүний хүрээнд тухайлбал, бүх нийтийн боловсрол, эрүүл мэндийн асуудлаар иргэд хяналтын шатанд төлөөлөгчөө сонгох, хуулийн төсөл, бодлогын баримт бичиг саналаа өгөх боломжтой байдаг. Иргэд ийнхүү бүх шатанд идэвхтэй оролцох нь мэдээлэл авах тодорхой мөн шударга арга зам болдог. Саналаа өгөх нь зүгээр нэг техникийн асуудал төдий зүйл биш юм. Иргэд саналаа өгснөөр ногдсон үүргээ биелүүлж улмаар олон улсын хуулинд тодорхойлон заасан “Засгийн эрх баригчдын үйл ажиллагааны үндэс нь иргэдийн хүслийг дээдлэх явдал” мөн гэсэн заалтыг хангана. Ийм ч учраас сонгогчид заавал мэдээлэл авах ёстой. Энэ нь мөн иргэдийн бүх шатны оролцоог хангаж өгнө. Жишээлбэл, санал болгосон зүйлийн үндсийг мэдэхгүй, бодлогын баримт бичигтэй танилцаагүй иргэд тухайн бичигт өөрсдийн хэрэгтэй саналыг тусгуулах боломжгүй юм.
 - б. *Хэвлэл мэдээллийн үүрэг:* Дээрхтэй нягт холбоотойгоор ардчилсан нийгэмд хэвлэл мэдээллийн хэрэгсэл голлох үүрэгтэй байдаг. Мэдээлэл авах эрх нь мэдээлэл олж авахын зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг. Цаг үеийн мэдээ нь зөвхөн шинэ санаа төдийгүй бодит мэдээллийг дамжуулдаг. Ардчилсан засаглал, нийгмийн ашиг тусын тулд мэргэжлийн чадварлаг сэтгүүл зүй нь засгийн газрын үйл ажиллагаа мөн олон нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар тууштай, урьдчилан таамагласан мэдээлэл авах эрхтэй байдаг.
 - в. *Авлига:* Засгийн газрын буруутай үйл ажиллагаа ба авлигатай тэмцэхэд мэдээлэл авах эрх нь гол хөшүүрэг болж өгнө. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй ба хэвлэл мэдээллийн чиглэлийн ТББ-ууд мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хүрээнд засгийн газрын буруутай үйл

ажиллагааг илчилж байдлыг засч залруулахад тусалдаг. Америкийн Дээд шүүхийн шүүгч Луйс Брэндейсийн хэлсэнчлэн “Нийгмийг эрүүлжүүлэхэд үнэний төлөө дуу хоолой цөөддөггүй”.

- d. *Хариуцлага*: Сайн засаглал ба хариуцлагын систем нь ардчиллын салшгүй хэсэг. Олон нийт удирдагчийнхаа явуулж буй үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй ба энэ хүрээнд бүхий л төрлийн арга хэмжээ мөн нээлттэй хэлэлцүүлэгт оролцох ёстой. Иргэд Засгийн газраас явуулж буй бодлогод дуу хоолойгоо нэмэрлэхэд олон нийттэй холбоотой асуудлууд ба нийгмийн систем, эдийн засгийн талаарх мэдээллийн ил тод байдлаас шууд шалтгаалдаг. Ялангуяа засаглалын доройтолтой холбоотой асуудлыг нээлттэй, ил тод мэдээлэл бүхий хэлэлцүүлгээр авч үзэх нь үр дүнтэй аргын нэгд тооцогддог.
- e. *Хувь хүнд ямар ашигтай тухай*: Судлаачид мэдээлэл авах эрхийн улс төрийн шинжид илүү анхаарал тавьдаг ч энэ нь хувь хүний нийгмийн олон асуудал, тухайлбал, төрийн үйлчилгээний хүрээнд хувь хүнтэй холбоотой мэдээллийг засч залруулах, эрүүл мэндийн болон бусад төрлийн үйлчилгээний талаар мэдээлэл хүсэхэд тусална. Хувь хүний тухай мэдээлэл авах нь тухайн хүний нэр хүндийн салшгүй нэг хэсэг хэдий ч, хүн хувийн асуудлаа шийдвэрлэхэд зонхилох нөлөөтэйг үгүйсгэх аргагүй. Жишээ нь, ихэнх тохиолдолд хүний эрүүл мэндийн талаарх мэдээллийг хуулийн хүрээнд нууцалсан байдаг ч энэхүү мэдээлэл нь өөрөө хувь хүн эмчилгээ болон санхүүгийн асуудлаа төлөвлөхөд тусалдаг.
- f. *Бизнес*: Төгсгөлд нь хэлэхэд, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн талаар байнга орхигдуулдаг нэг асуудал бол энэхүү эрхийг бизнесийн үйл ажиллагаанд үр дүнтэйгээр хэрэглэх явдал юм. Ихэнх улс оронд бизнес эрхлэгчид хамгийн гол хэрэглэгчдийн бүлэгт хамаарна. Бизнес эрхлэгчдэд маш хэрэгтэй эдийн засгийн асуудалтай холбоотой бүхий л төрлийн мэдээлэл төрийн байгууллагуудад хадгалагдаж байдаг. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн чухал ашиг мөн засгийн газраас энэхүү хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлсний үнэ цэнийг үүгээр тайлбарлаж болно.

2. Гол зарчмууд

- Мэдээлэл авах эрх нь нээлттэй байх боломж эсвэл мэдээллийн үнэн бодит байдал дээр үндэслэдэг. Олон нийтийн мэдээлэл авах боломжийг удирдлага болгон мэдээлэл авах эрхийн зарчмыг тодорхойлох ба мэдээллийн бодит байдалтай холбоотой аливаа гомдол саналыг авч хэлэлцэх нь мэдээлэл хаалттай байхаас үүсэх дарамтыг зөвтгөхөөс хавьгүй хялбар юм. Олонх хэрэг дээр энэ нь төрийн

байгууллагад одоог хүртэл байсаар байгаа нууцын талаар өмнө оршиж байсан ойлголттой зөрчилддөг.

- Сайн боловсруулсан мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн гол цөм нь дараах таван зарчим байдаг.

а. *Хамрах хүрээ*: Мэдээлэл авах эрхийн хууль нь ил тод мэдээлэл үнэн бодит байхыг баталгаажуулах ёстой. Энэхүү бодит мэдээллийн зарчим төрийн бүх байгууллагад хамаатай, мөн тэдгээр байгууллагаас гаргасан бүх мэдээлэлд хамаатай юм.

- *Жишээ*: Шведийн Ерөнхий сайдын компьютерын cookies мэдээллийг шалгах хүсэлт ирсэн. Хүсэлтийг ёсоор болгож, мэдээллийг нээлттэй болгосон ч үнэн хэрэгтээ түүний компьютер дээр ямар ч мэдээлэлбайгаагүй. Өөрөөр хэлбэл, тухайн үед Ерөнхий сайд интернет ашиглаагүй байсан. Энэхүү эрх нь мэдээллийг хэрхэн авснаас үл шалтгаалан бүх төрлийн мэдээллийг ил тод болгож болохыг дээрх жишээ харуулж байна.

б. *Шуурхай мэдээлэл*: Энэхүү хуулиар олон нийтэд чухал ач холбогдолтой бүхий л төрлийн мэдээллийг шуурхай, автоматжуулсан хэлбэрээр мэдээлж байх үүргийг төрийн байгууллагуудад ногдуулах хэрэгтэй. Мэдээлэл хүсэх ба хүлээн авах эрх нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн гол цөм байдаг хэдий ч, олон нийтийг мэдээллээр хангахад мэдээллийн шуурхай автоматжуулсан хэлбэр үүнээс дутахгүй чухал ач холбогдолтойд тооцогдоно. Төрийн байгууллагын талаарх анхан шатны ерөнхий мэдээлэл ялангуяа мэдээлэл авах талаар ямар нэг оролдлого хийхийг боддоггүй иргэдийн дийлэнх хэсэгт хүрэх боломжтой. Мэдээллийн автоматжуулсан хэлбэр нь орчин үед олны анхаарал татаад байгаа төдийгүй ихэнх орнуудын төрийн байгууллага шуурхай, дэлгэрэнгүй мэдээллийг иргэдэд хүргэх үүрэг хүлээх болсон юм.

- *Жишээ*: Энэтхэгт Мэдээлэл авах эрхийн хуулийн 4 дүгээр заалтаар шуурхай хүргэх ёстой 17 төрлийн мэдээллийг баталсан ба үүнд төрийн үйлчилгээний албан хаагчдын сар тутмын дэс дугаар, мөнгөн тэтгэмж олгох арга, тэтгэмжийн мөнгөний зөвшөөрөгдсөн хэмжээ, тэтгэмжид хамрагдах хүмүүсийн талаарх нарийвчилсан мэдээлэл, шийдвэр гаргах процессоос улбаатай дүрэм журам, шалгалт, хариуцлагын арга хэлбэр зэрэг ордог.

с. *Журам*: Хуулиар мөн мэдээлэл авах тодорхой журмыг батлах хэрэгтэй. Энэ тухай дурдах нь илүүц мэт боловч үнэн хэрэгтээ энэ нь мэдээлэл авах эрхийн хуулийг амжилттай хэвшүүлж мөрдөхөд үндэс суурь болдог. Хуулийн дагуу, жишээлбэл, иргэдийн хүсэлт гаргах хэлбэрийг хялбаршуулж, (иргэд хүсэлтээ цахим болон очиж уулзах маягаар өгч болох ба шаардлагатай үед иргэдэд хүсэлт тавих маягтыг бөглөж өгөх) мөн хариу

авах хугацааг тодорхой заах, хүсэлтэд хариу өгөх боломжгүй шалтгааныг тайлбарлан мэдэгдэх, дор хаяж мэдээллийн үйлчилгээний хураамж төлөх арга хэлбэрийг тоймлон мэдээлбэл зохино.

d. *Онцгой нөхцлүүд*: Хууль мөн мэдээлэл өгөхөөс татгалзаж болзошгүй онцгой нөхцлүүдийг нарийвчлан тогтоож, улмаар онцгой нөхцлийн дүрмийг тодорхойлж өгөх нь маш чухал юм. Энэ нь нэг талаасаа эрх зүйн хүрээнд нууцлалыг хуулиар хамгаалж байгаа ач холбогдолтой зүйл. Мөн нөгөө талаасаа олон орны мэдээлэл авах эрхийн тухай хуулийн цоорхойг батлан харуулж байгаа хэрэг юм.

- *Жишээ*: 2000 онд баталсан Английн Мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн баримт бичиг нь олон талаараа сайн боловсруулсан хууль тогтоомж гэж тооцогддог. Гэсэн хэдий ч энэхүү хуулинд онцгой нөхцлүүд маш их, бүхэлдээ 22 төрлийн онцгой болон хориглосон заалттай байгаа нь мэдээлэл авах журмыг үндсэнд нь алдагдуулсан.

Мэдээлэл авах эрхэнд онцгой нөхцлүүд гэсэн заалтууд оруулсныг үзэл бодлын эрх чөлөөний хязгаарлалттай адил гурван талт шалгуураар авч үзэх хэрэгтэй. Нэгдүгээрт, мэдээлэл авах эрхэнд сөргөөр нөлөөлж байгаа хууль ёсны эрх ашиг гэдэг нь юу болохыг хуулиндаа сайн тусгах ёстой. Үүнд төрөл зүйл гэхээсээ урьдаар ямар эрх ашиг байгааг дурдах нь зүйтэй юм. Жишээ нь, нууцлах материалын тоонд хувь хүний эмчилгээ гэхээс илүү үндэсний аюулгүй байдал чухал, гэтэл цэрэг армийн талаарх мэдээлэл бас чухал гэх мэтээр эрх ашгийг бодолцоно. Хоёрдугаарт, нээлттэй мэдээлэл зөвхөн хууль ёсны эрх ашигт хор хөнөөл учруулж болох тохиолдолд мэдээллийг нууцлах ёстой. Хор хөнөөл нь үнэхээр хүндэтгэж үзэхээс аргагүй байх ёстой. Дотоод асуудлаар шийдвэр гаргахад төвөг учруулах байвал чөлөөтэй, илэн далангүй зөвлөгөө өгөхийг хуулийн дагуу хориглосон заалт тусгах жишээтэй. Төгсгөлд нь, олон нийтийн ашиг сонирхол нээлттэй байлгахыг шаардаж байгаа хэрэг дээр хууль ёсны эрх ашигт сөрөг уршигтай байсан ч олон нийтийн эрх ашгийг дээдлэн уг асуудалд ханддаг. Үүнтэй холбоотой жишээ авч үзье. Үндэсний эрх ашигтай холбоотой авлигын хэргийн материалыг нууцалж болох юм. Авлигын хэрэг нь тухайн нэг, богинохон хугацаанд үндэсний эрх ашигт нөлөөлөхөөс илүү ирээдүйд нийгэмд илүү хор хөнөөлтэй байж болох юм. Нууцалсан мэдээлэл бүрийн талаар төрийн байгууллага учир шалтгааныг тайлбарласан мэдэгдэл гаргахыг мэдээллийн шуурхай байдал гэж ойлгож болно.

- *Жишээ*: Эл Сальвадор улсын мэдээлэл авах эрхийн хууль мэдээллийг нууцлан онцгойлж авч үзэх нөхцөлд олон нийтийн эрх ашигт сөрөг нөлөөтэй эсэхийг нягтлан үзэж шийдвэрлэх шаардлагыг тусгасан байдаг.

Мэдээлэл авах тухай хууль тогтоомж, нууцлалын талаарх хууль тогтоомжийн харилцаанаас тусгайлан авч үзэх асуудал үүсдэг. Хэрвээ мэдээлэл авах хуулинд ил тод байдлыг нууцалсан мэдэгдэл бүхий харьцангуй заалтууд тусгагдсан бол үүнийг нууцлалын хуулинд заавал оруулах шаардлагагүй юм. Нууцлалын хуулийг засгийн газраас нэр төдий боловсруулж гаргаагүйг бодолцон, үндэсний олон төрлийн хуулинд нууцлалтай холбоотой тархай бутархай олон заалтууд тусгагдсан байдгийг санаж, хуулийн заалтууд хоорондоо зөрчилдсөн маргаантай хэрэг дээр мэдээлэл авах эрхийн хууль нь нууцлалын хууль тогтоомжоос давуу эрхтэйгээр үйлчлэх нь чухал. Үүнээс илүү чухал нэг зүйл бол нууцлалын жагсаалтанд орсон гэдэг үндэслэл мэдээллийн хуулийг хүчгүйдүүлэх ёсгүй. Энэ нөхцөлд нууцлалын ангилал гэдэг нь жагсаалтыг зохиосон хэн нэгэн хүнд сурталтан ч юмуу эсвэл түүний удирдлагын наасан шошго байдгийг санаж, энэ нь эргээд мэдээлэл авах эрхийн хууль тогтоомжийг үнэ цэнэгүй болгох ёсгүйг бодолцох хэрэгтэй.

- *Жишээ:* Өмнөд Африкийн мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 5 дугаар заалтад “Энэхүү хууль эрх зүйн баримт бичиг нь бусад хууль тогтоомжийн дагуу хориглосон бүх төрлийн заалтууд тухайлбал, а) төрийн байгууллага ба хувь хүнтэй холбоотой мэдээллийг нууцласан заалтуудаас давуу эрхтэйгээр үйлчлэх ба, б) тэдгээр нь энэхүү хууль эрх зүйн баримт бичгийн зорилго, тусгай заалтуудтай нийцэхгүй байна...” гэжээ.

е. *Давж заалдах:* Мэдээлэл авах журамтай холбоотой сүүлчийн гол элемент бол хувь хүнд нээлттэй байхаас татгалзсан аливаа няцаалтын эсрэг давж заалдах явдал юм. Мэдээж, хэн дуртай нь шүүхэд хандах боломжтой ч туршлагаас харахад, эрх зүйн мэргэшсэн байгууллага давж заалдах үнэ өртгийг үнэрхэлгүй, зарга мэдүүлэгчид туслах нь зайлшгүй чухал байдаг. Эрх зүйн мэргэшсэн байгууллага нь мэдээлэл авах эрхийн талаарх онцгойлон үздэг тохиолдол, энэ асуудлаар оршин буй системийн дотор гардаг эмзэг болон маргаантай асуудлыг мэргэжлийн зүгээс тайлбарлаж өгдөг учраас уг байгууллагаас туслалцаа авах нь чухалд тооцогдоно. Мөн засаг захиргааны хяналтын шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг нягтлан тайлбарлах зэргээр тусалж болно.

- *Жишээ:* Олонх оронд мэдээлэл авах эрхийн зөрчил дээр давж заалдах шатанд туслах эрхтэй бие даасан, мэргэжлийн байгууллагууд ажилладаг.
- Төрийн байгууллагууд энэхүү хуулийн хүрээнд мэдээлэл авах журмыг амьдралд бүрэн хэрэгжүүлэхийн төлөө янз бүрийн дэмжсэн арга хэмжээ явуулах хэрэгтэй. Дээрх арга хэмжээ орон бүрт өөр байж болох ч дараах зүйлсийг оруулах нь зүйтэй юм. Үүнд, төрийн албан хаагчдыг сургалтанд хамруулах, мэдээллийн хуулийн талаар олон нийтэд боловсрол олгох, мэдээлэл авах эрхэд санаатайгаар саад

учруулдаг хүмүүст үүрэг ногдуулах, (нөхцөл байдал шаардсан хэрэг дээр заавал мөрдөхийг шаардах) нийгмийн ухамсарын тухай хуулийн дагуу мэдээлэл задруулсан хүмүүс мөн, буруутай үйл ажиллагааны тухай мэдээлэл өгсөн шүгэлдэгчийг хамгаалах, мэдээллийг түгээхтэй холбоотой арга хэмжээний талаар тайлагнах систем, мэдээллийг урамшуулах схем, мэдээлэл хүсэх аргыг хэрхэн мөрдөж байгаа, үүнийг бүх шатны төрийн байгууллагын журамтай хэрхэн уялдуулах зэргийг оруулах шаардлагатай юм.

Журмыг боловсронгуй болгох

- Мэдээлэл авах эрхийн системтэй ажиллахад дагаж мөрдөх журам гол үүрэгтэй. Нэг талаас энэ нь хялбар зүйл мэт боловч зайлшгүй чухал ач холбогдолтой. Дагаж мөрдөх дараах журмыг хуулинд тусгаж өгөх хэрэгтэй.
 - Хүсэлт гаргасан хүмүүс шалтгаан үндэслэлээ тайлбарлах ёсгүй.
 - Хүсэлт гаргасан хүмүүс чирэгдэлгүй хүсэлтээ илгээж болох энгийн тодорхой байдлаар хүсэлтийг хүлээж авах журам тогтоох, хүсэлтээ тодорхой бичиж илгээхтэй холбоотой зарим нэгэн мэдээллээс өөр илүү зүйл хүсэлт гаргагчдаас шаардахгүй байвал зохино. (жишээ нь хүсэлт илгээх газрын хаяг байх)
 - Төрийн албан хаагчид хүсэлт гаргагчид, тухайлбал, өөрөө туслалцаа хүссэн нөхцөлд хүсэлтээ бичихэд туслах, жишээ нь бичиг үсэгт тайлагдаагүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслалцаа үзүүлэх.
 - Хүсэлтийн хариуг ихэнхдээ ажлын 5 хоногт багтаан өгдөг хэвшсэн хугацааны хүрээнд багтаан, хүлээн авсан ба хариу өгөх тодорхой хугацааг мэдэгдэх,
 - Нэг байгууллагад хандан хүсэлт гаргасан үед шаардлагатай мэдээлэл байхгүй бол хүсэлт гаргасан хүнд энэ талаар мэдээлэх, мэдээлэл өгч болох өөр байгууллагад хүсэлтийг шилжүүлэх тохиолдолд хэрхэн зохицуулахыг нарийвчлан заасан журмыг боловсруулах
 - Төрийн байгууллагуудаас иргэдэд мэдээлэлтэй хэрхэн танилцах талаар тухайлбал, (хувилбарыг хүлээн авах, баримт бичигтэй танилцах) (мэдээллийг хамгаалах) бусад хуулийн заалттай уялдуулах үүднээс зааварчилгаа өгөхийг журманд тусгах
 - Төрийн байгууллагуудаас иргэдийн хүсэлтэнд ямар ч тохиолдолд аль болох богино хугацаанд, хэвшсэн хугацааны хүрээнд багтаан (ажлын 20 хоногоос хэтрүүлэлгүй) хариу өгөхийг журманд тусгах. Мөн хариу өгөх хугацааг тусгайлан (ажлын 20 хоногоос хэтрүүлэлгүй) зааж болно.
 - Хүсэлт гаргах үйл явц нь үнэ төлбөргүй, хүссэн мэдээллийг хуулбарласан, илгээсэн зардалд хязгаарлалт тогтоосон (баримт бичгийг шалгасан процесс ба цахим хувилбар илгээсэн үед үнэгүй гэх мэт ялгаатай) мэдээллийн

үйлчилгээний хураамжийн талаар дагаж мөрдөх журмыг боловсруулж мөрдөх

- Төрийн байгууллагаас авсан мэдээллийн оюуны өмчийн эрхийг гуравдахь этгээд (энэ нь төрийн байгууллага биш бол) эзэмшсэн тохиолдлоос бусад үед авсан мэдээллийг дахин ашиглахад үнийн хураамж төлөх, бусад төрлийн хориг саад байх ёсгүй.

Хэлэлцүүлэг: Мэдээлэл авах эрхийн хуульд заасан онцгойлж үзэх нөхцөл нь хүндрэлтэй асуудал. Ямар төрлийн ашиг сонирхлыг онцгойлж үзэх нөхцөлд хамруулан хамгаалах ёстой вэ? Жишээлбэл, хуулийн төсөл, хэлэлцэгдэж буй асуудлыг хэдий нь олон нийтийн сонорт хүргэх ёстой вэ?

Ашигласан материал

1. *Иргэдийн мэдэх эрх: Мэдээллийн эрх чөлөөний хууль тогтоомжийн талаарх зарчмууд* (London: ARTICLE 19, 1999). Цахим хаяг: <http://www.article19.org/pdfs/standards/righttoknow.pdf>
2. Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооноос 2002 оны 2 дугаар сарын 21-нд баталсан албан баримт бичигтэй танилцуулах тухай гишүүн орнуудад хандсан зөвлөмж No. R(2002)2: [http://www.coe.int/t/dghl/standardsetting/media/doc/H-Inf\(2003\)003_en.pdf](http://www.coe.int/t/dghl/standardsetting/media/doc/H-Inf(2003)003_en.pdf)
3. НҮБ-ын Үзэл бодлын илэрхийллийн эрх чөлөөний асуудлаарх Тусгай Илтгэгч ба Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Хэвлэлийн эрх чөлөөний Төлөөлөгч ба Америкийн Муж улсуудын байгууллагын үзэл бодлын эрх чөлөөний асуудлаарх Тусгай Илтгэгчийн 2004 оны 12 сарын 06-нд гаргасан Хамтарсан Тунхаглал. Цахим хаяг: <http://www.unhchr.ch/huricane/hurricane.nsf/0/9A56F80984C8BD5EC1256F6B005C47F0?opendocument>
4. Тоби Мендел, Мэдээллийн эрх чөлөө: *Эрх зүйн харьцуулсан судалгаа* (UNESCO publication; second edition, 2008). Available in various languages at: http://portal.unesco.org/ci/en/ev.php-URL_ID=26159&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html

Модуль 6: Өргөн нэвтрүүлэг ба интернетийн зохицуулалт

- Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл шаарддаг учраас өргөн нэвтрүүлгийн зохицуулах журам сонин хэвлэлээс ялгаатай болохыг бүгд зөвшөөрдөг.
- Хэд хэдэн үндэслэл байдгийг доор дурдваас:
 - Өргөн нэвтрүүлэг нь олон нийтийн оролцоо, агаарын долгионоос хамааралтай нэвтрүүлгээ түгээн цацдаг. Олон нийтийн бололцоог ашиглан нэвтрүүлэг хийдэг тул хянах нь зүй ёсны хэрэг юм.
 - Өргөн нэвтрүүлэг нь маш хүчтэй хэрэгсэл учраас олон нийтэд хор уршиг тарихаас сэргийлэн уг байгууллагын үйл ажиллагааг хянах нь чухал.
 - Өргөн нэвтрүүлэг нь арилжааны томоохон салбар тул энэ салбарт мөнгөний ашиг сонирхол давамгайлахаас урьдчилан сэргийлж хянах ёстой.
- АНУ-ын Дээд шүүх өргөн нэвтрүүлгийн Red Lion ХХК холбоотой Холбооны харилцаа холбооны зохицуулах комиссын 1969 онд гарсан хэрэг дээр тусгай зөвшөөрөл авах шаардлагыг нарийвчлан заасан байдаг.

100 хүн өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл хүсэхэд хэдийгээр тэд бүгдээрээ зөвшөөрөл эзэмших эрхтэй ч 10 долгионы сувагт л зөвшөөрөл олгох боломжтой. Радио долгион ашиглах нь үр дүнтэй харилцааны хэлбэр гэдгийг бүгд мэддэг хэрнээ зөвхөн цөөхөн хүнд тусгай зөвшөөрөл олгож үлдсэн хэсгийг нь долгион ашиглахыг хориглодог. Үзэл бодлын илэрхийллийг баталгаажуулах талаас харилцаа холбооны хэрэгслийг дэмжих зорилготой атлаа засгийн газар хүсэлт гаргасан хүн бүрт өргөн нэвтрүүлгийн болон радио тусгай зөвшөөрөл олгох, мөн долгионы суваг дүүрэхээс сэргийлж тусгай зөвшөөрөлд хатуу хяналт тогтоодог нь хачирхалтай хэрэг юм.

Хэлэлцүүлэг: Өргөн нэвтрүүлгийн энэхүү ухаалаг зохицуулалтын талаар таны бодол? Бусдын тухай бодох ёстой юу? Монголын харилцаа холбооны системд энэхүү ухаалаг зохицуулалт тусгалаа олсон болов уу?

1. Зохицуулах байгууллага

- Тусгай зөвшөөрлийг ямар байгууллагад олгохыг шийдэх хязгааргүй эрхийг эзэмшиж байгаагийн хувьд өргөн нэвтрүүлгийн зохицуулах байгууллагын бие даасан статус маш чухалд тооцогдоно.
- Засгийн газар ба үйлдвэрлэлийн салбарын хүмүүс нөлөөгөө тогтоохын төлөө хоёул өрсөлддөг тул оролцогч тал бүрийн хүчтэй ашиг сонирхлыг зохицуулах нь ярвигтай асуудал юм.
- Өргөн нэвтрүүлгийн салбарын зохицуулах байгууллагын хүлээх үүрэг ба бие даасан байдлын талаар Европын Зөвлөлөөс 2000 онд гаргасан зөвлөмжид энэхүү асуудлыг тусгайлан авч үзэн (COE Recommendation 23) дурдахдаа:

Гишүүн орнууд энэхүү зорилгыг удирдлага болгон боловсруулсан хууль тогтоомжийн хүрээнд өргөн нэвтрүүлгийн салбарын зохицуулах байгууллагыг байгуулж, хүлээх үүргийг баталгаажуулж өгөх хэрэгтэй. Зохицуулах байгууллагыг удирдах дүрэм журам, биелүүлэх үүргийг хуулинд нарийвчлан тусгаж, бие даасан байдлыг бүрэн хангах ёстой.

- Бие даасан байдлыг бэхжүүлэн хангах олон арга байдаг. Үүнд:
 - Хууль тогтоомжид бие даасан байдлыг тусгайлан зааж баталгаажуулах
 - Санхүүгийн эх үүсвэртэй, өөрийн үйл ажиллагааны салбарт албан ёсоор бие даасан, нэр нөлөөтэй байгууллагаар дамжуулан ажиллах
 - Хариуцлагын системийн үндэс суурийг хангах, нөлөөллөөс ангид байлгахын тулд тухайн сонгосон байгууллагад юунд оролцох болон оролцохгүйг зааж эрх бүхий итгэмжлэл олгох
 - Тухайн байгууллагын дүрэм журмаас ангид байхаар бодож ажлаа хэрхэн явуулах тухай нарийвчилсан зааварчилгаа өгөх
 - Томилогдсон гишүүдээр дамжуулан ажиллах
- Гишүүдийн хэрхэн томилох талаар хоёр гол загвар байдаг.
 - Салбараас сонгон томилох, гишүүдийг салбар бүрээс сонгох тухайлбал, эрдэмтэд, хуульчдын холбооны төлөөлөгч гэх мэт. Гишүүдийн хүрээ тэлэх тусам улс төрчид системийг хянах боломжгүй болдог.
 - Баталсан журмын дагуу хамгаалах, янз бүрийн салбарын хүмүүсийг оролцуулан нээлттэй ил тод хэлбэрээр бие даасан байдлыг хянах журам гаргах, үүнд иргэний нийгэм төлөөллөө дэвшүүлж, парламентаас гишүүдийг сонгож, ерөнхийлөгч албан ёсоор батлаж болно. Энэхүү сонгох үйл явц иргэдийн идэвхтэй оролцоотой, нээлттэй явагдана. Жишээ нь, парламент сонгогдсон гишүүдийн жагсаалтыг иргэдийн дунд хэлэлцүүлэхээр нийтэлж болох юм.
- Хуулийн дагуу гишүүнээр томилоход “нийцэхгүй байх дүрэм”-ийг тодорхойлж өгч мөн болох юм. Хамгийн наад зах нь дараах ангилалд хамаарах хүмүүсийг томилох нь эрх ашигт нийцэхгүй. Үүнд: 1) засгийн газарт алба хашиж буй хүмүүс, төрийн албан хаагч, улс төрийн нам, мөн сонгогдсон төлөөлөгчид, 2) өргөн нэвтрүүлгийн болон харилцаа холбооны салбарт хөрөнгө оруулагч нар томилогдох боломжгүй.
- Томилогдсон гишүүдийг ерөнхийдөө халж солихоос сэргийлэх ёстой. Гишүүд нь байнгын орон тоо эзэмших ба тэднийг солих үндэслэлийг тодорхой зааж өгөх нь зохимжтой. Орон тоонд анх томилсон байгууллага халах, солих эрхтэй ба солих асуудлыг шүүхээр хянан шийдвэрлэж болох юм.
 - *Жишээ:* Өмнөд Африкт нэрнээсээ эхлээд бие даасан байдлаа зарласан (ICASA) Өмнөд Африкийн харилцаа холбооны бие даасан байгууллага байдаг ба анх байгуулсан хууль тогтоомж нь уг байгууллагын бие даасан байдлыг нь баталгаажуулж энэхүү байгууллага нь бие даасан, зөвхөн

Үндсэн хууль ба бусад хуулийн өмнө хариуцлага хүлээх хараат бус хэмээн тодорхойлсон байна. Өмнөд Африкийн харилцаа холбооны бие даасан байгууллагын удирдах зөвлөлийг Үндэсний Ассамблейгаас санал болгосны дараа ерөнхийлөгч томилдог. Үүний өмнө а) олон нийтийн дундаас нэр дэвшигчийг шалгаруулах, б) энэ нь ил тод, нээлттэй байх, в) шалгарсан нэр дэвшигчийн нэрсийг нийтлэх үйл ажиллагаа хийгддэг байна. Гишүүдэд Өмнөд Африкийг бүхэлд нь төлөөлөх, анализ хийх болон багаар ажиллах чадвартай, нийгмийн өөдрөг үнэт зүйлсийг дээдэлдэг, үзэл бодлын илэрхийлэлд үнэнч байх зэрэг шаардлага тавина. Улс төрд оролцдог, өргөн нэвтрүүлгийн салбарт ашиг сонирхлын зөрчилтэй хувь хүнийг гишүүнээр томилдоггүй.

- 1995 оноос Нэгдсэн Вант улсад өрсөлдөөний үндсэн дээр олон нийтийн зүгээс өргөн нэвтрүүлгийн байгууллагын гишүүдийг томилох журам үйлчилж эхэлсэн. Дор хаяж, нэг хараат бус шинжээч магадлан итгэмжилсэн, нэр хүнд бүхий хүн олон нийтийн шалгаруулалтанд нэрээ дэвшүүлдэг.
 - Индонези улс 2002 онд баталсан Өргөн нэвтрүүлгийн хуулиндаа бие даасан байдлын зорилго, зорилтыг хангах хэд хэдэн сурвалжийг дурдсан. Өргөн нэвтрүүлгийн зохицуулагч “бие даасан статустай байгууллага” байх ба үндэсний зохицуулах байгууллагын гишүүдийг олон нийт нэр дэвшүүлэх, парламент “нээлттэй зохих ёсны туршилт”-ын үндсэн дээр гишүүдийг сонгох ба ерөнхийлөгч нь албан ёсоор томилдог байна. Гишүүд нь зарчимч байдал, Үндсэн хуулийг дээдэлдэг, зохих туршлагатай, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцдоггүй, эрх зүй, шүүх болон төрийн байгууллагын гишүүн бус байх ёстой. Гишүүд ерөнхийлөгчийн зарлиг, парламентын зөвлөмж, шүүхийн шийдвэрээр хорих ял авсан тохиолдолд ажлаасаа өөрчлөгдөнө. Гишүүд дундаасаа дарга болон дэд даргаа сонгоно.
- Өөр нэг чухал зүйл бол байгууллагын санхүүжилт. Зохицуулагч байгууллага өөрийн төсвийг парламентад өргөн барьж хэлэлцүүлэх нь сайн туршлагад тооцогддог ч тухайн байгууллагад санхүүжилтээ долгион хүсэх зөвшөөрлийн хураамж болон долгион ашигласны жилийн хураамжаас бүрдүүлэх боломжийг олгодог нь нийтлэг зүйл юм.
- Бие даасан байдал нь хариуцлагаас чөлөөлсөн гэсэн үг биш юм. Хариуцлагыг санхүүжилтийн нэгэн адил парламентын хүрээнд авч хэлэлцэх нь сайн туршлагад тооцогдоно. Ихэнх зохицуулагч байгууллага ажлаа дүгнэн жилийн тайлан гаргаж, санхүүгийн ажлаа аудитаар шалгуулдаг. Байгууллагын дүрмийг батлахаас өмнө өргөн хэлэлцүүлэг явуулах зэрэг тухайн байгууллагад хариуцлага тооцох өөр хэлбэрүүд байж болно.

Хэлэлцүүлэг: Монголд бие даасан зохицуулагч байгууллага байгуулах боломжтой гэж та бодож байна уу? Дээр дурдсан хэлбэрүүдээс аль нь илүү зохимжтой ажиллах бол? Эсвэл та өөр процесс шаардлагатай гэж үзэж байна уу?

2. Тусгай зөвшөөрөл олгох процесс

- Өргөн нэвтрүүлгийн зохицуулагч нарт ногдуулсан эрх мэдлийн шалгуур болдог учраас тусгай зөвшөөрөл олгох процесс ил тод, шударга явагдах нь маш чухал.
- Зөвшөөрөл авах мэдүүлгийн журмыг оновчтой, тодорхой байдлаар хуулинд тусгаж өгөх нь зүйтэй. Үүнд наад зах нь дараах элементийг багтаасан байвал зохино.
 - Мэдүүлэг өгсөн өрсөлдөгчдийг сонгон шалгаруулах гол үзүүлэлтийг тусгах
 - Сонгон шалгаруулалтыг зарлахдаа шаардлагатай нарийвчилсан бүх мэдээллийг тодорхой дурдаж, тухайлбал, мэдүүлэг гаргагч ямар хэлбэрээр материалаа бүрдүүлэх, мэдүүлгээ өгөх ёстой товлосон цаг, ямар нэмэлт мэдээлэл хэрэгтэй, техникийн шаардлагууд болон хураамжийн хэмжээг заах
 - Өрсөлдөж буй талууд сонгон шалгаруулалтын дүнг сонсох эрхтэй, мөн олон нийт үүнд саналаа өгөх боломжтой байх
- Зохицуулагч сонгон шалгаруулалтын дүнг мэдүүлэг гаргасан талд бичгээр өгөх ба шийдвэртэй санал нийлэхгүй бол шүүхэд давж заалдах эрх нээлттэй үлдэх ёстой.
- Тусгай зөвшөөрөл хүссэн мэдүүлэгт тусгасан амлалтыг зөвшөөрөл олгосон баримт бичигт дахин тусгах нь олон талт байдлыг сурталчлах гол арга (мэдүүлэг гаргагч амлалтаа биелүүлэхээр чармайх болно) юм.
- Зөвшөөрлийн хураамж боломжийн хэмжээтэй, хураамж төлөх хуваарийг урьдчилан нийтлэх, дур зоргоороо үнэ нэмэх асуудлыг зөвшөөрөхгүй байх ёстой.

3. Олон төрөлт байдлыг дэмжих

- Хэвлэл мэдээлийн салбар олон төрөлтэй байх нь сонсогч олны үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалахаас үүдэлтэй (шинэ санаа, мэдээлэл эрх хайх, хүлээн авах) үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрхийн гол шинж чанар болдог. Ийнхүү төрөл бүрийн мэдээ мэдээлэл, санаа оноог мэдэж сонсох явдал нь өөрөө олон төрөлт байдлын үндэс суурь болдог.
- Хэрвээ хувь хүмүүс олон өнцгөөс таамагласан, олон төрлийн мэдээ мэдээлэл, санал бодлыг хүлээн авах боломжгүй байсан бол нийгмийн амьдралд идэвхтэй оролцохгүй.
- Олон төрөлт байдал нь иргэдэд хүртээмжтэй мэдээ мэдээлэл, санал бодлын олон төрөлт байдлыг бүрдүүлэхийн төлөө төрөл бүрийн арга хэмжээг дэмжих гэсэн эерэг үүргийг улс орнуудад ногдуулдаг. Өргөн нэвтрүүлгийн салбарт зохицуулалт

байхгүйгээр хэвлэл мэдээллийн олон төрөлт байдал жинхэнээсээ бий болохгүй ба хэвлэлийн зохицуулалтыг бүрдүүлэх оролдлого хийх нь үүнд хангалтгүй юм.

Хэлэлцүүлэг: Хэвлэл мэдээлэлд олон ургалч үзэл хэвшүүлэхийг та юу гэж үзэж байна? Энэ нь Төрөөс дэмжих ёстой зүйл мөн үү? Монголд хэвлэлийн олон төрөлт байдлыг тогтоох боломжтой юу?

- Олон ургальч үзэл маш өргөн хүрээнд дэмжлэг хүлээдэг. Жишээлбэл, НҮБ-ын Хүний эрхийн хорооноос мэдэгдэхдээ:

Хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийн (үндэстний болон хэлний цөөнхийн гишүүдийг оролцуулан) эрхийг хамгаалах нь тэдэнд өргөн хүрээтэй мэдээ, мэдээлэл ба санаа оноог хүргэх явдал ба, үүний тулд Гишүүн орнууд бие даасан олон ургальч хэвлэл мэдээллийг хөхиүлэн дэмжихэд онцгой анхаарал тавих ёстой.

- Бүхэлдээ хэвлэл мэдээллийн олон төрөлт байдалд чиглэсэн үзэл бодлын илэрхийллийн асуудлаарх олон улсын дөрвөн тусгай илтгэгчийн Өргөн нэвтрүүлгийн олон төрөлт байдлын талаарх 2007 оны Хамтарсан Тунхаглалд ардчиллын тулгуур, үзэл бодлын эрх чөлөөний чухал шинж болох олон төрөлт байдлын ач холбогдлыг онцгойлон дурдсан.
- Хамтарсан Тунхаглалаар хэвлэл мэдээллийн олон ургальч үзэл ба олон төрөлт байдлын гурван илэрхий шинжийг тодорхойлсон юм.
 - а. *Эх үүсвэр:* Өмчлөлийн олон төрөлт байдал, хэвлэл мэдээллийн өмчлөл хэт төвлөрөх
 - б. *Хэлбэр:* Өргөн нэвтрүүлгийн янз бүрийн төрөл, мэдээллийг олон өнцгөөс хүргэх боломжтой олон нийтийн, арилжааны ба хүйн өргөн нэвтрүүлэг байх
 - с. *Агуулга:* Нийгмийн бүх гишүүдийн ашиг сонирхол ба шаардлагад нийцүүлэн үйлчлэх өргөн хүрээг хамарсан агуулгатай байх

Эх үүсвэрийн олон төрөл

- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өмчлөлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх үүднээс эх үүсвэрийн олон төрөлт байдлыг хангахыг сайтар зохицуулан НҮБ-ын Хүний эрхийн хорооноос ийнхүү мэдэгдэхдээ:

Хорооноос 10 дугаар ерөнхий тайлбарт хийсэн анхааруулгыг дахин давтаж “Орчин үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөгжлөөс үүдэлтэй, хүн бүрийн үзэл бодлын эрх чөлөөний эрхэнд халдаж болзошгүй, иймэрхүү хяналт хэвлэл мэдээлэлд үүсэхээс сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ зайлшгүй хэрэгтэй. Төр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд монополь хяналт тавихгүй, харин хэвлэл мэдээллийн олон ургальч байдлыг хөхиүлэн дэмжих

ёстой. Үүнээс үүдэн, төр иргэний эрхийн Пакттай нийцүүлэн, хэвлэл мэдээлэлд өмчлөлийн төвлөрөл үүсэх, хувийн өмчлөлтэй хэвлэлийн том бүлгүүд монополь эрхтэй ноёрхох нь эх үүсвэрийн олон төрөлт байдалд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зохистой арга хэмжээ авах ёстой.

- Европын Шүүх Италид гарсан Centro Europa 7 S.R.L. ба Di Stefano хэрэг дээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл хэт төвлөрөхтэй холбоотой гол асуудлын нэгийг ийнхүү тодорхойлсон байдаг.

Нөхцөл байдлаас харахад нийгэмд улс төр, эдийн засгийн хүчирхэг нөлөөтэй бүлгүүд дуу, дүрс бичлэгийн зах зээл дээр ноёрхох байр суурийг эзэлснээр өргөн нэвтрүүлэгчдэд дарамт үзүүлж, ялангуяа олон нийтийн ерөнхий ашиг сонирхолд нийцсэн мэдээ, мэдээлэл, санаа оноог дамжуулах, түүнээс гадна олон нийт тэрхүү мэдээллийг хүлээн авах ёстой гэсэн Конвенцийн 10 дугаар заалтад дурдсан ардчилсан нийгэм дэх үзэл бодлын эрх чөлөөний үндсэн үүргийг умартуулж, эцэстээ өргөн нэвтрүүлэгчдийн редакцийн хараат бус байдлыг хязгаарлахад хүрээд байна. Олон нийтийн өргөн нэвтрүүлэг, мөн төр зах зээл дээр ноёрхох байр суурь эзлэхэд энэ байдал ажиглагддаг. Ийм учраас, долгионы суваг олгох бололцоотой газарт олон нийтийн өргөн нэвтрүүлэгчдэд онцгой шаардлага байгааг нотолж чадаагүй нөхцөлд, тусгай зөвшөөрлийн журамд заасанчлан зөвшөөрлийн хоригийг үндэслэн зөвшөөрөл олгохгүй байхыг Шүүхээс тогтоож байна.

- Хэвлэл мэдээллийн олон төрөлт байдал нь өмчлөлийн бүх хэлбэрийг дэмжих ёстой гэсэн дүрмийг өөртөө агуулж байдаг учраас: та бүхэн хоёр, гурваас доошгүй өрсөлдөгчийг шалгаруулах ёстой.
- Нөхцөл байдлаас харахад ихэнх ардчилсан орнуудад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өмчлөл төвлөрөх асуудалд анхаарлаа хандуулан, энэ талаар тусгайлан дүрэм боловсруулж, хэт төвлөрлийн эсрэг ерөнхий дүрмийг мөрддөг.

Жишээ: АНУ-д хэвлэл мэдээллийн салбар доторх хамтран өмчлөл, өмчлөлийн төвлөрлийн талаар нарийвчлан тусгасан тодорхой дүрэм байдаг. Үндэсний хэмжээнд хэвлэл мэдээллийн хэрэгслийн дөрвөн том сүлжээ болох (ABC, CBS, Fox, NBC)-ыг хоорондоо нэгдэхийг хориглосон байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл дангаараа үндэсний хэмжээнд телевиз үзэгчдийн 39%-аас илүүг хамрах боломжгүй. Нэг компани салбартаа хоёр ТВ станц эзэмшиж болох ч энэ нь 1) үйлчилгээний хамрах хүрээ давхцах ёсгүй, 2), хоёр ТВ станцын дор хаяж нэг нь дээр дурдсан дөрвөн ТВ сүлжээнд хамааралгүй байх мөн өмчлөлийн холимог байдлыг санал болгосны дараа зах зээлд бие даасан өмчлөлтэй наад зах нь найман ТВ үлдэх ёстой гэж дүрмэндээ тусгасан байна.

Хэлбэрийн олон төрөлт байдал

- Төрөөс бүх төрөл болох арилжааны, олон нийтийн, хүйн гэсэн өргөн нэвтрүүлгийн гурван төрлийг хөхиүлэн дэмжих ёстой ба эс бөгөөс арилжааны төрөл зах зээл дээр ноёрхох хандлагатай байдаг.
 - Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн газар зүйн хамрах хүрээ өргөн, нэвтрүүлгийн бодлогоо арилжааны бус хэлбэрээр төлөвлөн хүргэдэг байх
 - Хүйн өргөн нэвтрүүлэг нь хувь хүмүүс, хүй олны дуу хоолойг хүргэх тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилготой
- Тусгай зөвшөөрөл авах процесс нь эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөх ёстой ба энэ нь хүйн өргөн нэвтрүүлгийг чадавхжуулах гол түлхүүр юм.
 - *Жишээ:* Канадад, хүйн өргөн нэвтрүүлгийг ийнхүү тодорхойлсон байдаг. Үүнд: “Хүйн радио станц нь хүй олны оролцоотойгоор нэвтрүүлгийн бодлого, үйл ажиллагаа, удирдлага, гишүүнчлэлийн бүтцийг бүрдүүлдэг ашгийн бус байгууллагын өмчлөл, хяналтад байх ёстой. Нэвтрүүлгийн бодлого нь уг станцын тусгай зөвшөөрөлд заасанчлан зах зээлийн олон төрөлт байдлыг харгалзсан байвал зохино.”
- Өргөн нэвтрүүлгийн долгионы сувгийг дээрх байгууллагад нөөцлөх ёстой ба эс бөгөөс арилжааны өргөн нэвтрүүлэг бүх сувгийг эзэгнэх болно.
 - *Жишээ:* Тайландад сувгийн зөвшөөрлийн 40%-ийг төрд, 40%-ийг арилжааны салбарт, 20%-ийг ашгийн бус байгууллагуудад хуваарилсан байдаг.
- Тусгай зөвшөөрөл олгохдоо энгийн, шуурхай процессийг хэвшүүлж мөрдөх
- Хүйн өргөн нэвтрүүлэгт санхүүжилт олгох боломжтой байх

Агуулгын олон төрөлт байдал

- Тусгай зөвшөөрөл олгох процесс нь агуулгын олон төрөлт байдлыг хөхиүлэн дэмжих ёстой.
 - Санал болгож буй өргөн нэвтрүүлгээс олон төрөлт байдлыг хөхиүлэн дэмжихэд хувь нэмэр оруулж байгааг нь тусгай зөвшөөрлийн шалгуураар дүгнэх
 - Зөвшөөрөл хүссэн мэдүүлэгтээ өргөн нэвтрүүлэгч нар хийхээр санал болгож буй нэвтрүүлгийн хуваариа хавсарган ирүүлэхийг шаардах
 - Олон оронд өргөн нэвтрүүлгийн байгууллагууд нэвтрүүлгийн агуулгад тавигдах тодорхой шаардлагыг биелүүлэх ёстой байдаг. (доор дурдсаныг үзнэ үү)

Хэлэлцүүлэг: Таны хүсч байгаа зарим төрлийн нэвтрүүлэг Монголд үйл ажиллагаа явуулж буй сувгуудад үгүйлэгдэх явдал гардаг уу? Зохицуулах механизм хөхиүлэн дэмжих үү?

4. Агуулгын хяналт

- Ардчилсан орнуудад сонин хэвлэлийн салбарт агуулгын хяналтын өөрийн ба хамтарсан зохицуулалт зонхилдог бол өргөн нэвтрүүлгийн салбарт хууль ёсны хяналтын тогтолцоо илүүтэйгээр шаардагдана.

Агуулгын эерэг шаардлагууд

- Ихэнх оронд агуулгын олон төрөлт байдлыг хөхиүлэн дэмжих, олон нийт төрөл бүрийн хүрээний нэвтрүүлэг хүлээн авах ёстой гэсэн бодлогын дагуу өргөн нэвтрүүлгийн байгууллагад эерэг үүрэг ногдуулдаг. Энэхүү эерэг өнгө аястай үүргийн жишээнээс дурдвал:
 - а. *Үндэсний болон орон нутгийн квоть*: Үндэстний онцлогийг дэмжих, үндэсний нэвтрүүлгийн хөгжилд түлхэц болох үүднээс өргөн нэвтрүүлгийн салбарт тухайн үндэстний дуу хоолойг тусган харуулах нь чухал байдаг, (мөн гадаадын нэвтрүүлэг худалдан авахаас өртгийн хувьд хямд тусдаг).
 - *Жишээ нь*: Өмнөд Африкт, телевизийн нэвтрүүлгийн наад зах нь 35%, радиогийн нэвтрүүлгийн 20% нь тус улсынх байхыг шаарддаг. Малайзид телевиз, радио адилхан нэвтрүүлгийн 60% нь тухайн үндэснийх байхаар заасан. Европт телевизийн нэвтрүүлгийн 50% нь Европынх байх ёстой.
 - б. *Уран бүтээлийн бие даасан үйлдвэрлэл*. Бие даасан чөлөөт уран бүтээлчид өргөн нэвтрүүлгийн салбартай холбоогүй ажилладаг. Энэ нь агаарын долгионоор төрөл бүрийн дуу хоолой хүлээн авах бололцоо олгон, мөн авьяаслаг, ирээдүйтэй уран бүтээлчид төрөн гарахыг (олон төрөлт байдлын хувьд ашигтай) дэмждэг. Нөгөө талаасаа, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл хэт төвлөрөх сөрөг үр дагаврыг бууруулахад тусална.
 - *Жишээ нь*: Англид үндэсний хэмжээний бүх чөлөөт суваг нэвтрүүлгийн цагийнхаа дор хаяж 25%-ийг бие даасан чөлөөт уран бүтээлчдэд нөөцлөх ёстой байдаг ба 2009 онд нэвтрүүлгийн оргил цагийн 50%-ийг тэдний уран бүтээл эзэлсэн байна.
 - в. *Орон нутгийн нэвтрүүлэг* Томоохон газар нутагтай улсуудын хувьд үзэгч олонд орон нутгийн мэдээ мэдээлэл, бусад нэвтрүүлгийг үндэсний хэмжээний үйл явдалтай харьцуулан жиших үүднээс орон нутгаас бэлтгэсэн нэвтрүүлгийг дэмждэг.
 - *Жишээ*: Англид орон нутгийн радио станц өдөрт долоон цагийн орон нутгийн агуулгатай нэвтрүүлэг явуулах, орон нутгийн мэдээний тойм тогтмол явуулах ёстой.

Үйл ажиллагаанд мөрдөх зарчмууд

- Ихэнх ардчилсан орнуудад өргөдөл гомдлын системийн үндсэн дээр үүсдэг нэвтрүүлэгтэй холбоотой төрөл бүрийн асуудлыг шийдэхийн тулд өргөн нэвтрүүлгийн байгууллагаас үйл ажиллагаандаа мөрдөх ёстой зарчмын хэм хэмжээг сахихыг шаарддаг.
- Энэхүү систем нь ихэнхдээ хамтарсан зохицуулалттай буюу хууль ёсны зохицуулагчтай байдаг.
 - *Жишээ:* Хамтарсан зохицуулалтын жишээ Өмнөд Африкт байх ба хууль ёсны зохицуулагч (ICASA) Өмнөд Африкийн харилцаа холбооны бие даасан байгууллага өргөн нэвтрүүлгийн салбарыг зохицуулах мөртөө бусад зохицуулах байгууллагыг хүлээн зөвшөөрдөг. Аж үйлдвэрийн салбарынхны байгуулсан Өмнөд Африкийн Өргөн нэвтрүүлгийн Өргөдлийн хороо (BCCSA)-ноос нэвтрүүлгийн агуулгыг зохицуулахыг зөвшөөрдөг.
 - *Жишээ:* Франц улс Дуу, дүрс бичлэгийн хяналтын зөвлөлийн удирдлага дор ажилладаг ба хууль ёсны зохицуулах системтэй (CSA) хэрнээ хууль ёсны бие даасан байгууллага (Бие даасан засаг захиргааны эрх бүхий байгууллага)-ын хяналтыг зөвшөөрдөг.

5. Интернетийн зохицуулалт

- Үзэл бодлын эрх чөлөөний эрх нь харилцаа холбооны бусад хэрэгслийн нэгэн адил интернетэд ч мөн хамаарна.
- Хэвлэл мэдээлийн энэ шинэ хэрэгсэлтэй хэрхэн яаж харилцах тухай олон орны Засгийн газрууд асуудаг.
- Интернетийг нийгэмд сөрөг нөлөөтэй, хууль бус зүйлсийг тараах тухайлбал, хүүхдийг садар самуунд уруу татсан зэрэгт ашиглаж болохгүй нь ойлгомжтой. Сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийн байгууллагад ашигладаг дүрэм журмыг интернетэд хэрэглэх нь үр дүн муутай байдаг.
- Өнөөгийн нөхцөлд интернет анхаарлын төвд байгаа ба интернет хэрэглэх эрх нь шинээр урган гарч буй асуудал болно.

Хэлэлцүүлэг: Интернетийг та үзэл бодлоо илэрхийлэх хэрэгсэл гэж үзэж байна уу? Энэ нь эерэг сөрөг олон асуудал дагуулж байгаа гэж боддог уу? Бид интернетэд хатуу чанга хяналт тавих ёстой юу?

Бүтцийн зохицуулалт

- Интернет харилцаа холбооны бусад хэлбэртэй харьцуулахад үнэхээр өргөн олныг хамарч чаддаг.

- Бүх нийтэд зориулсан интернетийг зохицуулах шаардлага үнэхээр бий. Домэйн нэр буюу өмчлөлийн нэр (TLD) нэр байршуулах, (улсын код, ерөнхий код (com.org.mn гэх мэт) дугаарлалтын эх үндэс, интернет ажиллуулах техникийн дүрэм зааврыг зохицуулж болно.
- Өгөгдөл нэр ба дугаарын Интернет нэгдэл (ICANN) хэмээх ашгийн бус байгууллагын ихэнх нь Калифорнид үйл ажиллагаа явуулдаг. Энэ талаар олон удаагийн хэлэлцүүлэг, тухайлбал, Интернет засаглалын форум (IGF), засгийн газрууд, иргэний нийгмийн байгууллагууд, бизнес форум зэргээс зохион байгуулсан Мэдээллийн нийгмийн үйл явцын тухай НҮБ-ын Дэлхийн дээд хэмжээний уулзалт (WSIS) яригдсан билээ.
- Нэг оронд байршдаг ашгийн бус байгууллага мэдээллийн чухал эх сурвалж болсон Интернетийг ажиллуулах нь зүйд нийцэж байгаа эсэх, үүнийг НҮБ-ын хяналтанд тухайлбал, Олон улсын харилцаа холбооны (ITU) мэдэлд шилжүүлэх нь зүйтэй эсэх талаар олон удаагийн хэлэлцүүлэг явагдаж байсан билээ. Эдгээрийн ихэнх нь НҮБ үзэл бодлын эрх чөлөөний талаар анхаардагийн хувьд интернетийг хянах нь зүйтэй гэсэн ойлголтын хүрээнд явагдсан юм.

Хэлэлцүүлэг: Энэ асуудлаар та ямар бодолтой байна? Интернетийг ардчилсан зарчмын дагуу удирдах хэрэгцээ ба мэдээллийн гол эх сурвалж болсон Интернетийг ардчилсан бус орнуудаас үзүүлэх хөндлөнгийн оролцооноос хамгаалах шаардлагын тэнцвэрийг хэрхэн барих вэ?

- Сүлжээний төвийг сахисан байдал ба интернетэд нэг чиглэлийн мэдээлэл дүүрэх гэдэг нь хоёулаа үндэсний болон олон улсын хэмжээнд нөлөөтэй. Интернетийн эрх чөлөө нь сүлжээнд төвийг сахих байр суурийг дэмжих хандлагатай байгаа. 2011 онд гаргасан тусгай илтгэгчийн Тунхаглалд дурдахдаа:

Арга хэрэгсэл, агуулга, зохиогч, гарал үүсэл ба агуулгын зориулалт, үйлчилгээ, програм хангамж зэргийн үндэслэн интернэтэд байршуулсан тоо баримт, мэдээлэлтэй харилцахдаа ялгаварлан гадуурхах байдлаар хандаж болохгүй.
- Хэрэг болон даамжираагүй болохоос аль хэдийнээ техникийн шаардлагын дагуу Интернетийн гүйцэтгэх үүргийг удирдан чиглүүлж зарим төрлийн мэдээллийг эрэмбэлэх болсон билээ.
- Интернетийн үйлчилгээ эрхлэгчид төрөл бүрийн үнэтэй, төрөл төрлийн үйлчилгээг санал болгодог. Хэн илүү мөнгө төлсөн нь интернетэд илүү давуу эрхтэй үйлчлүүлдэг. Интернетийн үйлчилгээ үзүүлэгч олон компани илүү хурдтай, илүү мэдээлэлтэй сүлжээнд холбогдсоны төлөө төлбөр нэхэх болсон.
- 2011 онд гаргасан Тусгай илтгэгчийн Тунхаглалд дурдахдаа:

Интернет зуучлагчдаас өөрсдийн ашигладаг хэрэглээний мэдээлэл болон байршаагүй мэдээллийн талаар ил тод мэдэгдэх, иймэрхүү тохиолдол гарсан

үед холбоотой мэдээллийг бүх оролцогч талд хүлээн авах боломжтой хэлбэрээр мэдэгдэхийг шаардах ёстой.

Хэлэлцүүлэг: Интернетэд бүтэцтэй холбоотой зарим төрлийн зохицуулалт хэрэгтэй гэж та үзэж байна уу? Ямар зорилгоор хэрэглэх ёстой вэ? Энэ яаж нөлөөлөх бол?

Үндэсний зохицуулалт

Домэйн нэр

- Улс бүр өөрийн улсын код бүхий өмчлөлийн нэр буюу домэйн нэр (ccTLD) Монголын хувьд mn. гэсэн нэр ашигладаг. Сайн туршлагаас харахад, энэхүү үүргийг засгийн газраас хараат бус, ашгийн бус байгууллага гүйцэтгэх нь бий. Гэсэн ч өөрийн улсдаа домэйн нэр (ccTLD) авахад төвөг чирэгдэлтэй учирсан хэн ч болов олон улсын домэйн нэр тухайлбал, com, org зэргийг худалдаж авч болдог.

Бүтцийн бусад зохицуулалт

- Олон оронд өргөн нэвтрүүлэг болон сонин хэвлэлийн нэгэн адил интернетийг зохицуулах зорилгоор интернет үйлчилгээ үзүүлэхийн тулд тусгай зөвшөөрөл авах, бүртгэл хийлгэх зэргийг санал болгох болсон. Энд урган гарч буй нэг асуудал нь Интернет хэвшиж тогтсон аль ч загварт таардаггүй. Хэвлэл мэдээллийн бусад хэрэгсэлд хэрэглэдэг бүтцийн зохицуулалт Интернетэд огт тохирохгүй болохыг бүгд хүлээн зөвшөөрдөг. Өмнө дурдсан 2011 онд гаргасан Тусгай илтгэгчийн Тунхаглалд тэмдэглэсэнээр:
 - Өргөн нэвтрүүлэг ба утсан харилцаа зэрэг харилцаа холбооны бусад хэрэгсэлд зориулан боловсруулсан зохицуулалтын хандлагыг Интернетэд шууд хуулбарлан ашиглах нь тохиромжгүй тул үүнд тусгайлан зориулж загвар гаргах шаардлага байна.
- Мөн интернет үйлчилгээ эрхлэгчдээс бүртгүүлэх, тусгай зөвшөөрөл авах зэргийг шаардсан тусгай зохицуулалт нь өөрөө хууль бус болохыг хүлээн зөвшөөрдөг. Ардчилсан орнуудад интернетээр дамжуулан материал тараах, жишээлбэл цахим хуудсанд мэдээлэл байршуулах нь тусгайлсан зохицуулалт шаардах зүйл биш.

2. Агуулгын асуудлууд

- Ер нь хүмүүст маш чухал шаардлагатай учраас томоохон хэмжээний зөрчил гарсан тохиолдолд ч интернетийг бүхэлд нь явдал хууль бус ажиллагаа болно. 2011 онд гаргасан Тусгай илтгэгчийн Тунхаглалд дурдахдаа:

Хүмүүсийн хүсэл санаачлага эсвэл аюулгүй байлын үүднээс нийт хүн ам эс бөгөөс хэсэг бүлэг хүмүүст интернетэд бүхэлд нь эсвэл хэсэгчилсэн байдлаар хандалтыг хаах (интернетиийг унтраах) нь хэзээ ч зөвтгөж болохгүй үйлдэл юм.

Хууль эрх зүйн асуудлууд

- Интернетэд хаанаас ч хамаагүй материал нийтэлж, үүнийг дурын газраасаа үзэж болдог учраас хууль эрх зүйн хүндрэлтэй асуудлыг байнга дагуулдаг. Эрүүгийн хэрэг дээр хууль эрх зүйн талаас нь ямар улсын иргэн хэрэгт буруутгагдсан, хэрэг хаана гарсан гэдгийг үндэслэх хандлага байдаг. Иргэний хэрэг дээр, тухайлбал, нэр төр гутаасан үйлдэлд эдгээр бүх техникийн шаардлага зарга мэдүүлэгчийн таньдаг, мэдэгдлийг уншсан, сонссон бүх хүмүүст хамааралтай болно. Хувь хүмүүс хаана ч шүүхэд дуудагдаж болох тул энэ нь өөрөө маш ярвигтай асуудал юм.
 - *Жишээ:* Англи, Австрали зэрэг орны шүүх хууль эрх зүйн холбоос хичнээн сул байсан ч нэр төр гутаахтай холбоотой хэргийг авч хэлэлцэхийг зөвшөөрсөн. Нью-Йоркод амьдардаг зохиолч Рэчл Эхрэнфелд “Чөтгөрийг хайх нь: Терроризмыг хэн санхүүжүүлдэг ба үүнийг хэрхэн зогсоох нь” номноос болж хэдийгээр уг ном тэр оронд 23 ширхэг зарагдсан байсан ч Саудын Арабын баян бизнесмен Шейх Халид бин Махфоузын нэхэмжлэлийн дагуу Английн шүүхээр доромжилсон хэрэгт буруутгагдсан. Бин Махфоуз анхан шатны шүүх дээр ялж, зохиолч түүнээс уучлалт гуйх, номоо устгах, нөхөн төлбөр түүнд төлөх тухай шүүхийн шийдвэр хүлээн авсан.
- Хууль эрх зүйн хувьд үнэхээр холбоотой байхыг шаардах нь сайн туршлагад тооцогддог. Тусгай илтгэлд дурдсанаар:

Интернеттэй холбоотой агуулга бүхий шүүхэд ирсэн хэрэг нь хууль эрх зүйн талаасаа төрийн нэр хүндтэй үнэхээр холбоотой, энэ нь зохиогч зохиож бичсэн, тухайн цахим хуудсанд байршуулсан, нийтлэлийн агуулга төрийн эсрэг чиглэсэн байж болох юм. Хувь хүний хувьд зөвхөн хэргийг хууль эрх зүйн хүрээнд хэлэлцүүлэхээр авчирч өгөн, тухайн хүнд ямар тодорхой хор хөнөөл учирсныг хууль эрх зүйн талаас нь тодорхойлуулах боломж олгогддог.

Зуучлалын хариуцлага

- Хэвшиж тогтсон хуулийг удирдлага болговоос, мэдэгдэл түгээхэд оролцсон хүн бүхэн тодорхой хэмжээгээр хариуцлага хүлээдэг. Зарим оронд гэм хоргүй нийтлэлийг өмгөөлөхийг хүлээн зөвшөөрдөг, гэхдээ нэр төр гутаасан агуулгагүй мэдэгдлийг санамсаргүй түгээсэн бол хариуцлагаас чөлөөлнө.

- Интернет үйлчилгээ эрхлэгчдийг хамгаалахаар тусгай дүрэм гаргасан орнууд байдаг. Европын Холбоонд хууль бус үйл ажиллагаа явуулдаггүй, мэдээллийг шуурхай устгадаггүй интернет үйлчилгээ эрхлэгчдийг агуулгын эзний хувьд хуулиар хамгаалагддаг. Үүнийг “мэдээлэл ба түүнийг арилгах” заалтын хүрээнд хийнэ. Ихэнх тохиолдолд байршуулсан мэдээлэл хууль бус байхаас хамааралгүй зарим материалыг шууд устгадаг нь асуудал үүсгэдэг. Интернет үйлчилгээ эрхлэгчдийн халдашгүй байдлыг баталгаажуулах нь дээр санагддаг.
 - *Жишээ:* АНУ-ын 1996 оны Харилцаа холбооны эрх зүйн баримт бичигт (нийтлэг нэрлэж заншсанаар Харилцаа холбооны ёс зүйн журмын акт) үйлчилгээ эрхлэгч, хэрэглэгч аль алиныг нь хамгаалсан тодорхой заалт бий. “Харилцан үйлдлийн компьютерын үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгч нар нь бусдын дамжуулсан мэдээллийн төлөө нийтлэгч эс бөгөөс илтгэгч хариуцлага хүлээдэггүйн адил ямарваа нэгэн хариуцлага хүлээхгүй.

Хаах ба шүүлтүүр хэрэглэх

- Тодорхой нэгэн цахим хуудасны үйл ажиллагааг зогсоохыг хаах гэж нэрлэнэ. Энэ нь сонины хэвлэлтийг зогсоохтой яг адил үйлдэл ба зөвхөн шүүхийн шийдвэр гарсан үед юмуу маш цөөн тохиолдолд хэрэглэнэ.
- Агуулгын утгыг шүүхдээ тодорхой үг хэллэгийг бусад орлуулагч (зураг) ашиглан “зохимжгүй” агуулгатай нийтлэхийг хянан тохиолдуулдаг. Энэ нь ихэнхдээ хасах ёстой үг хэллэгээс илүүтэй мэдээллийн утгыг алдагдуулдаг хэлбэр төдий шүүлт юм. Олон улсын хуулийн хэм хэмжээний дагуу төрөөс эрх авсан агуулгад шүүлтүүр хэрэглэх нь хууль бус гэж тооцогддог.

Хэлэлцүүлэг: Төр интернетийн агуулгыг хянах гэдэг нь бараг л боломжгүй зүйл. Харин бид өөрсдийн үр хүүхэд болон бусад хүмүүсийг интернетэд байршсан сөрөг мэдээллээс хэрхэн хамгаалах вэ? Энэ талын боловсрол олгох нь хангалттай юу?

3. Хүртээмж

- Интернет хүмүүст зөвхөн өөрийгөө илэрхийлэхээс гадна нийгмийн бусад харилцаанд (худалдаа хийх, хүмүүстэй танилцах, соёл, боловсрол, улс төрийн хэлэлцүүлэгт оролцох) орох зайлшгүй хэрэгцээг бүрдүүлж өгдөг болсоор байна. Хөгжингүй орнуудад хүн амын 73.8 хувь нь интернетийг бүх талаар хэрэглэдэг бол хөгжиж буй орнуудад иргэдийн зөвхөн 26.3% нь хэрэглэдэг гэсэн асар их зөрүүтэй тоо байдаг. Интернетийн ач холбогдол нь түүнд нэвтрэх боломж бол хүний эрх гэж хэлэхэд хүргэж байна. 2011 онд гаргасан Тусгай илтгэгчийн Тунхаглалд дурдахдаа:
 - Үзэл бодлын эрх чөлөөний эрхийг хангахын тулд улс орнууд иргэддээ Интернетэд чөлөөтэй нэвтрэх боломжийг олгох үүрэг ногдуулж байна. Интернетэд чөлөөтэй нэвтрэх нь иргэн хүний боловсрол эзэмших, эрүүл мэндээ хамгаалуулах, ажил хөдөлмөр эрхлэх, эвлэлдэн нэгдэх, чуулах, чөлөөт

сонгуульд оролцох зэрэг хүний бусад олон эрхийг хөхиүлэн дэмжихэд зайлшгүй хэрэгцээтэй болсон байна.

Хэлэлцүүлэг: Энэ саналын талаарх таны бодол? Үүнд амьдралд хэрэгцээтэй санаа байна уу? Байгаа бол түүнийг яаж хийх вэ?

Ашигласан материал

1. Eve Salomon, Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын талаарх удирдамж (2006, UNESCO and CBA). Цахим хаяг: http://portal.unesco.org/pv_obj_cache/pv_obj_id_6A9EA94E1FCDD576F2C14582745E5AE678120600/filename/Guidelines+for+Broadcasting+Regulation.pdf.
2. 19 ЗҮЙЛ, Агаарын долгионд нэвтрэх боломж : Үзэл бодлын эрх чөлөөний зарчмууд ба Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт (2002). Цахим хаяг: <http://www.article19.org/data/files/pdfs/standards/accessairwaves.pdf>
3. Toby Mendel, Steve Buckley, Kreszentia Duer and Sean O'Siochru, Өргөн нэвтрүүлэг, Дуу хоолой ба хариуцлага: Бодлого, хууль, зохицуулалтад нөлөөлөх олон нийтийн сонирхол (2008, Ann Arbor, University of Michigan Press)
4. Эрх зүй ба Ардчилал төв, Дэлхий дахинаа түгсэн цахим хуудас: Хүний эрхийн хөгжлийн үүднээс интернетэд нэвтрэх нь (2012). Цахим хаяг: <http://www.law-democracy.org/wp-content/uploads/2012/04/final-Internet.pdf>.
5. Үзэл бодлын илэрхийллийн талаарх олон улсын Тусгай илтгэгчдийн Хамтарсан Тунхаглал 2011, цахим хаяг: <http://www.osce.org/fom/66176>.
6. Европын Зөвлөл, Харилцаа холбооны эрх чөлөө ба интернетийн тухай Тунхаглал, 7 дугаар зарчим (2003). Цахим хаяг: http://www.coe.int/t/information/society/documents/Freedom%20of%20communication%20on%20the%20Internet_en.pdf.